



Шашны хэрэг эрхлэх газар - 2656
Залуучуудын Ном- 86

Ерөнхий зохицуулагч:
Профессор.Др Хурие Марты

Хэвлэлийг Хариуцсан Эрхлэгч:
Жафер Таяар ДОЯМАЗ

Хэвлэлийн Зохион Байгуулагч:
Фатих КАРАЗЭЙБЕК

Редактор
Фатих КУРТ

Бэлтгэсэн
Айшэ Нур Өзкан
Доктор Равза Жихан
Доктор Нурхаяат Харал Ялчы
Доктор Туба Дуру
Есра Баш
Имран Элагөз Ташкын

Монгол хэлнээ хөрвүүлсэн:
Жумагүль КУЛАЙХАН

Зохиолыг хянан шалгах комиссын шийдвэр:
03/10/2024 - 103
2024-06-Y-0003-2656
ISBN 978-625-435-842-5
Гэрчилгээний дугаар: 46325

Дизайн
Эмрэ Елдыз

Хяналт ба Хэвлэл
Зейнеп Онар

Хэвлэлийг Бэлтгэсэн
Мехмет КАЯАБАШЫ

Хэвлэл
TDV Yay. Mat. Tic. İsl.
Tel: +90 312 354 91 31

1. Хэвлэл Анкара, 2024

© Туркийн Шашны Хэрэг Эрхлэх Газар


Шашны Хэвлэлийн Ерөнхий Газар
Гадаад Хэл ба бусад Аялагууд
Хэвлэл мэдээллийн хэлтэс
Юнивэрситэлээр гудамж Думлуфынар өргөн чөлөө
No 147/A 06800 Чанкаяа/АНКАРА/ТУРК УЛС
Утас: +90 (312) 295 72 81
Факс: +90 (312) 284 72 88
Имэйл: yabancidiller@diyanet.gov.tr



Бүгд Найрамдах Турк Улс Ерөнхийлөгчийн Тамгын
Газар Турк Улсын Шашны Хэрэг Эрхлэх Газар

Асуулт ба хариултын хамтаар

**Би яагаад
ИТГЭДЭГ
ВЭ?**



АГУУЛГА

АЛЛАХАД ИТГЭХ ИТГЭЛ, 9

**МЕЛЕК БУЮУ ТЭНГЭРИЙН
ЭЛЧ НАРТ ИТГЭХ ИТГЭЛ, 53**


**ТЭНГЭРЛЭГ СУДРУУДАД
ИТГЭХ ИТГЭЛ, 77**

**ГЭГЭЭН ЭЛЧ НАРТ
ИТГЭХ ИТГЭЛ, 109**

**АХИРЕТ ЕРТӨНЦӨД
ИТГЭХ ИТГЭЛ, 137**

**КАДЭР БА КАЗАД
ИТГЭХ ИТГЭЛ, 171**

**ШАШНААС ГАРГАХАД
ХҮРГЭДЭГ ҮГС, 195**



ӨМНӨХ ҮГ

Мэдэх хүсэл нь, үүний зэрэгцээ судалгаа болон асуулт асуухыг шаарддаг. Мэдлэггүй байдлаа нөхөхийн тулд сонирхсон сэдвийн тухай асуулт асуусан хүн, сурах эрмэлзлийн хамгийн чухал аргуудын нэгийг олсон болно. Асуулт асуухдаа анхаарах хамгийн гол зүйл нь асуултаа зөв хүмүүст чиглүүлэх юм. Тухайн сэдвийн талаар буруу, дутуу мэдээллээс зайлсхийхийн тулд мэргэжлийн хүмүүстэй зөвлөлдөх нь үнэнийг мэдэх хамгийн зөв зам байх болно. Чухамдаа, Аллаха эзэн, *"Хэрэв чи мэдэхгүй бол мэргэн ухааны эздээс нь асуугтун"*¹ гэх айлдвараар үзэл бодлоо илэрхийлэхийн өмнө, асуултыг мэргэжлийн хүмүүсээс асуух нь чухал ач холбогдолтой болохыг харуулж байгаа болно.

Мэдээлэл, харилцаа холбооны эрин зуунд мэдээлэл олж авахад хялбар, гэхдээ үнэн зөв мэдээлэлд хүрэхэд хэцүү болсон билээ. Ялангуяа итгэл үнэмшлийн талаарх ташаа мэдээлэл залуучуудын оюун ухаанд сөргөөр нөлөөлж байгаа учраас үнэн худал мэдээллийг ялгахын тулд бэрхшээлтэй тулгарч байгаа билээ. Энэ байдал нь тэднийг буруу зам руу амархан орох шалтгаан болж байгаа. Залуучуудын Исламын Үндэс суурийг бүрдүүлдэг итгэл үнэмшлийн талаарх жинхэнэ мэдлэгт хүрэх нь нийгмийн үнэт зүйлсийг нэмэгдүүлнэ.

.....
1 Нахыл, 16/43.

ЗАЛУУЧУУДЫН ИТГЭЛ СҮСЭГ БИШРЭЛИЙН АСУУЛТУУД


Исламын мөн чанаруудын оршин тогтнох ба амьдруулж буй залуучуудад асар их үүрэг даалгавар хүлээлгэсэн бидний хайрт Элч Сүсэг бишрэлийн сэдвээс Үл үзэгдэх ертөнц хүртэл, мөргөлөөс эхлээд, өдөр тутмын амьдрал хүртэлх бүх сэдвүүдийн талаарх асуултууд тавигдсан байдаг. Ялангуяа залуу үеийнхэнд Гэгээн Элчийн өгсөн хариултууд тэдний амьдралд нь зөв чиглэл болж өгсөн юм.

Таны гарт буй энэ бүтээл нь манай залуу ахан дүүсийн маань Шашны хэрэг эрхлэх газрын зөвлөлийн холбоонд чиглүүлсэн асуултууд болон Төлбөрт Оюутны Дотуур байрны Холбоонд байрладаг оюутан залуучуудад тулгамдсан асуултууд дээр үндэслэгдэн таньд хүрч байгаа болно. "Би итгэх ёстой юу?, Дейзм гэж юу вэ?, Хувь заяа өөрчлөгдөх үү?" гэх мэт асуултууд залуучуудын оюун санааг зовоож буй эдгээр асуултуудад үнэн бодит мэдээлэл хүргэх үүднээс хариулав.

Редактор: Шашны хэвлэлүүдийн ерөнхий менежер болох Доктор. Фатих Курт. Бүтээлийн текстүүдийг Айшенур Озкан, Доктор. Равза Жихан, Доктор. Нурхаят Харал Ялчи, Доктор. Туба Дуру, Эсра Баш болон Имран Элагөз Ташкин нар бэлтгэсэн. Уг бүтээлийг бүтээхэд манай Байгууллагын төрөл бүрийн түвшинд ажилладаг ажилчдын хамт олноос дэмжлэг авсан ба мөн шашны асуудал хариуцсан мэргэжилтнүүд болох Элиф Эрдэм, Халэ Шахин нар оролцсон болно.

Нийт уншигчдадаа, тэр дундаа залуу дүү нарын оюун санаанд байгаа асуултуудын хариултыг олоход нь сайн сайхныг хүсэн ерөөж хувь нэмрээ оруулсан бүх хүмүүст талархал илэрхийлье.

Аллахад
ИТГЭХ
ИТГЭЛ



Би итгэх ёстой юу ?

Бүх хүн төрөлхтөн цэвэр ариун, нүгэлгүй, хөгжил ба төлөвшилд нээлттэй бүтээгдсэн. Хүний мөн чанарт Алладын оршин тогтнол ба цор ганц байдлыг хүлээн зөвшөөрөх хандлага байдаг юм. Энэ чиг хандлага чин сэтгэлийн эрэл хайгуулаар гарч ирдэг. Тохиромжтой орчинд амьдрах нь үүнийг илүү хялбар болгодог. Итгэж үнэмшсэн хүн, юуны түрүүнд Аллах болон, өөрийнхөө хэрхэн бүтээгдсэн талаар, амьдрал мөн үхлийн талаарх үндсэн асуултуудын хариултыг олдог. Мөн хүнд сэтгэл зүйн хувьд итгэх шаардлагатай байдаг.

Шашин, хүмүүсийг өөрсдийн хүслээр зөв зүйтэйд, үзэсгэлэн ба сайн сайханд хүргэдэг бурханлаг хууль гэж тодорхойлогддог. Үүн дээр хамгийн чухал асуудал бол хүмүүсийн дарамт шахалтгүйгээр өөрсдийн чөлөөт хүслээр сонгон шашныг хүлээн зөвшөөрөх явдал юм. Аллах эзэн маань *"Шашинд (Исламд) албадлага үгүй"*¹ гэх айлдвараар Ислам шашны уриалгыг, дагах эсвэл биелүүлэхгүй байх тухай хүн бүрийн өөрсдийн эрх чөлөөтэй хүсэл зорилгодоо эзэн гэдгийг мэдээлсэн байдаг.

.....
1 Бакара, 2/256.

Түүхэн үйл явцыг харахад шашин ба ухамсрын эрх чөлөө, хүний эрхийн дунд өөртөө нэлээд хожуу байр сууриа олж чадсан. Итгэл үнэмшлийн хувьд хэнийг ч шахаж итгүүлж болохгүйтэй адил итгэдэг хүмүүст ч гэсэн өөрсдийн итгэл үнэмшлээр чөлөөтэй амьдрах боломжийг олгосон. Хэт туйлширч шашны тухай хүмүүст дарамт шахалт үзүүлэх нь Алладын зөвшөөрөөгүй нэгэн үйлдэл юм. Куран Сударт; *"Аяа, Мухаммед! Хэрэв Эзэнтэн чинь хүссэн бол, дэлхий дээрх бүх хүмүүс сүсэглэх байсан. Байдал ийн байхад, чи хүмүүсийг албадан сүсэглүүлэх гэж үү?"*² хэмээн айлдсан. Тэгээд ч албадлагаар итгэл үнэмшил нь хүнийг сүсэглэгч мумин бус хоёр нүүртэн болгодог.

Хүчирхэг нэгэнд итгэдэг хүн, түүнд итгэж ойр байх ба өөрийгөө ганцаар мэт санагдахгүй. Түүнд тулгарсан асуудлуудыг шийдвэрлэх явцдаа тэрээр Эзэнтнийхээ тусламж дэмжлэгийг олдог. Тиймээс итгэл үнэмшил бол хүн төрөлхтний хувьд чухал хэрэгцээ гэдгийг хэлэх хэрэгтэй.³

Итгэх, мэдэх хоёр нь адилхан уу ?

Итгэл гэдэг бол аливаа зүйлийг сэтгэлийн амар амгалангаар өөрийн болгож, түүнд чин сэтгэлээсээ ба зүрхнээсээ итгэх явдал юм. Исламын хэлснээр итгэл бол Гэгээн Элчийн Аллахаас авчирсан үнэнийг хүлээн зөвшөөрч, тэдэнд чин сэтгэлээсээ итгэхийг хэлнэ. Ийм сүсэг бишрэлтэй хэн нэгнийг итгэгч буюу "мумин" гэж хэлнэ, харин итгэл үнэмшлийнхээ шаардлагыг бүрэн дагаж биелүүлдэг хүнийг

2 Юнус, 10/99.

3 Бекир Топалоглу, "Дин", ДИА, хавтас. 9, х. 322-325.

сүсэглэгч "мусульман" гэж хэлнэ. Хүн юунд, яаж, яагаад итгэж байгаагаа мэдэх нь чухал. Исламын эрдэмтэд итгэл үнэмшлийг; зүрх сэтгэлээрээ хүлээн зөвшөөрч хэлээрээ үүнийг илэрхийлэх гэж тодорхойлсон. Итгэл үнэмшлийн үндэс нь зүрх сэтгэл дээр тогтдог бөгөөд энэ нь чин сэтгэлээсээ байхын баталгаа юм. Гэхдээ хүн нийгмийн амьдралдаа Мусульман гэдгээ харуулахын тулд үүнийгээ үг яриа, хэллэгээр илэрхийлэх хэрэгтэй.

Шашны зарчмуудыг маш сайн мэддэг ч, зүрх сэтгэлээрээ зөвшөөрөөгүй учир тус хүнийг итгэгч болгодоггүй. Үүний хамгийн сайн жишээ бол Исламын тухай судалгаа хийсэн Барууны академичид, өөрөөр хэлбэл дорно дахины судлаачид юм. Шашин, хэл, шинжлэх ухаан, сэтгэлгээ, урлаг, түүх зэрэг салбарт Исламын ертөнцийг судалж, энэ чиглэлээр дүгнэлт гаргаж буй эдгээр хүмүүсийн өргөн мэдлэг нь тэднийг итгэхэд хангалттай байгаагүй билээ. Эдгээр зүйлүүдэд итгэхийн тулд зүрх сэтгэлээрээ хүлээн зөвшөөрөх ёстой.⁴

Аллахын оршихуйг оюун ухаанаар нотлох ? боломжтой юу

Бид ихэвчлэн оюун ухаан болон мэдрэхүйн эрхтнүүдээрээ дамжуулан оршихуйн талаарх мэдээлэлд хүрдэг. Оюун ухаан бол Аллах эзнээс бидэнд өгсөн хамгийн том бэлэг буюу хамгийн чухал адислал юм. Гэхдээ бүх мэдээлэлд оюун ухаанаар хүрэх боломжгүй. Ислам шашны мэдээллийн

4 Мустафа Синаноглу, "Иман", ДИА, хавтас. 22, х. 212-214.

ЗАЛУУЧУУДЫН ИТГЭЛ СҮСЭГ БИШРЭЛИЙН АСУУЛТУУД

эх сурвалжаас нэг нь илчлэгч (вахи) юм. Аллах эзний илгээсэн элч нараар болон ариун судруудаар дамжуулан бидэнд мэдэгдсэн юм.

Оршихуйн үндэс хоёр хуваагддаг ба энэ нь мэдрэхүйгээр мэдрэгддэг харин нөгөө нь мэдрэхүйгээс гадуур байдаг. Мэдрэхүйгээр мэдрэгддэг оршихуйг бид оюун ухаан ба мэдрэхүйгээрээ мэдэж болно. Бид мэдэхийг хүссэн зүйлсээ шаардлагатай бол лабораторид туршилтад оруулснаар зөв үр дүнд хүрч чадна. Гэсэн хэдий ч мэдрэхүйн цаадах хүрээнд үүнийг хийх боломжгүй. Бидний Эзэн (Аллах) бол мэдрэмжээс давсан оршихуй учраас Түүний мөн чанар нь мэдрэхүйн тусламжтайгаар тодорхойлогдохгүй. Энэ шалтгааны улмаас Аллахын оршихуйг (байдаг гэдгийг) харагдахуйц ба мэдэгдэхүйц байдлаар нотлох боломжгүй. Энэ талаарх тодруулга болон гаргасан нотлох баримтууд нь зөвхөн хүмүүсийг сэрэмжлүүлэх, сэтгэх зорилготой болохыг хангах явдал юм.

Исламын эрдэмтэд хэлэхдээ, нүдэнд харах чадварыг өгсөнтэй адил хүний мөн чанарт Аллахыг таньж, түүнд албат болох хүсэл байдаг гэж хэлдэг. Гэсэн хэдий ч өвчин, хөгжлийн бэрхшээлийн улмаас алсын хараагаа хэсэгчлэн эсвэл бүр мөсөн алдсан байж болохтой адил хүний мөн чанар алдагдсан үед энэ функц гэмтсэн байж болзошгүй.

Аллах Эзэн *“Тэнгэр, газрыг бүтээхэд, өдөр, шөнө солигдоход, хүмүүст ашиг тус өгөгч зүйлүүдтэй далайд сэлж яваа хөлөг онгоцнуудад, Аллахын тэнгэрээс хур*

буулгаж үхмэл байдалтай газрыг амилуулсан ба тэнд бүх төрлийн амьд амьтдыг өсөн дэвжихэд бороо, салхи болон тэнгэр, газрын хооронд зарлиг гүйцэтгэгч үүлнүүдийг чиглүүлэх нь ухаантай хүмүүсийн хувьд (Аллахын оршихуйг нь, Түүний цорын ганц болохыг нь нотлоход) үй олон баталгаа байгаа нь эргэлзээгүй."⁵ хэмээн айлдсан. Орчлон ертөнц дэх энэхүү өөрчлөгдөшгүй зохицол, дэг журам нь Аллахын оршихуй бий гэдгийг харуулсан хамгийн чухал нотолгоо юм.

Аллах Эзний бүтээсэн зүйл ба түүний бүтээлүүдийг эргэцүүлэн бодох болон тэндээс Аллахын оршихуйд хүрэх нь зөв хандлага байх болно. Мөн чанар нь эвдрээгүй, оюун ухаан нь худал мэдээллээр бохирдоогүй, өрөөсгөл үзэлгүй хүн бүр орчлон ертөнц болон Аллахын бүтээлүүдийг харах замаар түүний оршихуйг ойлгох чадвартай бүтээгдсэн.⁶

Аллахын оршиж буй гэдгийг би амьдралдаа яаж мэдрэх вэ ?

Аллах эзэн хүнийг бүхэлд нь бие махбодь (физик) болон метафизик хэмжүүрээр бий болгосон. Хүн оршихуйн үүднээс Эзнээ (Аллахыг) таних чадвартай байдаг. Исламын эрдэмтэд хүн төрөлхийн Аллахын оршихуйг мэдэрч чадахуйц байдлаар бүтээгдсэн бөгөөд үүнийг "Фытрат" буюу "зан чанар өөрөөр хэлбэл хүнд байгалиас заяасан" хэмээх ойлголтоор тайлбарладаг. Бидний гэгээн Элч "Хүүхэд бүр

5 Бакара, 2/164.

6 Бекир Топалоглу, "Дин", ДИА, хавтас. 2, х. 473-477.

байгалиас заяасан төрдөг"⁷ гэж хэлэн өөрийн үгээр илэрхийлсэн байдаг.

Хүний биеийг сайтар судалж үзэхэд ДНХ-ийн бүтцээс эхлээд мэдрэлийн сүлжээнд, эсүүдээс цусан дахь элементүүд хүртэл ийм гайхалтай нэгэн бүтцээр бүтээгдсэнийг бид харж байна. Энэ төгс оршихуй нь өөрөө бий болон бүрэлдэх чадваргүй гэдгийг ч бид мэднэ. Аллахын оршихуйг хүлээн зөвшөөрөөгүй шинжлэх ухааны аргуудын аль нь ч одоог хүртэл нэг хүнийг, тэр ч байтугай түүний ганц эрхтнийг, Аллахын бүтээсэн төгс төгөлдөр байдлыг үүсгэж чадаагүй. Энэ нь хэзээ ч боломжгүй гэдгийг Куран сударт ийнхүү айлдсан байдаг: *"Аяа, хүмүүс ээ! Та нарт нэгэн жишээ өгөгдлөө. Одоо үүнийг сайн сонсогтун: Та нарын Аллахаас бусад, шүтэн тахисан зүйлс чинь бүгдээрээ нийлээд ганц ялааг ч бүтээж чадахгүй. Ялаа тэднээс бие цогцсоос нэг зүйлийг булаахад тэд түүнийгээ ч хамгаалж чадахгүй. Учир нь шүтсэн, шүтүүлсэн хоёулаа чадал мөхөс билээ."*⁸

Аллах Эзэн Куранд: *"Тэнгэр, газарт буй бүхэн Аллахаас хувь хишиг хүсдэг. Тэр агшин бүрт шинэ үйлийг гүйцэлдүүлнэ."*⁹ гэж айлдснаар мэддэг мэдээгүй бүх оршихуйнууд Аллах Эзэнтэй байнгын холбоотой байдаг гэсэн үг юм. Амьсгалах хүртэл Түүний бүтээлд хором мөч бүрт хэрэгтэй хүн, Аллахын оршихуйг мэдрэхгүй байх боломжгүй юм. Орчлон ертөнц¹⁰ болон хүний бүтээгдсэн байдлыг¹¹ хараад бид Түүнийг (Аллахыг) ямар ч үед мэдэрч

7 Бухари, Тэфсир, (Рум) 2.

8 Наж, 22/73.

9 Рахман, 55/29.

10 Нахыл, 16/11, 12; Рум, 30/22; Фатыр, 35/41; Ясин, 36/38-40; Каф, 50/6.

11 Мүминун, 23/14; Ясин, 36/77; Жасия, 45/4.

болохыг Куран судрын олон эшлэлд дурдсан байдаг. Гайхамшигт ордон, цайз, усан үзмийн талбай, цэцэрлэгт хүрээлэнгээрээ алдартай Ирем хотод цэцэглэн хөгжиж амьдарсан ч үгүйсгэсээр байгаа хүмүүс, Ад үндэстний Элч Худ хэлэхдээ: *"Та нарын мэдэж буй бүхнийг хайрласан Аллахаас айгтун. Тэр та нарт мал сүрэг хийгээд үр хүүхдийг; Мөн цэцэрлэгүүд хийгээд булгийн усыг хайрласан Аллахаас эсрэг босохоос эмээгтүн."* гэсэн үгээрээ анхааруулсан байдаг.¹²

Зөвхөн нэг хүний бий болох, төрж өсөх болон түүнийг насанд хүрсэн хойноо үхэхийг нь ажигласнаар ч гэсэн, бид Аллахын оршихуйг амархан мэдэрч чадна. Бидний зүрх сэтгэл дэх хайр бол Аллахын биднийг нигүүлсэж буйн илрэл юм. Аллах Эзэн өөрийн албатуудаа өвчтэй үед нь эдгээж, өлсөхөд нь цатгадаг мөн шаардлагатай үед нь аюулгүй байдлыг хангадаг юм. Куран сударт энэ үнэнийг Гэгээн Элч Ибрахимын хэлээр үүнийг дараах байдлаар дүрсэлсэн байдаг: *"Та нар сайтар мэдэж авагтун, Ертөнцийн Эзнээсээ өөр шүтээнд шүтэн мөргөх юм бол тэд чинь миний атаат дайсан юм шүү дээ, Тэр намайг бүтээсэн, бас надад зөв шулуун замыг заасан; Намайг хооллож, ундаалдаг нь ч Тэр, Өвдсөн үед намайг анагаах увдис өгөгч нь мөн Тэр билээ."*¹³

Аллах Эзэнд итгэх итгэл нь намайг хүчирхэг болгох болов уу ?

Хүний тэнцвэртэй, тайван амьдралаар амьдрах болон түүний амин чухал хэрэгцээг хангахын

12 Шугара, 26/132-134.

13 Шугара, 26/77-80. Аугиса бкз. Курайш суре.

тулд тодорхой урам зоригтой байх сэтгэл зүйн хүч чадалтай нягт холбоотой юм. Сэтгэл зүйн байдлаар тэсвэр тэвчээртэй хүмүүс тулгарсан бэрхшээлийг даван туулахад бэлэн байдаг ба илүү амжилттай байдаг. Өнөөгийн орчин үеийн амьдрал хувь хүнд үзүүлж буй стресс нь эмч нарын хувьд олон өвчний үр дагавар шалтгаан эсвэл өдөөгч гэж үздэг байна.

Аллахад итгэх итгэл нь Мусульманчуудын хувьд хуяг дуулганы үүргийг гүйцэтгэдэг. Хүн өөрт нь тохиолдсон хүнд хэцүү нөхцөл байдалд бүх хүч чармайлтаа гаргасны дараа Түүнээс тусламж гуйж, нөхцөл байдлыг Аллахад шилжүүлэн, бүх зүйлийг сонсох чадвартай, бүхнийг чадагч Бүтээгчийн оршихуй нь түүнд итгэл найдвар болон аюулгүй байдлын мэдрэмжийг өгдөг. Бидний Эзэн өөрт нь хандан залбирсан хүмүүсийн залбиралд хариулна гэдгээ мөн тэрээр албат нар нь өөрт нь ойртоход тэд нартайгаа илүү дөхөм болно гэсэн сайн мэдээг дуулгадаг. *"Боолууд минь та нараас Миний тухай асуувал: Би тэдэнд ойрхон байна. Бас надад наманчлан залбирах аваас түүний залбирлыг хүлээн авч соёрхоно. Тэд зөв замаар явна гэвэл Миний урилгыг хүлээж авагтун, надад итгэгтүн."*¹⁴

Аллахад итгэх итгэл нь хүн төрөлхтний сайн сайхны болон эрх, шударга ёсны төлөө тэмцдэг хүмүүсийн хүч чадлын эх үүсвэр юм. Аллах Эзэнд итгэх нь хүмүүст түүхийн хүнд хэцүү үеийг даван туулахад, сэтгэл зүйд итгэх хүч өгдөг байсан. Бэрхшээлийг итгэлээр даван туулсан олон жишээ бий. Ялангуяа хүнд хэцүү цаг үед Аллахад итгэх итгэл нь гол

.....
14 Бакара, 2/186.

тулгууруудын нэг байсаар ирсэн. Бадрын тулаанд хэдийгээр тэд цөөхөн байсан Мусульманчууд, Аллахад итгэх итгэлийн тусламжийн ачаар тэднээс тоо томшгүй олон, зэвсгийн хувьд давуу талтай дайснуудаа ялсан билээ. Тэр ч байтугай тэвчээртэй байж Аллахыг үл дагах байдлаас зайлсхийвэл тэднийг цаашид мөн адил дэмжих болно гэдгээ зарласан билээ.¹⁵ Бидний өвөг дээдэс Аллах Эзний тусламж нь тэдэнтэй хамт байсан тэдэнд тусалж дэмжиж байсан гэдэгт итгэснээрээ бэрхшээлийг даван туулсан түүхэн бодит байдал юм.

Аллах Эзэн хаана байна, ? Би харж, сонсож чадах уу ?

Нэг газарт, нэг байранд байх нь бүтээгдсэн хүн амьтдад хамааралтай онцлог юм. Харин бидний Эзэн Аллах бол бүтээгдсэн оршихуй биш юм. Бүтээсэн, байгуулсан, зохион бүтээсэн орчлон ертөнцөд ямар нэгэн газар, албан тушаалыг Аллахад хамааруулах нь зөв хандалт биш юм. Аллах Эзэн бол бүх хүнийг болон бүх зүйлийг бүтээгч ба бидний Эзний мөн чанар нь бид нарын бодож байгаа бүхнээс илүү юм.

Дэлхий дээр бидний харж чадахгүй олон зүйл бий. Энэ нь тэдний байхгүй байгаатай биш, бидний нүд тэднийг харах чадваргүй учраас тэр бүх зүйлийг харж чаддаггүй. Бид Аллах Эзнээ, мэдрэхүйгээр шууд ойлгож чадахгүй. Үүнийг Аллах Эзэн, Гэгээн Куранд: *"Хорвоод түүнийг үзэж чадах нүд үгүй. Харин Тэр мэлмий бүхнийг соёрхон харж байдаг. Тэр хамгийн*

.....
¹⁵ Али Имран, 3/123-125.

нарийн зүйлүүдийг мэддэг ба бүхнийг мэдэгч билээ.¹⁶ гэх эшлэлээр тайлбарласан байдаг. Хэдийгээр бид Түүнийг харж чадахгүй ч, бидний Аллах Эзэн, -Нарны илч, гэрэл хаа сайгүй нэвтэрдэг шиг- нэр болон тэр өөрийн онцлог шинж чанаруудын илрэлтэй холбоотой хаа сайгүй байдаг.¹⁷

Би Аллах Эзнийг диваажинд харах уу ?

Ихэнх Исламын эрдэмтдийн үзэж байгаагаар итгэгчид буюу Мусульманчууд Аллахыг диваажинд харах боломжтой. Энэ бол диваажин дахь хамгийн агуу адислал байх болно. Аллах Эзэн маань бидэнд ¹⁸энэ тухай сайн мэдээг энэхүү эшлэлээр дуулгадаг: "Тэр өдөр олон хүн Эзэнтэн рүүгээ хараад царай нь аз жаргалаар гэрэлтэнэ." Гэгээн Элчийн хадисуудаас бидний ойлгож байгаагаар үүлгүй өдрийн үд дунд дахь нар болон үүлгүй шөнийн тэргэл сарыг хардаг шиг нөгөө ертөнцөд (Ахирэтед) Аллахыг харах болно.¹⁹ Гэхдээ энэ харах нь ямар байдлаар болохыг бид мэдэхгүй. Хэрэв бид түүнийг энэ ертөнцөд харж чадахгүй бол бид түүнийг диваажинд хэрхэн харах вэ гэсэн асуултад дараах байдлаар хариулъя: Энэ ертөнцөд оршихуйн харагдах нөхцөлд шаардагдах зүйлс нь диваажинд хүчинтэй биш юм. Диваажин нь өөрийн гэсэн өөр бүтэц зохион байгуулалтын нөхцөлтэй. Үүнээс гадна хүний бие мөн адил диваажинд дахин бүтээгдэх бөгөөд түүний

16 Ангам, 6/103.

17 <https://kurul.diyanet.gov.tr/Cevap-Ara/7/allah-nerededir?> Дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү. Бекир Топалоглу, "Аллах", ДИА, боть 2, х. 471-498.

18 Киямет, 75/22-23.

19 Бухари, Тэвхид, 24; Мүслим, Иман, 299, Зүхд, 16.

чадвар, онцлог нь энэ ертөнцөөс өөр байх болно. Хязгааргүй хүч чадалтай бидний Эзэнд өөрийг нь харах чадвартай бидний нүдийг бүтээх нь тийм ч хэцүү биш юм.²⁰

Хэрэв Аллах Эзэн танигдахыг хүссэн бол яагаад өөрийгөө ийм ? нууцлаг байлгадаг юм бэ

Бид энэ ертөнцөд Аллахын оршихуйг мөн чанараар нь харж чадахгүй байгаа нь итгэлээс үүдэлтэй, хамааралтай асуудал юм. Бүтээсэн бүтээлээрээ оршин байгаа нь тодорхой болсон бүтээгчдээ итгэхгүй байх, нөхцөл байдал байж болохгүй гэдгийг хүн бүр мэддэг, хүлээн зөвшөөрдөг. Тийм ч учраас Аллах өөрийн "жинхэнэ төрх"-ийг бидний харж чадах ойлголтоос хол байлгасан. Зөвхөн Аллахын мөн чанар төдийгүй итгэл үнэмшлийн зарчимд багтсан тэнгэрийн элч нар, ертөнцийн төгсгөл, диваажин, там гэх мэт сэдвүүд нь итгэгсдийн хувьд үл үзэгдэх бөгөөд далд байдаг. Үл үзэгдэх зүйл бол мэдрэхүйн эрхтнүүдээрээ мэдэх боломжгүй, мөн нүднээс далд байгаа бүх зүйлийг хэлдэг.²¹ Үл үзэгдэх ертөнцөд итгэх нь Куран сударт Фатихагийн дараагаар “Аль Бакара” бүлэгт итгэгсдийн шинж чанарыг тайлбарласан эхний эшлэлд оршдог. Юуны өмнө Аллах хараагүй мөртөө үл үзэгдэх зүйлд итгэж, намаз мөргөл үйлдэж, инфак буюу Аллахын тааллыг олж авахын тулд хөрөнгө мөнгөө

20 Тэмэл Ешилюрт, “Рүетуллах”, ДИА, б. 35, х. 312-314.

21 Иляас Чэлэби, “Гайб”, ДИА, 13-р боть, 404-р хуу.

зарцуулдаг мүмин хүнийг сүсэг бишрэлтэй хэмээн дурдаж, авралд хүрнэ гэсэн баярт мэдээг өгдөг.²²

Энэ ерөнхий хүрээнд авч үзвэл, энэ нь Аллах ертөнцөд өөрийгөө нуун дарагдуулах нь нэгэн сорилтын шаардлага юм. Оршихуй нь Түүний мөн чанартай хамт харагдахуйц нэгэн бүтээгч гэдэгт итгэх нь итгэл бишрэлийн асуудал байхаа больж, мэдээжийн хэрэг энэ тохиолдолд хүмүүс итгэхгүй байхаас өөр аргагүй болдог. Аллах Эзэн Куран сударт өөрийг нь олохыг хүссэн хүмүүст илэрхий боловч мөн адил нууцлагдмал болохыг илэрхийлсэн билээ. "Түүнд эхлэл, төгсгөл үгүй. Тэр мөнх оршиор байх болно. Ид шидийн чадлаа үзүүлдгээрээ ил тод, нүдэнд үзэгдэхгүй, ухаан хүрдэггүй нууцаараа далд байдаг. Тэр бүхнийг мэдэж байдаг."²³ Түүний оршихуйг харахыг хүсдэг хүмүүст энэ нь тэдэнд тэр орчмын ба тэдний өөрсдөд буй нотолгоонуудаа харуулсаар байх ба хамгийн гүн гүнзгий мэдрэгддэг.²⁴

Аллах Эзэн хаа сайгүй байдаг гэдэг нь юу гэсэн үг вэ ?

Хэдийгээр бид оюун ухаанаараа Аллах Эзний оршихуйг ойлгож чаддаг ч чухам ямар төрлийн оршихуй вэ гэдгийг тэр бүр ойлгоход хэцүү байдаг. Аллах Эзэн бидэнд зарим шинж чанар болон зүйрлэлээр Өөрийгөө танилцуулдаг. Эдгээр шинж чанаруудын нэг нь Аллах цаг хугацаа, орон зайнаас үл хамааралтай байдаг; өөрөөр хэлбэл цаг хугацаа,

.....
²² Бакара, 2/3-5.

²³ Хадид, 57/3.

²⁴ Фуссилат, 41/53.

орон зай байхгүй, бүтээгдээгүй үед ч байхаас гадна, бүх цаг үе болон бүх газарт оршин байдаг. Учир нь орон зайг Аллах Эзэн бүтээсэн билээ. Түүний бүтээсэн нэгэн оршихуй нь Аллахыг хязгаарлах боломжгүй юм. Нэг орон зайд байх нь үндсэндээ хязгаарлагдмал байх гэсэн үг юм. Аллах Эзэнд ийм хязгаарлалт байхгүй билээ.

Хэрэв Аллах Эзэнд зориулсан газар байхгүй бол мөсжидүүд Аллахын өргөө байх нь юу гэсэн үг вэ ?

Аллахын хувьд орон зай байхгүй гэдэг нь мөсжид ба Кагба нь Аллахын өргөө болох нь хоорондоо зөрчилддөггүй. Сансар огторгуйг Аллах бүтээсэн бөгөөд Түүний бий болгосон зүйлүүд нь Бүтээгчээ хүрээлэх, захирах, хязгаарлах боломжгүй юм. Аллах бүх газрыг, бүх орон зайг захирдаг, тиймээс Тэр хаа сайгүй байдаг. Гэсэн хэдий ч мөсжид, Кааба бол бидний Аллах Эзнээ дурсаж, мөргөл үйлдэж, залбирах онцгой газар юм. Эдгээр газар байршил нь Аллах тэдгээр "газруудад" байгаа гэсэн үг биш юм.

Аллах бүтээгдээгүй юм ? бол яаж байх билээ

Аллах Эзэн бүхнийг бүтээгч билээ. Бүтээгч байхад өөр нэг бүтээгч хэрэгтэй гэж төсөөлөхийн аргагүй юм. Куран сударт ийнхүү дурдсан билээ " (Аяа, Мухаммед) Ийнхүү хэлэгтүн: Аллах бол цорын ганц. Аллах ашид мөнх. Тэр төрөөгүй, төрүүлээгүй. Түүнтэй

эн зэрэгцэх юу ч үгүй."²⁵ Эшлэл дэх "Самед" гэдэг үг нь оршихуйн хувьд хэнээс ч хамааралгүй ба бүх зүйлийн оршин тогтнох болон үргэлжилсэн байдал нь үүнээс хамаарна гэсэн утгыг илэрхийлнэ. Түүний оршихуйд эхлэл болон төгсгөл гэж үгүй. Бидний Эзний оршихуй нь Өөрөө юм. Аллах Эзний оршихуйн гарт баригдаж нүдэнд харагддаг зүйл биш учраас Түүний мөн чанарыг мэдрэхүйгээр хүлээн авах боломжгүй юм. Ийм учраас Түүний оршихуйг шинжлэх ухааны аргуудаар тайлбарлахыг оролдох нь биднийг зөв дүгнэлтэд хүргэхгүй.

Бидний мэдрэхүй нь Аллах Эзнээ танин мэдэхийн тулд; оюун ухаан болон зүрх сэтгэлд мэдээлэл/материалаар хангадаг. Энэ мэдээлэл, материал нь бүтээгдсэн бүх зүйл юм. Орчлон ертөнцийн бүхий л зохицол, дэг журам, өөрчлөлт ба хувирал, гайхамшигт бүтэц нь Аллахын цор ганц болохын баталгаа юм. Өөрөөр хэлбэл, бид Аллахыг нүдээрээ харж чадахгүй ч оюун ухаанаараа Түүний оршихуйг ухаарч, зүрх сэтгэлээрээ Түүнийг мэдэрдэг.

Таухидын зарчмын тайлбар юу вэ ?

Исламын шашны үндэс нь таухид, өөрөөр хэлбэл Аллахын цорын ганц гэдэгт итгэх зарчим дээр суурилдаг. Энэ зарчмыг Калима-и Таухид, Калима-и Шахадат нарын өгүүлбэрт товч тодорхой илэрхийлсэн байдаг. Калима-и Таухид, *"Ла илаха иллаллах Мухаммадун расулуллах"* нь *"Аллахаас өөр шүтээн үгүй, Мухаммед түүний элч мөн"* гэсэн утгатай. Калима-и Шахадат бол *"Ашхадү аль ла*

.....
²⁵ Ихлас, 112/1-4.

илаха иллаллах уа ашхаду анна Мухаммеден абдуху уа расулүх" нь "Аллахаас өөр шүтээн үгүй бөгөөд Мухаммед бол Түүний үнэнч боол бөгөөд элч гэдгийг би гэрчилж байна" гэсэн утгатай юм.

Таухидын зарчим бол Аллах өөрийн шинж чанар, бүтээсэн зүйлсээрээ цорын ганц бөгөөд өвөрмөц юм. Энэ нь Аллах зати шинж чанараараа цор ганц гэсэн утгатай юм, Түүний цор ганц нь Түүнд ижил төстэй, эсвэл эсрэг зүйл байдаггүй гэсэн үг юм. Аллах өөрийн субути шинж чанараараа цор ганц гэдэг нь өөр хэнд ч Түүнд байгаа шинж чанарууд байдаггүй гэсэн үг юм. Жишээлбэл; Аллахын хаят (амьд байх, Аллах мөнхөд амьд сэрүүн байна) гэх шинж чанартай нь бусад амьд биетүүдийн амьд байхтай нь ижил биш юм. Түүний амьдралыг өөр хэн ч өгөөгүй, эхлэл төгсгөлгүй ба амьсгалах зэрэг нөхцөлд шаардлагагүй нэгэн шинж чанар юм. Зөвхөн Аллахад хамаарах зарим шинж чанарууд бас байдаг. Яг л юуг ч оргүй хоосноос бүтээж, эхлэл ба төгсгөлгүй, өөр хэнд ч хэрэгцээ шаардлаггүй гэсэн хэдий ч хүн бүр Түүнд хэрэгтэй байдаг шиг... Энэ бүгд Аллахын үйлдлүүдийн нэг чанар нь орчлон ертөнцийг оргүйгээс бүтээж, удирдан чиглүүлдэг цорын ганц Аллах байдаг гэдэгт оршино.²⁶

Аллахаас өөр шүтээнийг хүлээн зөвшөөрөх, Аллахаас өөр бурханд залбирч мөргөх, Аллахаас өөр ирээдүйн тухай мэдээг мэддэг гэдэгт итгэх, зөвхөн Түүнд үзүүлж болохуйц хүндэтгэлийг бусад бурхан

.....
26 Куран судар дахь таухидын зарчмын талаар үзнэ үү. Шабан Али Дүзгүн, "Куран судрын Таухид философи", *Кэлам судлалууд*, 3:1 (2005), 3-21-р хуу.

болон шүтээнд үзүүлэх нь таухидын (Аллахын цорын ганц гэдэгт итгэх итгэл) зарчимд харш юм.

Калима-и Таухид нь бидний амьдралд ямар ач холбогдолтой вэ ?

"Калима-и Таухид", өөрөөр хэлбэл *"Ла илаха иллаллах Мухаммадун расуллах"* гэдэг нь Исламын шашны үндсэн зарчим болох таухидын зарчмыг хураангуйлсан хэллэг юм. Аллах, бүх Элч нарыг Калима-и Таухидын илэрхийлсэн утгыг хүмүүст хүргэхийн тулд илгээсэн юм. Энэ талаар Куран сударт дараах эшлэлээр илэрхийлсэн байдаг. *"Аяа, Мухаммед! Бид чамаас өмнө илгээсэн гэгээн элч нарт гагцхүү: 'Эргэлзээгүй Надаас өөр ямар ч бурхан үгүй. Тиймээс зөвхөн Надад сүсэглэн мөргөгтүн' хэмээн айлдсан бөлгөө."*²⁷

Калима-и Таухидын утгад итгэж, хүлээн зөвшөөрсөн хүн мусульман болдог. Учир нь энэ үг итгэлийн үндсэн зарчмуудыг хураангуйлан агуулсан байдаг. Аллахад болон элч нарт итгэх нь Таухидын үгэнд байдаг бол сахиусан тэнгэрүүд, ариун судруудад, хойд ертөнцөд, хувь заяанд итгэх итгэлийн талаар мөн энэ үгэнд утгын хувьд агуулагдсан байдаг. Учир нь Аллахын оршихуй болон Түүний цор ганц гэдгийг хүлээн зөвшөөрсөн хүн, Түүний илгээсэн элч нараар дамжуулан өөрт нь ирсэн итгэл сүсэг бишрэлийн бусад зарчмуудыг хүлээн зөвшөөрдөг.²⁸

27 Анбия, 21/25.

28 Комисс, *Илмихал*, Туркийн шашин хэрэг эрхлэх газрын хэвлэл, Анкара, 2006, 1-р боть, 70-р хуу.

Энэ тохиолдолд Калима-и Таухид нь бидний Аллах Эзний хүмүүст мэдэгдэхийг хүсдэг хамгийн чухал мэдээллийг агуулдаг юм. Орчлон ертөнцийг бүтээх болсон шалтгаан нь "Ла илаха иллаллах" гэдэг үгийг тунхаглаж, хүмүүсийг энэ үгэнд хариу өгөхийг уриалсан явдал юм. Гэсэн хэдий ч төгс утгаараа итгэл бишрэл нь бүтээдэг, захирдаг нэгэн Шүтээн байдаг гэдгийг батлах замаар бий болдоггүй. Бидний Элч Мухаммед (с. а. у.)- ын Гэгээн Элч болохыг баталгаажуулснаар итгэл бишрэл төгс болдог.²⁹

Калима-и таухидыг чин сэтгэлээсээ хэлж буй хүн бүх анхаарлаа Аллахад чиглүүлж, Түүнд бууж өгч, Түүний үзүүлсэн замаар алхахыг хичээх болно гэдгээ илэрхийлж, тэрээр өөрийн боолчлолыг Аллах Эзэндээ хамгийн сайнаар харуулахыг хичээдэг.

Нэгээс олон шүтээн байж болох уу?

Аллах Эзэн Куран сударт: *"Хэрэв, тэнгэр газарт Аллахаас өөр бурхад байсан сан бол газар, тэнгэр хоёр эвдрэн сүйрэх байсан."* ³⁰ Энэ эшлэлийн тайлбарыг харахад бид дэлхий дээр нэгээс олон бүтээгч, захирагч оршин тогтнох боломжгүй гэдгийг маш тодорхой ойлгож байна. Хэрэв орчлон ертөнцөд Аллахаас өөр бурхан, бурхад байсан бол бидний харж буй энэхүү гайхамшигт бүтэц дэг журам орчлонд байх боломжгүй. Учир нь бурхан бүр бий болгох бүтээх, удирдах, давуу байдлын хувьд хоорондоо

29 Эбү Хамид Мухаммед б. Мухаммед эл-Газзали, *Ихья*, Жүмлэ хэвлэл, Истанбул, 1989, 1-р боть, 229-р хуу.

30 Анбия, 21/22.

зөрчилдөх нь гарцаагүй. Энэ тохиолдолд ч биш дэлхий дээрх дэг журам үргэлжлэх нь боломжгүй байх байсан тэр ч байтугай дэлхий ертөнц бий болох боломжгүй болох байсан байх. Хэрэв энэ ертөнц оршин тогтнож, одоо байгаа ертөнц эмх цэгцтэй хэвээр байгаа бол энэ нь ганц бурхан оршин тогтсоны ачаар юм.³¹

Гэхдээ орчлон ертөнцөд хоёр ба түүнээс дээш бурхан байдаг гэж бодъё. Энэ тохиолдолд бурхад бүр бүрэн төгс байх чанараа алддаг. Дутагдалтай бол бурхан байж чадахгүй. Өөрөөр хэлбэл, орчлонд нэгээс олон бурхан байдаг тухай ярих нь дөрвөн талт гурвалжны тухай ярьж байгаагаар адил өөртэйгөө зөрчилдсөн үг юм. Бурхан цор ганц юм. Хэрэв тэр цор ганц биш бол тэр бурхан биш юм. Хэрэв энэ ертөнцийг бүтээсэн бурхан төгс бөгөөд бүхнийг чадагч юм бол энэ нь цор ганц байх ёстой. Тэгэхгүй бол өөр бурхан байгаа тохиолдолд түүний сул дорой байдлаас болж өөр бурхан байх хэрэгтэй гэх мэт байж боломгүй нөхцөл байдал үүснэ.³²

Товчхондоо, бие бийнээсээ хамааралгүй, эсвэл бие биетэйгээ түншилсэн ч гэсэн Аллахаас өөр шүтээн байх нь оюун санааны хувьд боломжгүй юм. Бидний Куран сударт ч Аллахаас өөр бурхан байдаг гэдгийг үгүйсгэдэг.³³

31 Комисс, *Куран судрын Турк утга агуулга ба тафсирын арга зам*, Турк улсын шашны хэрэг эрхлэх газрын хэвлэл, Анкара, 2017, 3-р боть, 672-р хуу.

32 Режеп Ардоган, *Системчилсэн теологи ба одоогийн итгэл бишрэлийн асуудлууд*, Клм хэвлэл, Истанбул, 2018, 53-р боть.

33 Али Имран, 3/2; Анбия, 21/22.

Исламын шашинд Аллахад итгэх итгэл болон бусад шашинд Аллахад итгэх итгэлийн хооронд ямар ялгаа байдаг вэ ?

Аллахад итгэх итгэл нь хүний мөн чанарын итгэл үнэмшил учраас дээд оршихуйд итгэж, хорогдох хэрэгцээ нь анхны хүн үүссэн цагаас хойш янз бүрээр илэрч ирсэн. Аллах энэ асуудалд өөрийн тусламжаа өгөхөөс татгалзаагүй бөгөөд вахи (Аллах өөрийн элч нартаа тушаал, зарлиг, мэдээлэл дамжуулах гэсэн утгатай) болон элч нарынхаа тусламжтайгаар хүн төрөлхтөнд хэрхэн итгэхийг заасан юм. Хүн төрөлхтний түүхийн туршид зөв замыг зааж, цаг хугацааны явцад бий болсон итгэл үнэмшлийн алдаа үүний нийгмийн амьдралд тусгагдсан байдлыг засахын тулд элч нарыг илгээсэн билээ.

Исламын шашин нь Аллахын анхны элч, Хз. Адамаас сүүлчийн элч Хз. Мухаммед (с. а. у) хүртэл илгээгдсэн цорын ганц шашин юм. Исламын шашинд Аллах бол цорын ганц, түүнтэй энэ зэрэгцэх зүйл үгүй. Тэрээр хүүхэдтэй болох, андуурах, мартах зэрэг дутагдалтай шинж чанарууд түүнд тохирохгүй бөгөөд бүхнийг мэдэх, сонсох, бүхнийг чадагч байх зэрэг дээд шинж чанарууд нь түүнд хамаарах цорын ганц Бүтээгч юм. Иймээс бүх зүйлийг бүтээгч ба хэлбэржүүлэгч нь Аллах учраас итгэн залбирч шүтэх ёстой нь зөвхөн Аллах юм.

Хэдийгээр Еврейчүүд ба Христийн шашин нь үндсэндээ бурханлаг илчлэлт буюу вахи дээр суурилдаг ч цаг хугацааны явцад хоёр шашинд өөрчлөлт, хазайлт гарч ирсэн юм. Еврейчүүд болон

Христэд итгэгчдийн дунд Аллахад итгэх итгэлийн эвдрэлийн талаар Төгс Хүчит Аллах тэрээр хэлэхдээ: "Еврейчүүд: "Гузайр бол Аллахын хүү" гэгцээсэн. Христчууд ч: "Иса буюу Масих бол Аллахын хүү" гэгцээсэн. Энэ нь тэдний өмнөх үл сүсэглэгсдийн (мухар сүсэгт өвөг дээдсийн) үгтэй адил, санаанаас зохиосон худал үг болой. Аллах тэднийг ниргэх болтугай! Тэд чин үнэнээс хэрхэн төөрөлдөнө гээч! Тэд (Еврейчүүд, Христчүүд) Аллахыг орхиж өөрсдийн эрдэмтэд, санваартнууд болон Мариямын хүү Масихийг (Иса-г) бурхан хэмээн үзсэн. Тэдэнд цорын ганц Аллахыг шүтэцгээ! хэмээн тушаасан билээ. Түүнээс өөр ямар ч бурхан үгүй; Аллах тэдний эн зэрэгцүүлснээс эрхэм дээд бөлгөө."³⁴ Эдгээр эшлэлүүдэд бидний Эзэн Еврейчүүд болон христэд итгэгсдийн Өөрийнх нь тухай зохиосон гүтгэлэгт хариу өгч, бүрхэг оюун ухааныг цэвэрлэв. Нөгөөтэйгүүр, Аллахын албатууд болох Хз. Иса болон түүний туслах нарт үзүүлсэн хэт их хүндэтгэлийг Аллахад харьяалагдах ёстой сууринаас хэтрүүлснийг илтгэдэг юм. Ийм учраас Рабб Эзэн маань Өөрөөсөө өөр бурхан байхгүй гэдгийг онцлон Өөрийнхөө тухай буруу итгэл үнэмшлийг засаж залруулдаг.

Ислам шашны цорын ганц бурханд итгэх итгэлтэй, Христийн шашны "Ариун гурвал" гэж илэрхийлэгддэг "Нэг бүтээгч Эзэн боловч гурван бодгалиас бүрддэг" гэх итгэл үнэмшил нь Аллахын тухай ойлголтын хамгийн үндсэн ялгаануудын нэг юм. Ариун гурвалын анхны элемент болох Эцэг бол орчлон ертөнцийг бүтээгч юм. Хүү бол хүн төрөлхтнийг анхны нүглээс аврахын тулд загалмайд

.....
34 Тауба, 9/30-31.

цовдлогдон өөрийгөө золиосолсон. Ариун Сүнс бол хүний зүрх сэтгэлд бурханлаг хайрыг суулгадаг нэгэн юм.³⁵

Христийн шашны ариун гурвалын итгэл үнэмшлийн буруу байдлын талаар Төгс Хүчит Аллах Куран сударт ийнхүү айлдсан: *"Аллахыг, "гурван бурхны гурав дах нь" гэдэг хүмүүс жинхэнэ буруу номтон болсон билээ Үнэндээ цор ганц бурхнаас өөр бурхан үгүй. Хэрэв тэд хэлснээсээ буцахгүй бол тэдний буруу номтнууд нь энэ ба хойд насанд хатуу цээрлэл үзнэ."*³⁶ Дээрх айлдвараас ойлгогдох нь ариун гурвал итгэл үнэмшил нь Хз. Исагийн заасан зүйл биш, харин хожим Христэд итгэгсэд бий болгосон итгэл үнэмшил юм. Исламын шашинд Аллахад итгэх итгэлд; тэрээр хүүхэдгүй бөгөөд Жабрайл бол сахиусан тэнгэр юм. Харин энэ нь Христийн шашинд Ариун Сүнс гэж нэрлэгддэг. Хз. Иса (Есүс) бол бурханлаг шинж чанар байхгүй Аллахын албат ба элч юм. Хз. Иса болон Ариун Сүнс хоёр ямар ч байдлаар Аллахтай ижил төсгүй юм.

Политеист буюу Олон бурхант шашнууд ба Исламын Аллахад итгэх итгэлийн гол ялгаа нь Аллахын цор ганц байдлыг онцолсонд нуугдаж байдаг юм. Куран сударт Аллах Өөрийгөө танилцуулахдаа Өөрийн шинж чанаруудыг, ялангуяа Түүнээс өөр бурхан байхгүй гэдгийг онцолж, хүмүүсийг бодоход уриалдаг юм. Энэ тухай Куран судар дахь эшлэлүүдийн нэг нь дараах байдалтай байна:

35 Өнөөгийн оршин тогтнож буй шашинууд, Шинаси Гүндүз, Туркийн шашны хэрэг эрхлэх газрын хэвлэл, Анкара, 2016, 95-р хуууркийн шашны хэрэг эрхлэх газрын хэвлэл

36 Маида, 5/73. Мөн үзнэ үү Ниса, 4/171.

"Аллах хэзээ ч хүүхэдтэй байгаагүй. Түүнтэй адилтгах ямар ч бурхан үгүй. Хэрэв тийм байсан бол бурхан бүр өөрийн бүтээснээ эзэгнэн, харсан зүг рүүгээ явах байсан бөгөөд тэд нэг нь нөгөөгөөс давуу эрхтэй болно хэмээн өрсөлдөх байсан ажгуу. Аллах тэр мүширикүүдийн зохиомжилсон зүйлсээс ангид бөлгөө. Аллах ил, далд бүхнийг мэдмүй. Тэр түүнтэй эн зэрэгцүүлж зүйрлэсэн бүхнээс агуу болой.³⁷ Энэ нь Аллахын цор ганц байдлыг үгүйсгэж, өөр өөр өнгөлөн далдлан Түүнтэй түншлэх бүх итгэл үнэмшлийг үгүйсгэдэг.

Дүгнэлтээр үзэхэд, Исламын шашин болон бусад шашны Аллахад итгэх итгэлийн гол ялгаа нь Аллахын цор ганц байдал юм.

Өөр өөр шашин ба соёлд хүмүүжсэн хүмүүс Аллах байдаг гэдэгт итгэж чадах уу ?

Аллахад итгэх итгэл нь хүн төрөлхтөнд төрөлхийн байдаг бөгөөд энэ нь байгалийн юм. Фитрат буюу хүмүүнд байгалиасаа бий болдог мөн чанарын тухай янз бүрийн тодорхойлолтууд хийгдсэн.³⁸ Харин бидний Гэгээн Элч Мухаммед (с. а. у.) "Төрсөн хүн бүр өөрийн фитрат мөн чанарын дагуу төрдөг. Дараа нь эцэг эх нь түүнийг еврей, христийн шашинтан эсвэл гал тахигч болгодог..."³⁹ гэсэн үгийн дагуу фитрат "анхны бүтээлийн үед Бүтээгчийг таньж мэдэх хандлага, хүний мөн чанарт заяасан зүрх сэтгэлийг ариусгах гэх мэт зүйлс багтдаг ба эерэг

37 Мүминун, 23/91-92.

38 Хаяати Көкэлэкли, "Фитрат", ДИА, 13-р боть, 47-48-р хуу.

39 Бухари, Тафсир, (Рум) 2; Мүслим, Кадэр, 22.

чадвар, зан чанар⁴⁰ гэж бид хэлж болно." Товчхондоо фитрат гэдэг нь хүнийг "үнэнийг хүлээн зөвшөөрөх хандлагатай бүтээгдсэн" гэсэн утгатай.

Аллахад төрөлхийн итгэл үнэмшлийн үндсэн дээр хүн ямар ч шашин шүтлэг, итгэл үнэмшлээс үл хамааран Аллахын оршихуйд "эрүүл ухаанаар" өөрөөр хэлбэл өөрийн мөн чанарыг хамгаалсан оюун ухаанаар хүрч чадна. Үүнтэй холбогдуулан калам/акайд болон Исламын философи гүн ухааны аль алинд нь зарим нотлох баримтуудыг хэлэлцэх асуудалд оруулж, Аллахын оршин тогтнох оюун ухааны үндэслэл болгон эх сурвалжуудад боловсруулагдсан билээ. Тухайлбал, эмх цэгцтэй байдлын баталгаа хэмээх логикийн хувьд асар том тосон будгийг харсан ухаант хүн бүр уг зургийг бүтээсэн мастер зураач байдаг гэж бодоод, түүний оршин тогтнолыг хүлээн зөвшөөрдөг. Яг үүнтэй адил орчлон ертөнц (*макро орон*) болон хүний (*бичил орон*) дахь төгс дэг журам нь, хүнийг энэ дэг журмыг тогтоосон болон хамгаалдаг Бүтээгч рүү Аллахад хөтөлдөг.

Еврей эсвэл Христийн орчинд амьдардаг, өөрөөр хэлбэл тэнгэрлэг гаралтай шашны аль нэгэнд харьяалагддаг хүмүүс (тэд өнгөрсөн эсвэл одоо амьдарч байгаа эсэх) Аллахын оршихуйд хүрэх боломжтой. Эдгээр бүх шашинд адилхан биш ч гэсэн Аллахад итгэх итгэл дурдагдсан байдаг. Бусад итгэл үнэмшлийн системүүд Аллах/бүтээгч гэх бодлын талаар өөр өөр таамаглалтай байдаг. Тиймээс эдгээр итгэл үнэмшлийн системийг хүлээн

40 Хаяати Көкэлэкли, "Фитрат", ДИА, 13-р боть, 47- р хуу.

зөвшөөрсөн хүмүүс Аллахын оршихуйд хүрэхийн тулд хувь хүн бүр өөрийн хүчин чармайлтаа гаргах хэрэгтэй.

Аллахад итгэх итгэлийг үгүйсгэх ? хөдөлгөөний шүүмжлэл юу вэ

Эрт дээр үеэс өнөөг хүртэл хүмүүсийн дунд харийн шашны итгэл үнэмшил дэлгэрч байгаагийн хэрээр Аллахад итгэх итгэлийг харьцангуй бага ч гэсэн бүрмөсөн үгүйсгэдэг урсгалууд бас байсаар ирсэн. Бидний амьдарч буй эрин үед өргөн тархсан үгүйсгэлийн чиг хандлагууд дотор атеизм, деизм, агностицизм, позитивизм, материализм, нихилизм, эволюционизм, фрейдийн психоанализ зэргийг нэрлэж болно.⁴¹

Атеизм нь бүтээгч Бурхан байдаг гэсэн итгэлийг бүр мөсөн үгүйсгэдэг бол; Деизм нь Бурханд итгэх итгэлийг хүлээн зөвшөөрдөг ч Түүний элч нар болон судруудаар дамжуулан хүний амьдралд хөндлөнгөөс оролцохыг хүлээн зөвшөөрдөггүй. Агностицизмд Бурханы орших, эс оршихыг мэдэх боломжгүй гэж үздэг. Позитивизмд зөвхөн туршлага, туршлагыг мэдлэгийн эх сурвалж гэж хүлээн зөвшөөрдөг тул Бурханы оршихуйг ч хүлээн зөвшөөрдөггүй. Учир нь Бурхан бол туршилт, ажиглалтын талбарт ордог оршихуй биш юм. Материализмыг дэмжигсэд материалыг мөнхийн гэж хүлээн зөвшөөрч, түүнээс өөр бодит байдлыг хүлээн зөвшөөрдөггүй

41 Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү. Тэмэл Ешилюург, *Орчин үеийн итгэл бишрэлийн асуудлууд*, Турк дахь шашны хэрэг эрхлэх газрын хэвлэл, Анкара, 2018 он.

учир материалыг сэтгэлгээний төвд суулгасан байдаг. Тиймээс материалист сэтгэлгээнд Бурхан байдаг гэх ойлголтыг оруулдаггүй юм. Нихилизм нь одоо байгаа бодол санаа, үнэ цэн, итгэл үнэмшилд эргэлзээ, шүүмжлэлээр ханддаг тул энэ нь мөн бурхны үзэл санаа болон бурхны дүрэм журмын эсрэг байр суурь эзэлдэг байна. Хувьслын үзэл баримтлалд, бүх зүйл доод хэлбэрээс дээд хэлбэрт шилждэг бөгөөд энэ нь санамсаргүй байдлаар тохиолддог гэж үздэг ба монотеист шашинд бүтээлийн санааг үгүйсгэдэг шиг; бүх зүйл санамсаргүй тохиолдох нь Бурханд итгэх итгэлийг бас үгүйсгэдэг байна. Сигмунд Фрейдийн боловсруулсан психанализийн аргын дагуу түүний бэлгийн харьцаа болон айдас нь тухайн хүний зан үйлийг чиглүүлдэг байна. Энэ хоёр мэдрэмжийн дарамтаар бий болсон бурханд итгэх итгэл нь хүний дотоод сэтгэлийн зөрчилдөөнөөс үүсдэг ба бодит байдал дээр байдаггүй өвчин эмгэг юм.

Бидний дурдсан бүх үгүйсгэх хөдөлгөөнүүдийг (урсгалуудыг) харахад тэд Аллахын эрх мэдлийг хүлээн зөвшөөрөхгүй байх нийтлэг хандлагатай байгааг бид харж байна. Аллахад хэрэгтэй байх ба Түүний өмнө хариуцлага хүлээх тухай бодол нь эдгээр хөдөлгөөний/урсгалуудын аль нэгэнд байдаггүй байна. Тиймээс тэд зөвхөн энэ ертөнцийг төвлөрүүлснээр хүмүүсийн алсын харааг хязгаарлаж, амьдралыг утга учиртай болгох ямар ч үүрэг гүйцэтгэдэггүй. Гэсэн хэдий ч Аллах өөрийн элч нар болон ном судраар дамжуулан хүнд илгээсэн чин үнэнээр оюун санааны хувьд аюулгүй байдлыг мэдэрч, асуултад үнэн зөв хариу

олох орчныг бүрдүүлж өгөөд зогсохгүй, хойд ертөнцийн оршихуйгаар түүний амьдралыг утга учиртай болгож өгснөөр хүний алсын харааг тэлж, илүү өндөр зорилтуудыг тавьдаг. Дээр дурдсан урсгалууд нь өөрсдийн мэдээллийн эх сурвалжаар дамжуулан Аллах байхгүй гэдгийг баталж чадахгүйн адил хүнд санал болгож буй утга учир, үнэ цэний тогтолцооны ертөнцийг хэзээ ч үзүүлж чадахгүй.

Деизм гэж юу вэ ?

Деизм бол *"бүх төрлийн илчлэл, вахи, Аллахын оршихуй, шашин, хувь тавилан зэргийг үгүйсгэж, зөвхөн оюун ухаанаар ойлгогдох Аллахын оршихуйг хүлээн зөвшөөрч, тэшбих (хүнтэй адилтгах), ариун гурвал (гурвалсан Бурханы тухай ойлголт) -ыг үгүйсгэдэг философийн сургууль юм"* гэж тодорхойлогддог байна.⁴²

Деизм бол Европт Христийн шашин давамгайлсан орчинд сүм хийдийн эсрэг хариу үйлдэл болгон үүссэн философийн сэтгэлгээ юм. Ийм учраас тэдний элч нарт болон ариун номуудыг шүүмжлэх нь сүмийн хандлагаас үл хамаарах зүйл биш юм. Үүнээс гадна зөвхөн нэг төрлийн деизмийн тухай ярих боломжгүй юм. Орчлон ертөнцийг төгс бүтээсэн ч гэсэн орчлонтой ямар ч холбоогүй Бурханыг хүлээн зөвшөөрдөг деистүүд байдаг шиг; Хэдийгээр тэд Бурхан орчлон ертөнцийг хамаардаг гэж үздэг ч Бурхан ёс суртахууны хувьд хамаардаггүй гэж үздэг хүмүүс бас байдаг. Бурханы ёс суртахууны

42 Сүлэйман Хаяри Болая, *Философийн сургаал ба нэр томъёоны тайлбар толь*, Анкара, 2004, 204- р хуу.

шинж чанарыг хүлээн зөвшөөрдөг ч Бурхан ба хүний хооронд ямар ч үйл ажиллагаа байхгүй гэж итгэдэг деистүүд байдаг. Зарим деистүүд шашны үнэнийг хүлээн зөвшөөрдөг ч "оюун ухаанаар шүүгдэх" ёстой гэж үздэг.⁴³

Деизмд "байгалийн шашны ойлголт" гэсэн санааг хамгаалдаг.⁴⁴ Деизм нь шашны хүрээтэй ойлголтыг итгэл үнэмшлийн маргаанаас болж хүмүүсийг салгаж, хүний оюун ухаан гэх мэт чадварыг идэвхгүй болгодог гэж тэрээр шүүмжилдэг. Деизмд оюун ухаан илүү чухал байдаг ба шагнал, шийтгэлийн тухай ойлголтыг шүүмжилдэг.⁴⁵

Хүний амьдралд оюун ухаан болон ухамсрын үүрэг мэдээж маш чухал. Гэсэн хэдий ч Деизмд хоёуланд нь авах ёстой хэмжээнээсээ илүү үнэ цэн өгдөг гэдгийг бид харж байна. Хүний хувийн хүсэл болон хүслээс бүрддэг тал бас бий. Иймээс хүслийг хангахын тулд ухамсар нь дарагдаж, энэ нөхцөлд оюун ухаан нь давамгайлж үүрэг гүйцэтгэдэг болохыг бид нийгмийн амьдралд олонтоо хардаг.

Бүтээдэг боловч бүтээлдээ саад учруулдаггүй Бурханы тухай санаа нь түүний мэргэн ухаан, шударга ёс, нигүүлсэл зэрэг шинж чанаруудыг үл тоомсорлодог гэсэн үг юм. Элч нар болон номоор дамжуулан Бурханы хөтчийг үгүйсгэх нь хүмүүсийг

43 Шабан Али Дүзгүн, "Деизм: Тэргүүлэх нэрс ба үндсэн сургаал", *Орчин үеийн шашны эсрэг хөдөлгөөн ба деизм*, Ван, 2017, 3-13-р хуу.

44 Сүлэйман Хаяри Болая, *Философийн сургаал ба нэр томъёоны тайлбар толь*, 204-р хуу.

45 Шабан Али Дүзгүн, "Деизм: Тэргүүлэх нэрс ба үндсэн сургаал", 3-13-р хуу.

агуу буян хишгээс салгадаг байна. Хүний оюун ухаан төгс биш алдаа гаргадаг, андуурах тохиолдол бий. Гэсэн хэдий ч бүхнийг мэддэг, хардаг Алладын хувьд алдаа гаргах боломжгүй юм. Ийм учраас оюун ухаанаасаа илүү Аллахад бууж өгөх нь түүнд аюулгүй байдлыг мэдрүүлдэг. Нөгөө талаар деизм нь "Хүний амьдралын утга учир, зорилго юу вэ?" гэсэн асуултад хариулж, хүн төрөлхтний төлөөх ихээхэн үзэл санааг дэвшүүлэх чадваргүй юм. Деизм нь хойд ертөнцийн итгэлийг үгүйсгэж, хүний амьдралыг зөвхөн энэ ертөнцөөр хязгаарладаг тул хүмүүсийн алсын харааг нарийсгадаг.

Мусульманчууд бид ертөнцийг төгс бүтээж, хором мөч бүрд бүтээсээр байгаа цорын ганц Аллахад итгэдэг. Харамгүй буян хишиг хайрлагч Эзэн маань биднийг хорвоод нэгэн зорилготой илгээж, энэ зорилгыг элч нар болон ариун судруудаар дамжуулан бидэнд илчилсэн билээ. Тэрээр хамгийн найдвартай хүмүүсийн дундаас элч нараа сонгож, тэднээр дамжуулан бид энэ ертөнцөд хэрхэн амьдрах нь бидний амьдралын зорилгод хүрэх болно гэдгийг заасан юм. Элч нарын амьдралыг судалж үзэхэд тэднийг Алладын цор ганц гэдэгт итгэж, энэ итгэл үнэмшлийн дагуу буянтай үйлдэл ба зөв ёс суртахуунтай амьдрахад уриалж байсныг бид харж байна. Үүний зэрэгцээ, бүх Элч нар үнэнийг уриалж анхны хэрэгжүүлэгчид юм. Тиймээс бид мусульманчуудад элч нарт итгэх олон шалтгаан бий. Деизмийн философи хүлээн зөвшөөрсөн мэдээллийн эх сурвалжууд нь элч нар болон ариун номууд найдвартай биш гэдгийг батлахад хангалтгүй үлдэж байгаа юм.

Аллах Эзэн яагаад орчлон ертөнц болон хүмүүнийг бүтээсэн бэ ?

Энэ асуултын нэг нь Аллахад, нөгөө нь хүмүүст зориулагдсан хоёр талын хариулттай. Бид Эзнийхээ тухай бодохдоо дараах зүйлийг хэлж чадна. Аллах хожим нь ямар ч зан чанарыг олж аваагүй юм. Түүний бүхий л шинж чанарууд түүнтэй үргэлж хамт байсан бөгөөд цаашид ч байх болно. Бидний Эзний нэг шинж чанар нь "Халик", өөрөөр хэлбэл "бүтээгч" юм. Аллах бол бүтээгч билээ, өөрөө бүтээгч учраас орчлон ертөнц болон хүнийг бүтээсэн юм. Оргүй хоосноос бий болгон бүтээсэнд "Яагаад бий болгов" гэж хэлэх боломжгүй. Энэ нь нарнаас яагаад гэрэлтэй байгаа юм гэж асуухтай адил юм. Нар бол гэрэлт оршихуй учраас гэрэлтэй байдаг. Уран бүтээлч хүн урлагийн онцлогоороо уран бүтээл туурвидаг бөгөөд урлагийг нь харж, мэддэг болохоор урлагийн хүн гэдгээрээ алдаршдаг. Түүнд "Чи яагаад уран бүтээлч юм бэ, яагаад урлагийн бүтээл хийж байгаа юм бэ" гэж хэлдэггүй. Хүн ухаантай, сэтгэдэг хүний хувьд ямар ч гараг ертөнцийн талаар бодож чаддаг. Эргэцүүлэн бодох үед "Яагаад гарагуудын тухай бодоод байгаа юм бэ" гэж хэлдэггүй биз дээ. Тэр бодохыг хүсэж байвал бодно. Тэр бодохгүй байх үед энэ нь түүний сэтгэдэг оршихуйн шинж чанарыг устгадаггүй. Бүтээлч байхын салшгүй хэсэг болох бүтээлч чанарынхаа үр дүнд Аллах орчлон ертөнц болон хүмүүсийг бүтээсэн юм. Хэдийгээр тэр бүтээхийг хүсээгүй ч энэ нь Түүний бүтээлч байдлыг үгүйсгэхгүй.

Бидний Эзний өөр нэг шинж чанар бол тэрээр "рахман", өөрөөр хэлбэл "бүтээгдсэн бүх зүйлийн

буян болон өршөөлийг эрхэмлэгч" юм. Аллах өөрийн хязгааргүй нигүүлслийн үр дүнд хүнийг бүтээсэн билээ. Оршин байгаа нь нэгэн буян хишиг юм. Хэрэв дэлхий дээрх хүмүүсээс асуувал бараг бүгдээрээ мөхөх биш оршин тогтнохыг сонгоно. Бидний Эзэн хүн төрөлхтнийг оршихуйгаараа хүндэлж үнэлдэг юм. Энэ бол Түүний өршөөлийн үр дүн юм.

Хүн төрөлхтний хувьд бодож үзэхэд Куран сударт айлдсанаар бол газар дэлхий дээр халиф (залгамжлагчаа) бүтээнэ хэмээн байдаг байна.⁴⁶ Хүн дэлхий дээр халиф болох нь Аллахын өмчид Түүний хүсэл, зааврын дагуу амьдрах гэж ойлгож болно. Аллах Эзэн маань хэнд ч өөрийнх нь хүчнээс давсан үүрэг хариуцлагыг үүрүүлэхгүй хэмээсэн байдаг.⁴⁷ Хүн өөрийн *"итгэмжлэл"*, өөрөөр хэлбэл оюун ухаан, хүсэл зоригоороо дэлхий дээрх Аллахын дэг журмыг сахин хамгаалах үүрэгтэй.⁴⁸ Тэрээр Аллахын хүслийг газар дэлхий дээр хэрэгжүүлэхээр томилогдсон бөгөөд оршихуйн төрөлд бусад амьтдаас давуу болсон: *"Гарцаагүй бид Адамын үр удмыг (хүмүүний) өргөмжлөн, тэднийг хуурай газар дээр уналга унуулан, далайд хөлөг онгоцонд суулгаж, амтат хүнсээр хангаж, бусад амьтдаас хамаагүй давуутай бүтээсэн билээ."*⁴⁹

Аллах Эзэн хүсэл зоригтой хүнийг бусад амьтдаас илүүд үзсэн билээ. Хүн ба буг чөтгөрөөс бусад оршихуйг өөрсдийн бүтээлийнхээ ачаар Аллахыг байнга магтан алдаршуулж байхад хүмүүс сонголт

46 Бакара, 2/30.

47 Бакара, 2/286.

48 Ахзаб, 33/72.

49 Исра, 17/70.

хийх эрх чөлөөтэй үлдэж, Аллахыг өөрийн хүслээр мэдэн таньж, мөргөл залбирлыг илүүд үзэхийг түүнээс хүссэн юм. Гэсэн хэдий ч хүн Аллахыг мэдэж, Түүнийг таньж, Түүнд мөргөл залбирал үйлдэхийн тулд бүтээгдсэн билээ. Аллах Куран сударт буг ба хүмүүнийг зөвхөн өөрт нь залбираг хэмээн бүтээсэн гэж тодорхой бичсэн байдаг.⁵⁰ Албат, мэдэх ба таних гэсэн хүчин чармайлтыг дотроо багтаадаг. Иймээс хүн энэ хичээл зүтгэлийг ухамсарлахгүй, үүний эсрэг амьдралаар амьдрах юм бол өөрийн мөн чанартай зөрчилдөх болно. Үүнээс болж тэр тайван бус байдалд орсноор бусад сонголтууд түүнийг хангаж чадахгүй байдалд хүргэнэ. Өөр нэг айлдварт бидний Эзэн хүмүүсийн аль нь илүү сайн үйлдэл гаргахыг шалгахын тулд үхэл ба амьдралыг бүтээсэн хэмээсэн байдаг.⁵¹ Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтөн туршигдахын тулд бүтээгдсэн юм.

Үүний үр дүнд бүтээл нь Куран сударт зорилго, утга учиртай холбосон байдаг бөгөөд бидний Аллах Эзэн орчлон ертөнц, хүмүүнийг хоосон, утга учиргүй,⁵² хараа хяналтгүй орхихын тулд бус, харин зорилго болон утгын хүрээнд бүтээсэн хэмээн мэдэгдсэн билээ.⁵³

.....
50 Зариат, 51/56.

51 Мүлк, 67/2.

52 Духан, 44/38-39; Үүнтэй төстэй айлдваруудыг үзнэ үү. Анбия, 21/16.

53 Юнус, 10/5; Мүминун, 23/115; Киямэт, 75/36.

Аллах бүтээхдээ надаас асуугаагүй байхад яагаад надад ? хариуцлага тооцдог юм бэ

Орших нь нэгэн ерөөл юм. Аллах хүнд оршихуйг өгснөөр түүнийг шагнаж өргөмжилсөн юм. Нэмж дурдахад тэрээр хүнд оюун ухаан, хүсэл зоригийг өгсөн бөгөөд үүний үр дүнд тэрээр сонголт хийх чадварыг түүнд хариуцлага болгон тооцсон юм. Яагаад хариуцлага хүлээдэг вэ гэж асууж буй хүн юуны өмнө өөрийн орчлон ертөнц дэх өөрийн байр суурь, бүтэц, зорилгынхоо талаар бодох ёстой бөгөөд энэ нь бусад амьтадаас бие махбод, оюун санааны хувьд ялгаатай байдаг. Хүн хүсэл эрмэлзэлтэй/сонголт хийх чадвартай бөгөөд сонголтоо хийхдээ мөн адил хариуцлага хүлээдэг учраас бусад оршихуйгаас ялгаатай юм. Тэнгэрийн элч нар Аллахын зарлигийг эргэлзэлгүйгээр биелүүлэх чадвартай байхад Шэйтан, Аллахын зарлигийг үл тоомсорлож, бослого гарган эсэргүүцсэн, харин хүн төрөлхтөн өөрсдийн хүсэл, сонголтын дагуу Аллахын тушаал, хоригийг дуулгавартай дагах тал дээр эрх чөлөөтэй билээ. Өөрийн хүслээр ямар нэгэн зүйл хийх эсэхээ шийдсэн хүн эдгээр сонголтын үр дагаврыг ч үүрэх ёстой юм.

Хүний амьдралд сонгох боломжгүй зүйл бас байдаг юм. Тухайлбал, хаана, хэзээ төрж нас барах, аль үндэстэн, аль гэр бүлд мэндлэх, хүйс, үс, нүдний өнгө гэх мэт биеийн зарим онцлогийг харуулж болно. Энэ тал дээр ямар ч хүнд давуу эрх байхгүй. Энэ нь Аллахын хүслээр болсон зүйл юм. Бидний Эзэн хүссэн зүйлээ бүтээж мөн сонгодог. Хүмүүсийн

хувьд энэ асуудал дээр сонголт хийх эрх байхгүй билээ.⁵⁴

Энэ хязгаарлалт нь Аллахын өмнө бидний байр суурьтай холбоотой гэдгийг бид мартаж болохгүй. Бусад оршихуйгаас өөрөөр хэлбэл бусад амьд биетүүдийн хувьд хүний байр суурь маш өөр юм. Хүнд өгсөн оюун ухаан ба хүсэл зоригийн чадвараараа шувуудаас өндөрт гарч болно загаснаас илүү гүнд шумбаж чаддаг байна. Тэрээр урлаг болон шинжлэх ухааны салбарт гайхалтай бүтээл туурвиж чаддаг. Энгийн нүдээр харж болох ч тусгай багаж зохион бүтээж, гэрлийн болон энергийн долгионы хурдыг ашиглан ахисан шатны судалгаа хийж чаддаг. Хүн өөрчлөх боломжгүй зүйл дээр гацалгүй өөрийгөө бусад амьд амьтдаас илүү чадвар, чадамжаар хангагдсанаа ухаарсны эцэст амьдралын утга учрыг ойлгодог. Энэ бүх буян хишгийг бидэнд заяасан Аллах Эзэн маань ч биднийг хараа хяналтгүй орхилгүй, элч нар болон ном судруудаар биднийг чиглүүлэн зөв сонголт хийхэд тусалсан билээ. Ийм учраас хүсэл зориг, оюун ухаантай хүмүүс хариуцлага хүлээдэг байна.

**Дэлхий дээр яагаад харгислал,
муу муухай ба шударга бус байдал
байдаг вэ? Эдгээр үйл явдлуудыг
бид Аллахын нигүүлслээр
хэрхэн тайлбарлах вэ ?**

Энэ хорвоогийн амьдрал бол хүмүүсийн зан авирыг сорьж, сайн муу үйл бүхэн нь хожимдоо/

.....
⁵⁴ Касас, 28/68.

хойд ертөнцөд үнэлэгдэх туршилтын газар юм.⁵⁵ Аллах орчлон ертөнцийг бүтээсэн бөгөөд бидний сорилтыг хөнгөвчлөх бүх төрлийн буян хишгийг бидэнд өгсөн юм.⁵⁶ Нөгөөтээгүүр, бид нараас албатын үүргээ дээд зэргээр биелүүлж, эх дэлхийгээ сэргээн босгож, элдэв харгислал, хагарал, муу зуршлаас хол байхыг хүссэн билээ.⁵⁷

Энэ хорвоод сорилт болж ирсэн хүн бүр сорилтод орох тодорхой дүрэм журамтай байдгийг мэдэж байх хэрэгтэй. Сэтгэцийн чадамжтай ба чөлөөтэй сонголт хүсэл зоригтой байх нь сорилтод орох хүмүүсийн үндсэн эрх юм. Хэрэв Аллах бидэнд сонголт хүсэл зориггоо ашиглах чадварыг өгөөгүй байсан бол бидний сайн муу бүх үйлдлийг дангаараа Аллах Эзэн хариуцна гэж амархан хэлэх байсан. Гэтэл сонголт хийх эрхтэй хүн бүр үүнийг сайн мэднэ; энэ хорвоо дээрх харгислал, шударга бус байдал, муу муухай бүхэн хүний өөрийн гараар хийсэн зүйлээс үүдэлтэй байдаг.⁵⁸ Шалгалтын үеэр сурагчийн хариултад ямар ч багш саад болдоггүй. Хэрэв Аллах хорон муу хүмүүсийн харгислал, шударга бус байдлаас урьдчилан сэргийлэх бол хүмүүсийн хүсэл эрмэлзэл алга болж, дэлхий сорилтын газар байх онцлогоо алдах байсан. Энэ тохиолдолд хүн бүр итгэн биширч, диваажин ба там ямар ч утгагүй болно.

Асуултыг ухрааж, Аллах бүх төрлийн харгислал, шударга бус байдал, муу муухайгаас сэргийлдэг

55 Мүлк, 67/2.

56 Бакара, 2/29; Жасия, 45/13.

57 Нахыл, 16/90.

58 Шура, 42/30.

гэж үзвэл хүн бүр сайн байх байсан. Ингэсэн тохиолдолд сайн сайхны төлөө программчлагдсан хүн сэтгэл санаа, хүсэл зориггүй болж, сайн муу гэх хувилбаруудыг бий болгох шаардлагагүй болно. Гэсэн хэдий ч Аллах бүх зүйлийг эсрэгээрээ бүтээсэн юм. Эсрэг нөхцөл байдал бүр бидэнд сайн сайхныг үнэлж, түүнд хандах боломжийг олгодог. Муу муухай байгаа газар сайн сайхны, муухай зүйлийн дэргэд гоо үзэсгэлэнгийн, там байгаа газар диваажингийн үнэ цэнийг ойлгодог. Дээрээс нь энэ ертөнцийн харгислал, шударга бус байдал болон бузар мууг хойд ертөнцөөс хамааралгүйгээр бодох нь оюун санааны хувьд биднийг сэтгэл хангалуун байлгаж чадахгүй. Мэдээжийн хэрэг, бүхнийг мэдэгч Аллах дарангуйлагчийн харгислал, хэлмэгдэгсдийн зовлонг мэддэг. *"Зальхай этгээдүүдийн ааш авир, үйлдэл бүхнийг Аллах үл мэддэг гэж бүү бодогтун! Үнэндээ, Аллах тэдний гэсгээлийг айсандаа нүд нь бүлтрэх өдрийг хүртэл сунгаж буй болой."*⁵⁹ айлдварт энэ хорвоод сорилтод орсон хүмүүс зан авир үйлдлийнхээ төлөө жинхэнэ хариуг нь хүртэх өдөр ирнэ гэдгийг тодорхой илэрхийлсэн байна.

Аллахын нигүүлслээр муу муухайн оршихуй хэрхэн тайлбарлах тухайд ирвэл юуны түрүүнд Аллах өршөөл үзүүлэхийг өөрийн зарчим болгосон гэдгийг мэдэх хэрэгтэй.⁶⁰ *"Аллах оршихуйг бүтээхээр зарлиг буулгахдаа тэрээр өөрийн оршихуйд зарчим тогтоож: "Миний өршөөл миний уур хилэнг давсан нь эргэлзээгүй" хэмээсэн билээ.*⁶¹ Аллахын нигүүлсэл түүний уур хилэнг даван туулж байгаа нь түүний бүтээсэн бүх

59 Ибрахим, 14/42.

60 Ангам, 6/12.

61 Бухар, Бэдиул-халк, 1.

зүйлд өршөөл нигүүлсэл чухал гэдгийг харуулж байна. Энэ тохиолдолд бидний муу гэж үздэг үйл явдлын цаана, бидний харж болох эсвэл олж харах боломжгүй ашиг тус байдаг байна. Аллахын өршөөл заримдаа түүний нигүүлслээр ирдэг бол заримдаа муу муухай мэт санагдах үйл явдлуудтай хамт ирдэг. Тааламжгүй мэт санагдах үйл явдлуудад Аллахын нигүүлслийг ойлгохын тулд цаана нь байгаа утга агуулгыг олж харах хэрэгтэй.

Итгэн биширдэг хэрнээ мөргөл залбиралаа биелүүлдэггүй хүний байдал ямар байх бол ?

Үйлдэл нь итгэл бишрэлийн нэг хэсэг биш юм. Үйлдэл буюу намаз мөргөл байдгийг хүлээн зөвшөөрсөн боловч үүнийг хэрэгжүүлдэггүй хүнийг үл итгэгч (кафир) гэж нэрлэх боломжгүй.⁶² Куран ба сүннет дэх шашны үндсэн зарчим, зарлиг, цээрлэлийг үгүйсгэхгүй л бол хүн үйлдэл хөдлөлөөс болж шашнаас гарахгүй. Гэсэн хэдий ч тэрээр нүгэлтэн болж, Аллахын зарлигийг дагаж мөрддөггүй нэгэн болно. Хэрэв бидний Аллах Эзэн хүсвэл түүнийг уучилж хүсвэл шийтгэдэг юм. Хэдийгээр мөргөл залбирал нь итгэл үнэмшлийн нэг хэсэг биш ч гэсэн итгэлийн үр жимс нь хүмүүст Аллахын албат гэдгийг сануулдаг онцгой зан үйл юм. Хүн зөвхөн шүтэн мөргөж байж л итгэсэн бүтээгчдээ үнэнч гэдгээ харуулж чаддаг ба тууштай шүтэн биширч байж итгэл нь бэхэждэг байна. Хүмүүс мөргөл залбирлынхаа ачаар Аллахад ойртож, итгэл үнэмшлийн хүчийг мэдэрдэг.

62 Ислам шашны үндсэн мэдэгдэхүүнүүд, 1-р боть, 72- р хуу.

Итгэл бишрэл бол газарт тарьсан үр бол түүний ус, нар ба агаар нь үйлдэл (мөргөл залбирал) мөн. Яг л тарьсан үр нь усалгаагүй, хөрсийг нь агааржуулж, нар нь хүрэлцэхгүй хатдаг шиг байгаа байхгүйн ойлгогдохгүй газар доор үлдэж, магадгүй цагтаа алга болчих юм бол зүрх сэтгэл дэх итгэл нь мөн мөргөл залбиралгүйгээр суларч, цаг хугацаа өнгөрөх тусам хүмүүсийг итгэлийн шугамаас холдуулах хязгаарт хүргэдэг байна. Итгэл бишрэлийг ургаж, үр жимсээ өгөхийн тулд мөргөл залбирал үйлдэх хэрэгтэй.

Куран сударт "Итгэж, зөв сайн үйлс үйлдэгсэд"⁶³ гэсэн хэллэгийг олон газар ашигладаг. Итгэн биширсний дараа шууд зөв зан үйл, үйлдлийг онцлон мэдэгдэх нь Аллахын үнэнч албат байхын тулд зөвхөн зүрх сэтгэлээр итгэх нь хангалтгүй гэдгийг харуулж байна. Хүн өөрийн сүсэг бишрэл, ёс суртахуунаараа Аллаhad зохистой албат байхыг хичээвэл Аллах түүний муу муухай үйлийг халхавчлан, хийсэн үйлсийнх нь хамгийн сайнаар шагнах болно.⁶⁴

Ширк яагаад хамгийн том нүгэл вэ? Аллах яагаад ширкийг уучилдаггүй вэ ?

Толь бичигт "нөхөрлөл", "хамтрагч, нэгдэгч" гэсэн утгатай ба ширк гэдэг нь "бусадтай адилтгах, " гэсэн утгатай ширк нь куфур буюу үл итгэх гэсэн үг юм.

63 "Итгэж, зөвт үйлс үйлдэгсэд" гэсэн хэллэгийг тодорхой дурдсан зарим айлдваруудыг үзнэ үү. Бакара, 2/25, 62, 82, 277; Ал-и Ймран, 3/57; Ниса, 4/57, 122, 173; Майда, 5/9, 69, 93; Аграф, 7/42; Ганкабут, 29/58; Талак, 65/11 гэх мэт.

64 Ганкабут, 29/7.

Ширк үйлддэг хүнийг мүшрик гэж нэрлэдэг. Энэ нь "Аллах өөртэй нь шинж чанар, үйлдэл эсвэл мөргөл залбирал үйлдэхдээ түүнтэй адил эсвэл ижил төстэй хамтрагч бий гэдэгт итгэхийг хэлдэг юм."⁶⁵

Ширк бол Аллахад хийсэн маш том шударга бус явдал, ⁶⁶ Түүний эсрэг хийсэн хамгийн том гүтгэлэг юм. Тиймээс энэ нь хамгийн том нүгэл бөгөөд Аллах Эзэн энэ нүглийг хэзээ ч уучлахгүй. *"Аллах өөртэй нь бусдыг адилтгахыг хэзээ ч үл өршөөнө! Үүнээс бусад нүгэл хилэнцийг хүссэн ёсоор өршөөдөг. Хэн Аллахтай бусдыг эн зэрэгцүүлнэ гэвэл тэр маш хүнд нүгэл, гүтгэлэг үйлдсэн болно."*⁶⁷

Хүн орчлонд бүхнийг захирдаг хүч байдаг гэсэн ойлголтод хүрснийхээ дараа энэ хүчийг зөв танин мэдэж чадахгүй, зөвхөн Аллахад хамаарах бурханлаг шинж чанарыг бусад шүтээн оршлуудаас эрэлхийлж байгаа нь харамсалтай. Юм бүхнийг бүтээж, удирдаж буй Бурхан яагаад өөрт нь хамтрагч болох оршихуйг олж авдаг вэ эсвэл өөрт нь хөндлөнгөөс оролцохыг зөвшөөрдөг юм бэ? Ийм бодол нь Куран судар дахь бурханлаг үзэл болон Аллахад итгэх итгэлд харшилж байна.⁶⁸ Аллах Эзэн маань энэ үнэнийг маш тодорхой эшлэлүүдээр олон удаа давтсан байдаг: *"Аллахтай төстэй юу ч үгүй."* ⁶⁹, *"Түүнээс өөр ямар ч бурхан үгүй. Тэр бүхнийг бүтээгч."* ⁷⁰, *"Түүнтэй эн зэрэгцэх юу ч үгүй."*⁷¹

65 Мустафа Синаноглу, "Ширк", ДИА, 39- боть, 193- р хуу.

66 Лукман, 31/13.

67 Ниса, 4/48.

68 Бэкир Топалоглу, Юсуф Шэвки Яавуз, Иляас Чэлэби, *Исламын итгэл үнэмшлийн зарчмууд*, Чамлыжа хэвлэл, Истанбул, 2016, 83-86- р боть.

69 Шура 42/11.

70 Ангам, 6/102.

71 Ихлас, 112/4.

Нэмж дурдахад тэрээр хүний оюун санаанд шууд хандсанаар тэдний бурхан гэж үздэг зүйлийг ямар чадваргүй байдгийг ойлгохыг урьсан. "Та нарын Аллахыг орхиж, шүтэн тахисан зүйлс чинь бүгдээрээ нийлээд ганц ялааг ч бүтээж чадахгүй. Бүр ялаа тэднээс бие цогцсоос нэг юм булаахад тэд түүнийгээ ч буцааж авч чадахгүй."⁷²

Аллах хүнийг оюун ухааны эзэн болгон бүтээсэн. Тэрээр дэлхий дээр цорын ганц бүтээгч байдаг гэж тунхаглаж мөн хүнд энэ үнэнийг зөвөөр ойлгуулахын тулд элч нар болон судруудыг илгээсэн бөгөөд яагаад энэ дэлхий дээр өөр бүтээгч бурхан байж болохгүй гэдгийг тайлбарласан юм. Энэ бүхний дараа хүн ширкт үлдэхээр шийдсэн хэвээр байвал энэ нь маш том нүгэл бөгөөд ширкт ордог юм. Ширк гэдэг нь энэ утгаараа үл итгэхтэй тэнцэнэ. Учир нь ширк гэдэг нь Аллахын мөн чанарыг зөв таньж чадаагүй, үгүйсгэсэн гэсэн үг юм. Мөн хэзээ ч уучлахгүй нөхцөл байдал болж хувирдаг.⁷³

Их нүгэл үйлдэхэд Аллах намайг уучлах болов уу ?

Алдаа дутагдалгүй цорын ганц шүтээн бол Аллах юм. Хүн сайн мууг чиглэн бүтээгдсэн учраас⁷⁴ амьдралынхаа туршид алдаа гаргаж байдаг байна. Тэрээр Аллах Эзэнтнийхээ эсрэг алдаа гаргаж, талархалгүй хандаж чаддаг байна. Аллах нэн их

72 Хаж, 22/73.

73 Мустафа Синаноглу, "Ширк", ДИА, 39- р боть, 193-198-р хуу.

74 Шэмс, 91/8.

өршөөгч, Куран сударт Түүний өршөөл нь маш их бөгөөд ширкээс бусад бүх нүглийг уучлах болно гэж тодорхой бичсэн байдаг.⁷⁵

*“Аяа, өөртөө гай барцад хураасан боолууд минь! Аллахын хайр энэрлийн талаар итгэл бүү алдагтун! Аллах хүссэн хүнийхээ бүх нүглийг өршөөн хэлтрүүлдэг. Тэр нэн их өршөөгч, машид энэрэгч юм.”*⁷⁶ эшлэлд Аллах нүгэл үйлдэж, хэт туйлширч буй хүмүүсийг "миний боол" хэмээж, өршөөлд нь бүү цөхөр гэж зөвлөсөн нь их гайхамшигт мэдээ юм.

Том нүгэл үйлдсэн гэж бодож буй хүн, хамгийн түрүүнд Аллах Эзний өршөөхгүй нүгэл гэж байхгүй гэдгийг мэдэх хэрэгтэй. Нүгэл нь хэчнээн их байсан ч гэмшлийн хаалга үүд хэний ч өмнө хаагдахгүй. Хүний нэр төрийг гутаасан гэмт хэрэг гэгддэг садар самуун, архи, хулгай зэрэг томоохон нүгэл үйлдэгсдэд гэмшлийн үүд хаалга ч нээлттэй байдаг. Хамгийн гол нь алдаа, нүгэл үйлдсэндээ харамсаж, Аллахаас өршөөлийг чин сэтгэлээсээ наманчилж, уучлал гуйх явдал юм.⁷⁷

"Чин сэтгэлээсээ наманчлал" нь хийсэн алдааны өмнө цөхрөнгөө барсан хүмүүсийг тайвшруулж, өнгөрсөн амьдралын ул мөрийг арилгахын зэрэгцээ мөргөлийн байрыг эзэлдэг. Энэ шалтгааны улмаас Исламын эрдэмтэд нүглийг уучлахад чухал ач холбогдолтой наманчлалыг хүлээн зөвшөөрөх зарим асуудлыг онцолсон байдаг. Аллахын өмнө наманчлалыг хүлээн зөвшөөрөх эхний нөхцөл бол

75 Ниса, 4/116; Шура, 42/25, 30; Хижр, 15/49-50.

76 Зүмэр, 39/53.

77 Комисс, *Хадис бүхий итгэл*, Анкара, 2013, 2-р боть, 100-р хуу.

буруу үйлдлээ ухамсарлаж, харамсах явдал юм. Хийсэн нүглээ орхиж, дахин хийхгүй гэж хатуу шийдсэн нь гэмшсэн чин сэтгэлийг харуулдаг. Мөн өмнөх алдаагаа засахын тулд сайн үйлс хийхийг зөвлөдөг.

Нүглийн өршөөлд, үйлдсэн нүглийн мөн чанарт тохируулан хийх зүйл бий. Хэрэв нүгэл нь фарз залбирлыг орхихтой адил, Аллахын өмнө хүлээсэн үүргээ зөрчсөн нөхцөл байдал юм бол уучлагдахын тулд орхисон залбирлыг нөхөхийн тулд хүчин чармайлт гаргах хэрэгтэй. Өршөөгдөхийг хүссэн нүгэл нь хүн, нийгэм рүү чиглэсэн бол эрх нь зөрчигдсөн хүмүүсээс уучлал гуйх ба учруулсан хохирлыг арилгах зайлшгүй шаардлагатай.⁷⁸

Заримдаа би Аллах байдаггүй гэсэн төөрөгдлийн тухай боддог Би шашнаасаа гарах уу ?

Өөрийн эрхгүй санаанд орж, хүний сэтгэлийг зовоодог ийм бодлуудыг "төөрөгдөл" гэдэг. Эдгээр бодлууд нь хүний өөрийн муу сэтгэл эсвэл шэйтаны атгаг санаа юм. Энэ нь шашны итгэл үнэмшил, ойлголтын эсрэг байдаг тул хүнийг туйлын эвгүй байдалд оруулдаг. Хүний толгойд өөрийн эрхгүй орж ирдэг эдгээр муу бодол букуу төөрөгдөл нь хүн өөрөө оюун ухаанаараа хүлээн зөвшөөрөхгүй л бол итгэл үнэмшилд нь хор хөнөөл учруулдаггүй.⁷⁹

78 Адил Бэбэк, Нүгэл, ДИА, 14-р боть, 283-р хуу.

79 Мустафа Чагрыжы, "Төөрөгдөл", ДИА, 43-р боть, 70-72-р хуу.


ЗАЛУУЧУУДЫН ИТГЭЛ СҮСЭГ БИШРЭЛИЙН АСУУЛТУУД

Төөрөгдлийн асуудал нь сахабануудын санааг ч мөн адил зовоосон сэдэв болсон билээ. Тэдний зарим нь Элч дээр ирж, хэлж зүрхэлдэггүй төөрөгдөлтэй байна гэж гомдоллож байсан. Харин бидний Гэгээн Элч, санаа зовох хэрэггүй гэж хэлсэн бөгөөд энэ нь тэдний цэвэр итгэлийг илтгэнэ.⁸⁰ Тэрээр өөр нэгэн хадис дээр дурдсанчлан, хүн өөрт тохиолдсон муу бодол, төөрөгдлүүдийг амьдралд хэрэгжүүлэхээс нааш хариуцлага хүлээхгүй юм.⁸¹

.....
80 Мүслим, Иман, 209.

81 Бухари, Талак, 11.

Мелек буюу
ТЭНГЭРИЙН
ЭЛЧ НАРТ
ИТГЭХ
ИТГЭЛ



Тэнгэрийн элч нар байдаг уу, тэд ямар төрлийн оршихуй вэ ?

Исламын итгэл үнэмшлийн нэг үндэс бол тэнгэр элчнүүдэд итгэх итгэл юм. Куран сударт олон эшлэлд сахиусан тэнгэрүүд, тэдгээрийн шинж чанар, үүрэг, түүнчлэн тэнгэрийн элч нар байдаг гэдэгт итгэх итгэлийн талаар дурдсан байдаг. "Аллахын элч болон итгэгчид Аллах Эзнээсээ түүнд илчлэгдсэн зүйлд итгэсэн. Тэд бүгд Аллахад, мэлэжүүдэд, номуудад, гэгээн элчнүүдэд төгс итгэцгээсэн..."¹Түүнчлэн сахиусан тэнгэрүүдэд итгэх хэрэгтэй гэж заасан байдаг. "Аяа сүсэгтнүүдээ! Аллахад, Түүний элч нарт, тэдэнд илгээсэн ариун сударт итгэцгээгтүн. Хэн Аллахад, Түүний мэлэжүүдэд, ариун судруудад, гэгээн элч нарт үл итгэж, ертөнцийн төгсгөлийн өдрийг үгүйсгэвэл үнэнхүү төөрөгдөлд орно." ²

Гэгээн Элчээс (с. а. у) "Итгэл гэж юу вэ? " гэж асуухад "Итгэл бол Аллахад, Түүний сахиусан тэнгэрт, Түүний ном судруудад, элч нар, эцсийн өдөр, сайн муу хувь заяанд итгэх явдал юм." гэж хариулсан юм.³ Бид тэнгэрийн элч нарт итгэх итгэл, сахиусан тэнгэрүүд оршин байдаг гэдгийг Куран судар ба хадисуудын тодорхой илэрхийллээс ойлгодог. Аллахын зүгээс

1 Бакара, 2/285.

2 Ниса, 4/136.

3 Мүслим, Иман, 1.

бидэнд илгээсэн судар бүхэн зөв бөгөөд үнэн юм. Амьдралдаа худал хэлж үзээгүй бидний Гэгээн Элч (с. а. у.) сахиусан тэнгэрүүд байдаг тухай бидэнд мэдээлсэн нь уахид суурилсан мэдээлэл юм. Энэ тохиолдолд сахиусан тэнгэрүүд байгаа нь эшлэл, хадисээр тодорхойлогддог.

Бид тэднийг харж чадахгүй ч элч нар, сахиусан тэнгэрүүдийг харж уулзсан юм. Тэнгэр элч болох Жэбраил (а. с.) -аар дамжуулан тэнгэрлэг илчлэлийг (уахиг) хүлээн авсан юм. Энэ нь бүх элч нарын хувьд хүчинтэй билээ. Ийм учраас бүх бурханлаг шашинд тэнгэр элч нарт итгэх итгэл нь байдаг байна.

Тэнгэрийн элч нар мэдрэхүйгээр харагдах, мэдрэхээс хол байдаг тул шинжлэх ухаанд байдаг шиг сахиусан тэнгэрүүд байдаг гэдгийг нотлох боломжгүй юм. Гэсэн хэдий ч оюун ухаан нь итгэлийн ийм асуудалд тухайн сэдвийн бодит байдлыг ойлгох үүрэгтэй юм. Хэдийгээр оюун ухаан нь сахиусан тэнгэрүүд оршин буй эсэхийг ямар ч нотлох баримтаар хангаж чадахгүй ч сахиусан тэнгэрүүд байгаа эсэх талаар дүгнэлт хийж чадна. Энэ тохиолдолд Аллаhad ийм оршихуйнуудыг бүтээх хүч байгаа нь хамгийн эхний гарах цэг юм. Эцсийн эцэст, бидний бие махбодын оршин тогтнолд ч гэсэн Аллах Эзэн бидний харж чадахгүй олон оршихуйнуудыг бүтээсэн билээ. Амьдрал шиг, оюун ухаан шиг... Үүний нэгэн адил, Тэр ертөнц дэх олон оршихуйнуудыг бий болгож чадна. Оюун ухаан нь сахиусан тэнгэрүүдийг оршин тогтнох боломжтой гэж хардаг. Боломжгүй гэж үздэггүй.

Дүгнэж хэлэхэд, бидэнд оюун ухаан, сэтгэл, амьдрал байдаг шиг сахиусан тэнгэрүүд бас байдаг.⁴

Тэнгэрийн элч нарыг бид нүдээрээ харж чаддаггүй болохоороо бид Куран судар болон хадисуудаар дамжуулан тэдний тухай мэдээллийг олж авах боломжтой. Куран судар болон хадисуудад дурдсанчлан;

- 1- Тэнгэр элч нар туяанаас (цацралаас) бүтээгдсэн юм.
- 2- Эр, эм, идэж уух, ядрах зэрэг хүний шинж чанар байхгүй.
- 3- Тэд Аллахын тэдэнд өгсөн үүрэг даалгаврыг гүйцэтгэдэг. Тэд Аллахын зарлигаас хэтэрдэггүй.
- 4- Тэд маш хүчтэй, хурдан хөдөлдөг оршихуй юм.
- 5- Хэвийн нөхцөлд тэдгээр нь нүдэнд харагдахгүй.
- 6- Аллахын зөвшөөрлөөр сахиусан тэнгэрүүд янз бүрийн хэлбэр, хувилбарт орж чаддаг. Энэ тохиолдолд тэдгээрийг хүн харж болно.
- 7- Тэнгэр элч нар гайб буюу ирээдүйг мэддэггүй. Тэд зөвхөн Аллахын тэдэнд өгсөн мэдээллийн хүрээнд мэддэг.⁵

4 А. Арслан Айдин, "Тэнгэрийн элч нар ба тэдний Ислам дахь байр суурь", *Дияанет Илми сэтгүүл [Турк Улсын шашны хэрэг эрхлэх ерөнхий газрын сэтгүүл]*, 1966, V-р боть, тоо: 11, 301-304-р хуу.

5 Бэкир Топалоглу, Юсуф Шэвки Явуз, Илиас Чэлэби, *Ислам дах итгэл үнэмшлийн зарчим*, 218-р хуу.

Тэнгэрийн элч нарын үүрэг юу вэ ?

Аллах Эзэн ямар ч зүйлийг дэмий хоосон бүтээгээгүй юм. Тиймээс сахиусан тэнгэрүүдийг бүтээхэд нь зорилго бий ба зорилгодоо нийцүүлсэн үүрэг даалгавартай байдаг. Тэнгэр элч нарын үүрэг бол Аллахыг магтан алдаршуулах, Түүнд сөгдөн мөргөдөг билээ.⁶ Элч нарт болон итгэгсдийг Бадирийн тулалдаанд тусалсантай адил хэцүү цаг үед нь дэмжих,⁷ үхлийн үед үл итгэгсдийг зэмлэж, итгэгсдэд диваажингийн сайн мэдээг дуулгах,⁸ Аллахаас тэдэнд өгсөн тушаалуудыг биелүүлэх,⁹ Элч нарыг өргөмжлөн хүндэтгэн амрыг айлтгаж, мүминчүүдийн төлөө уучлалт гуйдаг¹⁰ гэдгийг дурдах боломжтой.

Тэнгэрийн элч нарын зарим нь илүү тодорхой үүрэг хариуцлагатай байдаг. Жабраил элч, Аллах болон түүний Гэгээн элч нарын хооронд элчийн үүрэг гүйцэтгэдэг. Азраил; үхлийн цаг нь болсон хүмүүсийн амийг авч одох, Микаил; байгалийн үйл явдлыг зохицуулах, харин Исрафил ертөнцийн төгсгөлд Аллахын зарлигаар бүрээ үлээх үүрэг хүлээнэ.¹¹ Кирамин Катибин гэгддэг бичээч сахиусан тэнгэрүүд хүмүүсийн баруун ба зүүн талд байдаг бөгөөд тэдний хийж буй бүх зүйлийг бүртгэх

6 Аграф, 7/206; Анбия, 21/19-20.

7 Ал-и Имран, 3/123-125.

8 Анфал, 8/50; Фуссилат, 41/30-31.

9 Нахыл, 16/50.

10 Ахзаб, 33/56; Мүмин, 40/7-8.

11 Бэкир Топалоглу, Юсуф ШэвкиЯвуз, Иляас Чэлэби, *Ислам дах итгэл үнэмшлийн зарчим*, Турк улсын шашны хэрэг эрхлэх газрын хэвлэл, Анкара, 2015, 216-226-р хуу. Мөн үзнэ үү. Камил Гүнэш, *Сахиусан тэнгэрүүдэд итгэх итгэл*, Турк улсын шашны хэрэг эрхлэх газрын хэвлэл, Анкара, 2018, 43-63-р хуу.

үүрэгтэй.¹²Мүнкар, Нэкир хоёр нь үхлийн дараа булшинд хүмүүсийг байцаах үүрэгтэй,¹³ диваажин ба тамд мүминчүүдийг угтах,¹⁴ тамын хүмүүст хүртэх ёстой шийтгэлээ амсуулах үүрэгтэй тэнгэр элч нар¹⁵ болон сансар огторгуйг хүрээлэн буй болон түүний эргэн тойронд нь мелекууд¹⁶ бий. Үүний үр дүнд тэнгэрийн элч нар Аллах тэдэнд өгсөн аливаа үүрэг даалгаварыг гүйцэтгэдэг. Аллах хүсвэл тэнгэрийн элчид нэгээс олон даалгавар өгч болно.¹⁷

Бид сахиусан тэнгэрүүдийн тухай мэдээллийг Куран судар болон Суннагаас олж авсан болохоор энэ хоёр эх сурвалжид мэдээлсэн зүйлсээс дээр дурдсан мэдээллүүдийг жишээ болгон сонгосон болно. Бидний нэр, үүргийг мэдэхгүй хэчнээн олон сахиусан тэнгэр байдгийг зөвхөн Аллах л мэднэ.

Бид сахиусан тэнгэрүүдийг харж чадах уу ?

Тэнгэр элч нар бол метафизик оршихуй юм. Тэд нур буюу ариун туяанаас бүтээгдсэн юм. Бид тэдгээрийг харж чадахгүй, мэдрэхүйн эрхтний тусламжтайгаар хүлээн авах боломжгүй. Тэд алга болсондоо биш, харин бидний нүд тэднийг харах чадвараар бүтээгдээгүй учраас бид харж чадахгүй. Гэсэн хэдий ч тэнгэр элчнүүдийг Гэгээн Элч нар жинхэнэ дүр төрхөөрөө харсан билээ.

12 Зухруф, 43/80; Каф, 50/17-18; Инфитар, 82/10-11.

13 Тирмизи, Жэнаиз, 70.

14 Рад, 13/23-24; Анбия, 21/103; Зумар, 39/73.

15 Зумар, 39/71-72; Тахрим, 66/6; Мүддассир, 74/30-31.

16 Зумар, 39/75; Мүмин, 40/7; Хакка, 69/17.

17 Энэ сэдвийн талаар харна уу Мэхмэт Сайт Өзэрварли, "Мелек (Тэнгэрийн элч) ", ДИА, 29-р боть, 40-42-р хуу.

Аллах Эзний зөвшөөрлөөр тэнгэрийн элч нар янз бүрийн дүр төрх, хуваарилалтад орж чаддаг. Хэрэв тэд анхны хэлбэрээ орхиж, өөр хэлбэрт орж, тухайлбал хүний дүрд орвол бусад хүмүүст харагдах боломжтой байдаг. Жишээлбэл, Жибрил хадис гэгддэг итгэл, Ислам, ихсан гэсэн ойлголтуудыг тодорхойлсон хадис дотор сахиусан тэнгэр болох Жабраилийг, Асхаб хүний дүр төрхөөр харсан билээ.¹⁸ Куран судар дахь сахиусан тэнгэрүүд, Хз. Ибрахимд хүүтэй болно гэсэн баярт мэдээг хүний дүрд хувиран өгсөн тухай дурдсан байдаг.¹⁹ Хэдийгээр элч биш ч Жэбраил нь Хз. Мариямд хүний дүрээр үзэгдсэн²⁰ нь Куран сударт дурдсан байдаг.²¹

Бид сахиусан тэнгэрүүдийг хиймэл оюун ухаан гэж ойлгож болох уу? Тэнгэрийн элч нар робот эсвэл радио долгионтой төстэй байдаг уу?

Тэнгэрийн элч нар бол бидний мэдрэхүйгээр хүлээн авах боломжгүй оршихуй юм. Ийм учраас бид тэдний тухай зөвхөн Куран судар ба Суннагаас л мэдээлэл авдаг. Бакара сурегийн 30-р эшлэлд Аллаx ийнхүү айлддаг: *"Нэгэнтээ Эзэнтэн чинь Мэлэкүүдэд буюу тэнгэрийн элчнүүддээ хандан, "Би газар дэлхий дээр залгамжлагчаа бүтээнэ" гэжээ. Мэлэкүүд: "Газар дэлхийд үймээн самуун дэгдээж, цус урсгах нэгнийг бүтээх юм биш биз? Чухамхүү бид Чамайг онцгой хүндэтгэн дээдэлж, ариун шүтээн*

18 Мүслим, Иман, 1.

19 Худ, 11/69-70.

20 Мариям, 19/16-17.

21 М. Сайт Өзэрварлы, "Мелек", ДИА, 29-р боть, 40-42-р хуу.

хэмээн эрхэмлэдэг” гэжээ. Хариуд нь Аллах: “Үнэндээ Би та нарын мэдэхгүйг мэднэ” гэв. Энэ эшлэлээс бид Аллах, тэнгэрийн элч нарыг хүн төрөлхтнөөс өмнө бүтээсэн бөгөөд тэнгэр элч нар Аллахыг шүтэн мөргөдөг (юмс үзэгдлийг танин мэдэж тэдгээрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэлт хийх) ухамсартай оршлууд гэдгийг тодорхой ойлгож байна. Хиймэл оюун ухаан, роботыг хүн зохион бүтээж, үйлдвэрлэдэг болохоор сахиусан тэнгэрүүдийг хиймэл оюун ухаан гэж үзэх боломжгүй юм. Тэнгэрийн элч нар ухамсартай (юмс үзэгдлийг танин мэдэж тэдгээрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэлт хийх ухамсартай) оршихуйнууд учраас тэдгээрийг радио долгион гэж үзэх боломжгүй юм.

Бид ямар зүйл гэдгийг ойлгож чадахгүй байгаа оршихуйнуудыг мэдрэхүйн эрхтнүүдтэй харьцуулах нь биднийг буруу итгэл үнэмшилд хүргэдэг. Тэнгэрийн элч нарын тухай мэдээллийн ганц эх сурвалж бол вахи байдаг тул бид Аллахын хэлснээр тэнгэрийн элч нарыг өөр ямар ч биеттэй харьцуулахгүйгээр тэдэнд итгэх ёстой. Тэнгэрийн элч нарыг хиймэл оюун ухаан, радио долгион гэж хүлээн зөвшөөрч болно гэсэн нотолгоо Куран судар болон Суннад байдаггүй билээ.

Тэнгэрийн элч нарт итгэх нь миний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлдөг вэ ?

Аллахын бүтээсэн оршихуйнууд зөвхөн мэдрэхүйн хүрээнд хязгаарлагдахгүй. Тэнгэрийн элч нар бол метафизикийн ертөнцөд хамаарах оршихуйнууд

юм. Тэнгэрийн элч нарт итгэх нь орчлон ертөнц зөвхөн материаллаг ертөнцөөс тогтдоггүй бөгөөд Аллах бие махбодоос гадна метафизик ертөнцийг бүтээсэн гэдгийг ойлгоход хялбар болгодог. Өөрийгөө бие махбод ба амин сүнсээр бүтээгдсэн, материаллаг болон оюун санааны аль алиныг нь эзэмшсэн гэдгээ ухаарсан хүн Аллах түүнийг бүтээж, бие даан амьсгалж ч чадахааргүй сул дорой гэдгээ олж харна. Энэ ухамсраараа тэрээр Аллахын зохистой албат болохын тулд хичээн зүтгэж, хойд ертөнцийн амьдралын бэлтгэлийг хийдэг.

Түүнийг харж хянадаг, хайрлаж хамгаалж байдаг сахиусан тэнгэрүүд байгаа нь хүмүүст аюулгүй байдлын мэдрэмжийг өгдөг. Аллах өөрийг нь үл үзэгдэх туслагчдаар хамгаалж, дэмждэг гэдэгт итгэдэг хүн Аллахын хайрыг мэдэрч, энэ хайрыг хүртэхийн тулд чадах бүхнээрээ хичээдэг. Тэнгэрийн элч нар, бузар мууг төөрөлдүүлэх гэсэн шейтаны оролдлогын эсрэг сайн сайханд хөтөлдөг дэмжигчид гэдгийг мэдэх нь хүнийг тайвшруулж, хүчирхэг болгодог. Тэнгэрийн элч нар Аллахын өгсөн зарлигаас хэтэрдэггүй, зөвхөн Аллахыг алдаршуулах үүрэг хүлээсэн мелекүүд (сахиусан тэнгэрүүд) байдаг гэж бодох нь хүмүүсийг боолчлолоос холдуулах зүйлд хандахаас сэргийлдэг. Өөрийгөө Аллах байнга харж байдаг, үйлдлүүд нь бичигдэж байдаг гэдгийг мэддэг хүн алдаа гаргахад бэрхшээлтэй байдаг. Хийсэн үйлс нь хожим нь (ахирет ертөнцөд) өөрт нь үзэгдэж, тэндээ амьдралаа залгуулна гэж бодно алдаа гаргахаас зайлсхийдэг.

Тэнгэрийн элч нарт итгэхгүй байх нь миний итгэл бишрэлд ? хор хөнөөл учруулах уу

Тэнгэрийн элч нарын оршихуйг хүлээн зөвшөөрөх нь итгэл бишрэлийн нэг зарчим нь юм. Энэ тухай олон эшлэл байдаг: *"Гэгээн элч өөртөө Дэзтнээс илгээсэн сударт итгэсэн. Сүсэгтнүүд ч итгэсэн. Тэд бүгд Аллахад, мэлэжүүдэд, түүний номуудад, гэгээн элчнүүдэд төгс итгэцгээсэн..."*²² Куран сударт тодорхой заасан сахиусан тэнгэрүүдийн оршихуйг үгүйсгэх нь хүнийг шашингүй болгодог. Учир нь тэнгэрийн элч нарт итгэхгүй байна гэдэг нь Гэгээн элч нарыг, Гэгээн элч нарын авчирсан номыг, түүний дамжуулсан шашныг үгүйсгэж байна гэсэн үг. Учир нь шашны зарлигуудыг тэнгэрийн элчнүүдээр дамжуулан Гэгээн элч нарт илгээсэн юм.²³

Хэрэв Аллах бүхнийг чадагч юм бол яагаад сахиусан тэнгэрүүдээр бүхнийг хийлгэдэг вэ ?

Аллах өөр өөр шинж чанартай (юмс үзэгдлийг танин мэдэж тэдгээрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэлт хийх) ухамсартай ба ухамсаргүй, амьд ба амьгүй амьтдыг бүтээхийг хүссэн. Эдгээр оршихуйнуудын дунд сахиусан тэнгэрүүд биет ертөнцөд бус метафизик ертөнцөд харьяалагддаг бөгөөд хүсэл зориггүй, зөвхөн тэдэнд өгөгдсөн зүйлийг л хийдэг юм. Аллах тэнгэр элчнүүдийг, хүн төрөлхтнийг бүтээх явцад гэрч болгон,²⁴ тэдэнд

22 Бакара, 2/285.

23 А. Намди Аксэки, *Исламын шашин*, Анкара, 1983, 70-р хуу.

24 Бакара, 2/30.

орчлон ертөнцийн цэгц дарааллаар зарим үүрэг даалгаврыг өгсөн юм. Хүн төрөлхтнөөс бусад өөр өөр оршихуйн Аллахын сул дорой байдлыг харуулахгүй, харин ч эсрэгээрээ Түүний хүч чадал ба агуу байдлыг илтгэнэ.

Хэдийгээр маш олон янз байдаг ч эрдэмтдийн "космос буюу сансар огторгуй" гэж нэрлэдэг оршихуйнуудын хоорондын энэхүү зохицол нь орчлон ертөнцийн төгс төгөлдөр байдлыг илтгэдэг. Хэдийгээр бид орчлон ертөнц дэх дэг журмын нарийн төвөгтэй байдлыг бүрэн ойлгож чадахгүй ч энэ нь Аллахын оршин тогтнол болон агуу байдлын хамгийн чухал нотолгооны нэг юм. Аллах Өөрийн алдар сууг таниулахын тулд орчлон ертөнц болон түүн доторх оршихуйнуудыг бүтээсэн юм.²⁵ Аллах Эзний хувьд хүн төрөлхтөн, тэнгэрийн элч болон бусад оршихуйнуудын бүтээлийн хооронд ялгаа байхгүй билээ. Учир нь Аллах Эзэн хүссэнээ зүй ёсоор нь бүрэн гүйцэтгэгч,²⁶ Тэр болгоосон зүйлээсээ болж байцаагдахгүй. Зөвхөн Тэр л бусад оршихуйг байцаан шүүх болно.²⁷

Аллах Эзэн бүтээсэн оршихуйнуудын дунд өөрийн хүссэнээр дэг журам тогтоож, энэ дарааллаар тэрээр хүмүүст зарим үүрэг хариуцлагыг ноогдуулаад зогсохгүй, сахиусан тэнгэрүүдэд ч гэсэн тодорхой үүрэг даалгавар өгсөн юм. Энэ тохиолдолд тэрээр тэнгэрийн элч нарт янз бүрийн үүрэг даалгавар өгч, тэдний заримыг нь хүний хийсэн үйлдлийг гэрчлэх, хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх зуур

25 Талак, 65/12.

26 Худ, 11/107; Буруж, 85/16.

27 Анбия, 21/23.

үгүйсгэхгүй байхаар томилсон юм: "Аль эсвэл тэд өөрсдийнх нь нууц санааг, далд яриаг нь Бид сонсдоггүй хэмээн бодно уу? Тийм биш ээ (бид сонсдог). Бидний элч мэлэкүүд (Хафаза нар) тэдний хийсэн бүхнийг нь бичиж байдаг юм."²⁸ Эсрэгээрээ бидний Эзэнд тэнгэр элч нарын тусламж хэрэггүй. Учир нь Аллах аливаа юмыг бүтээхийг хүсвэл, ердөө л "Болтугай" хэмээхэд хангалттай. тэр даруй ёсоор болдог.²⁹

Азраил хүн бүрийн амийг авдаг бол нэгэн зэрэг нас барсан хүмүүсийн амийг хэн авдаг вэ ?

Азраил бол үхэх цаг нь болсон хүмүүсийн амийг авдаг сахиусан тэнгэр, өөрөөр хэлбэл Куран сударт айлдсанаар амь авдаг мелек юм. Тэдэнд: "Та нарын амийг авахын төлөө томилогдсон **үхлийн сахиусан тэнгэр** үүнийг гүйцэтгэнэ. Тэгээд Эзэнтэн рүүгээ эргэж буцах болно" хэмээн хэлэгтүн.³⁰

Азраил нэгэн зэрэг нас барсан хүмүүсийн амийг хэрхэн авдаг тухай хоёр тайлбар бий. Эдгээрийн эхнийх нь үхлийн сахиусан тэнгэр бол ганцаараа биш юм. Куран судрын зарим эшлэлд хүмүүсийн амин сүнсийг авдаг сахиусан тэнгэрүүдийг олон тоогоор дурдсан байдаг.³¹ Энэ тохиолдолд Азраил ганцаараа үүргээ гүйцэтгэдэггүй, харин ижил үүрэг хүлээсэн бусад мелекүүд буюу сахиусан тэнгэрүүдтэй хамт гүйцэтгэдэг юм. Өөрөөр хэлбэл,

28 Зухруф, 43/80.

29 Бакара, 2/117. Мөн үзнэ үү. Ал-и Имран, 3/47, 59; Ангам, 6/73; Нахыл, 16/40; Мариям, 19/35; Ясин, 36/82; Мүмин, 40/68.

30 Саждэ, 32/11.

31 Ниса, 4/97; Ангам, 6/61; Анфал, 8/50; Мухаммед, 47/27.

Азраил олон туслахтай. Энэ үзэл бодлыг илүүд үздэг байна.³²

Өөр нэг тайлбараар (бид тэнгэр элчүүдэд итгэх итгэлийн тухай бүлгийн эхэнд тайлбарласан) сахиусан тэнгэрүүд бол хүчирхэг оршихуй юм. Тэд үүргийнхээ дагуу тэс өөр шинж чанартай байж магадгүй юм. Тиймээс Азраилийн хувьд нэгэн зэрэг нас барсан хүмүүсийн амийг авах нь хэцүү бас боломжгүй зүйл биш юм. Хүмүүсийн хувьд хоёр газар зэрэг байж, маш богино хугацаанд хол зам туулна гэдэг боломжгүй ч сахиусан тэнгэрүүдэд ч ийм байдаг гэж үзэх нь буруу зүйрлэл болно. Тиймээс Азраил өөрт нь өгөгдсөн энэ үүрэг даалгаврыг хялбархан гүйцэтгэж чадна.³³

Яагаад сахиусан тэнгэрүүдийг дандаа далавчтай охидоор дүрсэлсэн байдаг вэ, тэд хүйстэй юу ?

Тэнгэрийн элч нарт хүйсийн ялгаа үгүй. Куран сударт Аллах Эзэн сахиусан тэнгэрүүдийг охид гэж ойлгож, Алладын охид гэж үздэгийг шүүмжилдэг. *"Эзэнтэн та нарт зөвхөн хөвгүүдийг заяаж, сахиусан тэнгэрүүдээ өөрийн охид болгон авсан гэж үү? Тийм биш ээ, та нар мэдэхгүйгээр үнэхээр дур зоргоор ярих юм."*³⁴ Өөр нэг эшлэлд, *"Тэд энэрэн нигүүлсэгч Алладын боолууд болох мэлэкуудийг ч эмэгтэй хэмээн зүйрлэв. Мэлэкууд буюу сахиусан тэнгэрүүд бүтээгдэхэд тэд*

32 Рэжэп Ардоган, *Системчилсэн теологи ба орчин үеийн итгэл үнэмшил асуудлууд*, 250-р хуу.

33 Рэжэп Ардоган, *Системчилсэн теологи ба орчин үеийн итгэл үнэмшил асуудлууд*, 250-р хуу.

34 Исра, 17/40.

хажууд нь байж, гэрчлэн харсан гэж үү? Тэдний (худал) гэрчлэл бүхэн үйлийн дэвтэрт бичигдэнэ. Төгсгөлийн өдөр тэд шүүгдэх болно. " ³⁵ Ийм бодолтой байгаа хүмүүсийг (төгсгөлийн өдөр) тэд шүүгдэх болно гэж заасан. Энэ эшлэлд дурдсанчлан, сахиусан тэнгэрүүд ч бас хүн, жин шиг Алладын албат юм. Зөвхөн тэдний оршихуйн шинж чанар нь хүнээс ялгаатай юм.

Тэнгэрийн элч нарыг далавчтай хэмээн Куран сударт өгүүлсэн байдаг. "Бүхий л магтаал тэнгэр, газрыг бүтээгч хоёр, гурав, дөрвөн далавчтай мэлэктүүдийг тэнгэрийн элч болгон илгээсэн Аллахад хамаарагдана. Аллах бүтээхээр таалсныгаа өргөмжилдөг. Аллахын хүч чадал эргэлзээгүй алив бүхэнд хүрдэг." ³⁶ Тэнгэр элч нарын далавчны мөн чанар, хэлбэрийг бид тодорхой мэдэхгүй ч тэднийг үүргээ аль болох хурдан биелүүлэх боломжийг олгодог хүч чадлын бэлгэдэл гэж үзэж болно.

Тэнгэрийн элч нарыг шоолж, "Азраил шаргуу ажилладаг, Исрафил амралттай байгаа" гэх мэт үгсийг ашиглах нь миний итгэл үнэмшилд хохирол учруулах уу ?

Тэнгэрийн элч нарт итгэх итгэлийн сэдэв болон итгэл үнэмшлийн бусад асуудлын талаар бодохгүйгээр ярих нь бидний итгэлийг гэмтээж болно. Ийм нөхцөл байдал Гэгээн элчийн үед тохиолдож, мұнафик (хоёр нүүрт) хүмүүсийг

.....
³⁵ Зухруф, 43/19.

³⁶ Фатыр, 35/1.

дараах эшлэлээр сэрэмжлүүлжээ. "Хэрэв тэднээс (доромжлон дооглож буй учрыг) асуувал тэд: "Бид зүгээр л тоглосон" гэнэ. Тэдэнд: "Та нар Аллах хийгээд Түүний айлдваруудыг, бас Түүний Элчийг доромжлон тохуурхах гэж үү дээ? " хэмээн асуугтун. Шалтгаан хэлэх гэж бүү оролд. Та нар сүсэглэж итгэснийхээ дараа урван тэрсэлцгээсэн... " ³⁷ Эдгээр эшлэл дэх сэрэмжлүүлэг нь мұнафик хүмүүст зориулагдсан боловч итгэгчдийг хамарч, шашин шүтлэг, итгэл үнэмшлийн асуудлыг шоолохоос сэрэмжлүүлдэг.

Хэрэв "Азраил шаргуу ажилладаг, Исафил амралттай байгаа" гэх мэт үгс нь сахиусан тэнгэр, Азраил, кияамет ба ахирет ертөнцийг тохуурхах гэж байгаа бол энэ нь хүнийг итгэл бишрэлийн хүрээнээс гарахад хүргэдэг. Хэдийгээр энэ нь зөвхөн хошигнол хийх зорилготой байсан ч (үгүйсгэх, тохуурхах, доромжлох зорилгоор биш) тааламжгүй бөгөөд эдгээр үгс итгэл үнэмшлийг гэмтээж болзошгүй юм.³⁸

Сахиусан тэнгэр ба жин нар хүмүүсийн мэдэхгүй зүйлийг мэддэг үү ?

Мэдрэмж болон оюун ухаанаараа хүрч чаддаггүй өнгөрсөн ба ирээдүйн тухай бидний сонирхдог мэдээлэл байдаг. Хүмүүсийн оюун ухаанаараа хүрч чадахгүй байгаа энэ мэдээллийг Куран сударт "гайб(үл үзэгдэх, үл мэдэгдэх) " гэж илэрхийлсэн байдаг.

37 Тауба, 9/65, 66.

38 Ахмет Саим Килавуз, *Итгэл бишрэл доромжлолын хязгаар*, Марифэт хэвлэл, Истанбул, 1984, 106-130-р хуу.

Гайб-тай холбоотой мэдээллийг зөвхөн "Аллах мэддэг" ба "Аллахын мэдэхийг зөвшөөрсөн хүмүүс мэддэг" гэж хоёр хуваадаг. Зөвхөн Аллахын мэддэг хэсгийг "мутлак гайб" гэж тодорхойлдог. Мүмин хүмүүсийн хувьд хамгийн чухал онцлог нь энэ мэдээлэлд итгэх ёстой явдал юм.³⁹ Хүн, мелек, жин болон бусад оршихуй энэ мэдээлэлд хүрэх боломжгүй юм.⁴⁰

Хүмүүсийн хувьд гайб ба Аллахын дэргэд нуугдаж буй бүх мэдлэг нь жин болон мелекийн хувьд ч үл үзэгдэх гайб юм. Гэсэн хэдий ч, сахиусан тэнгэр болон жин нь хүмүүсээс өөр оршихуй юм. Метафизик оршихуй байх нь, илүү хурдан хөдөлж, урт наслах нь хүмүүст байхгүй мэдээллийг олж авах боломжийг олгодог. Эдгээр шинж чанаруудыг үл харгалзан бид Аллахын зөвшөөрөлгүйгээр гайбтай/үл үзэгдэх мэдээлэлд хүрэх боломжгүй гэдгийг Куран судраас мэддэг. Куран сударт Аллахын *"Би газар дэлхий дээр залгамжлагчаа бүтээнэ"* гэсэн үгийн дараа тэнгэр элчнүүдийн *"Адамын үеийнхэн газар дээр цус урсгах болно гэсэн таамаглал нь"*⁴¹ тэнгэрийн элчнүүд хүмүүсийн мэдэхгүй зүйлийн талаар мэдлэгтэй болохыг илтгэх эшлэлүүдийн нэг юм. Гэсэн хэдий ч энэхүү мэдлэг нь туйлын бөгөөд хязгааргүй гэдгийг *"Бакара"* бүлгийн 32-р эшлэлд тэнгэрийн элч нарын хэлээр *"(Бидний Эзэн) Бид чамайг бүх төгс бус байдлаас ангижруулж байна. Бид Чиний зааж сургаснаас өөр зүйлийг мэдэхгүй. "Энэхүү хүлээн зөвшөөрөлт нь тэнгэрийн элчнүүдэд*

39 Бакара, 2/3.

40 Маида, 5/109, 116; Ангам, 6/73; Тауба, 9/94, 105; Рагьд, 13/9; Саба, 34/48.

41 Бакара, 2/30.

Аллахын зөвшөөрснөөс өөр зүйлийг мэддэггүйг харуулж байна.

Исламын эрдэмтдийн үзэж байгаагаар жиннүүд ч мөн мутлак гайбыг мэддэггүй. Гэсэн хэдий ч тэд урт насалдаг ба тэнгэрийн элчнүүдээс мэдээ олж авч чаддаг тул хүмүүсийн мэддэггүй зарим асуудлыг мэддэг байх магадлалтай юм.⁴² Куран судар дахь Жинн Суре 8-9-р эшлэлүүдэд өмнө нь жинд тэнгэрээс мэдээлэл авдаг байсан бол одоо мэдээлэл авч чадахааргүй хориглогдсон болохыг илэрхийлсэн байдаг билээ. Саба бүлэгт шаргуу хөдөлмөр эрхэлдэг жиннүүдийг Хз. Сүлэйман нас барсныг анзаарч чадаагүй нь гайбыг мэддэггүй гэдгийг онцлон илэрхийлж байна.⁴³

Аллах яагаад шэйтаныг бүтээсэн бэ ?

Шэйтаныг бүтээхэд Аллах Эзэн бузар мууг хүсэх, хүмүүсийг төөрөгдөлд амархан оруулахтай холбож болохгүй. Орчлон ертөнц болон түүний доторх бүх зүйлийг бүтээхэд бидний мэддэг эсвэл мэдэхгүй олон учир шалтгаан/шалтгаанууд байдаг. Шэйтаны бүтээлд бас ийм учир шалтгаан/шалтгаанууд нуугдаж байдаг. Үүний нэг нь хүнийг харгалзан авч үзвэл дараах байдлаар тайлбарлаж болно.

Хүн ертөнц дээр сорилт туршилтад оршдог юм. Туршилтын улмаас сайн, муу аль алиныг нь мэдэж, сонголт хийх явдал юм. Энэ ялгааг ойлгож, зөв бурууг ялгахын тулд Аллах Эзэн маань

42 Ахмет Саим Килавуз, “Жин”, ДИА, 8-р боть, 9-р хуу.

43 Саба, 34/14.

оршихуйнуудыг бие биеэсээ ялгаатай байдлаар бидэнд танилцуулсан юм. Энэ чиглэлд шэйтан сайн, үнэн, гоо үзэсгэлэнг илүүд үздэг, зөвлөдөг сахиусан тэнгэрүүдийн эсрэг, өөр хувилбар болгон бүтээгдсэн.

Куран сударт дүрсэлсэн, дурдагдсан шэйтан ба хүний хоорондын харилцаа үргэлж тэмцлийн хэлбэрээр байдаг. Шэйтан хүнийг хууран мэхэлж, төөрүүлж, Аллах Эзнээсээ холдуулахыг оролддог байна.⁴⁴ Нөгөөтээгүүр, Аллах Эзэн болон Гэгээн Элч маань бидэнд шэйтаны заль мэх, урхинаас болгоомжилж, санаа бодлыг нь үл хүндэтгэж, түүний бузар муугаас Аллаhad хоргодохыг бидэнд зөвлөдөг.⁴⁵ Энэ тэмцэл нь бидний дэлхий дээрх диваажингийн төлөө сорилтод орох зайлшгүй шаардлага гэж үзэх ёстой.

Аллах Эзэн хүн төрөлхтний төлөө сайн мууг бүтээж, сайн сайхныг тайлбарласан элчнүүд, ном судруудыг илгээж, муу зүйл ямар байдаг, түүнээс хамгаалах арга замыг зааж өгдөг. Ийм байдлаар тодорхойлсон журмыг шалгалт өгч буй оюутны нөхцөл байдалтай харьцуулж болно. Багшаараа хичээл заалгаж, шаардлагатай материалаар хангагдсан оюутан шалгалтын хуудсан дээр тааралдсан асуултуудаас нэг зөв сонголтоос гадна нэгээс олон буруу сонголтуудыг олж харна. Энэ тохиолдолд багш нь сурагчаа алдаа гаргахыг хүсэж байгаа байдлаар үнэлэх боломжгүй юм. Харин ч багш асуух асуултын талаар шаардлагатай мэдээллийг өгч, эх сурвалжийг

44 Ниса, 4/60; Аграф, 7/16-17-18; Анфал, 8/48; Намил, 27/24 мөн бусад.

45 Аграф, 7/200-201; Мүминун, 23/97-98; Фуссилат, 41/36.

үзүүлж, алдаа гаргах боломжтой нөхцөл байдлын талаар дурдсан юм. Гэхдээ шалгалтын хуудсанд буруу сонголт оруулах нь шалгалтын журмын нэг шаардлага юм.

Оршихуйн төрөл болох шэйтэн гэж юу вэ? Жин эсвэл сахиусан тэнгэр үү?

Бүтээгдсэн оршихуйнуудыг мөн чанараар нь *нягтаршсан* ба *нарийн* биетүүд гэсэн хоёр үндсэн гарчиг дор авч үзэж болно. Амьгүй амьтад, ургамал, амьтан, хүмүүс нь нягтаршсан биетүүд юм. Жин, чөтгөр, сахиусан тэнгэрүүд бол нарийн биетүүд юм.

Жин бол мэдрэхүйгээр хүлээн зөвшөөрөгдөхгүй, хүн шиг ухамсартай (юмс үзэгдлийг танин мэдэж тэдгээрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэлт хийх ухамсартай), хүсэл эрмэлзэлтэй, тэнгэрийн зарлигийг дагах үүрэгтэй, итгэгч, үл итгэгчдийн бүлгүүдээс бүрддэг биетүүд юм.⁴⁶ Жин гэдэг бол утаагүй,⁴⁷ цэвэр галаар⁴⁸ бүтээгдсэн, хүн шиг идэж ууж, гэр бүл болж үрждэг, эр эм хүйсийн ялгаатай бөгөөд тэдэнд гэгээн элчнүүд илгээгдсэн оршихуйнууд юм.⁴⁹

Тэнгэрийн элч нар нур буюу гэрэл, цацрагаас бүтээгдсэн бөгөөд тэд үргэлж бидний Аллах Эзэнд дуулгавартай байдаг тул жин болон шэйтануудаас ялгаатай. Тэнгэрийн элч нар өөрийн гэсэн онцлог,

46 М. Сүрэяа Шахин, “Жин”, ДИА, 8-р боть, 5-р хуу.

47 Рахман, 55/15.

48 Хижр, 15/27.

49 А. Саим Килавуз, “Жин”, ДИА, 8-р боть, 8-р хуу.

үүрэг хариуцлагатай байдаг. Гэхдээ тэдгээрийг ямар ч буруу, муу, алдаа гэх мэт сөрөг нөхцөл байдалтай холбож болохгүй.

Галаас бүтээгдсэн⁵⁰ шэйтаныг Куран сударт наян найман удаа (арван найман удаа олон тоогоор) (иблис гэж арван нэгэн удаа) дурдсан байдаг. Хз. Адамыг бүтээсний дараа тэнгэрийн элч нараас мэхийн ёслохыг гуйсан тухай есөн айлдварт "иблис" гэдэг үг, дайсагнаж янз бүрийн арга заль, урхи ашиглан хүмүүсийг хууран мэхэлсэн тухай ишлэлд "шэйтан" гэдэг үгийг ашигласан байдаг.⁵¹ Иблис бол жиннүүдийн нэг гэдгийг Аллах Эзэн маань ийнхүү илэрхийлсэн: *"Бид мелекүүдэд (тэнгэрийн элч нарт) хандан: "Адамд сөгдөн мөргөгтүн" гэж хэлэв. Иблис бусад нь бүгдээрээ мөргөцгөөсөн. Иблис жин буюу буг чөтгөрүүдийн нэгэн учраас Эзэнтнийхээ зарлигийг биелүүлээгүй билээ. Аяа, хүмүүс минь ээ! Ийм атал та нар Надаас урваж, түүнийг болон үр удмыг нь анд найзаа болгоцгоох юм гэж үү? Үнэндээ тэд та нарын илэрхий дайсан шүү дээ. Харгис зальхайчуудын хувьд ийнхүү хийсэн солио нь юутай муухай юм гээч!"*⁵² Бидний Аллах Эзэн, тэнгэрийн элч нар Хз. Адамд мөргөхийг тушаасан үед Иблис сахиусан тэнгэрүүдийн дунд байсан нь түүнийг сахиусан тэнгэр байсан гэдгийг батлахгүй. Яагаад гэвэл тэнгэрийн элч нар бол Аллахын зарлигийг биелүүлэхийн тулд бүтээгдсэн учраас тэд Аллахын эсрэг тэрсэлддэггүй. Харин Иблис Аллахын эсрэг

50 Аграф, 7/12; Хижр, 15/27; Мүснэд, VI, 152, 168; Мүслим, Зүхд, 60.

51 Иляас Чэлэби, "Шэйтан", ДИА, 39-р боть, 99-р хуу.

52 Кахф, 18/50.

дуулгаваргүй бөгөөд энэ дуулгаваргүй байдалдаа тууштай байсан юм.

Куран сударт шэйтан бол харгис хэрцгий, зальтай, төөрөгдүүлэгч, өдөөн хатгагч бөгөөд түүний заль мэхэнд нь анхаарал хандуулсан бөгөөд⁵³, түүнээс хол байхыг захиж, түүний бузар муугаас Аллахаас аврал эрэлхийлэх шаардлагатай⁵⁴ гэж заасан байдаг. Гэгээн Элч маань ч өөрийн хадиснуудад хүмүүсийн хийх бүх төрлийн муу зан үйлд чөтгөрийн нөлөөг онцлон тэмдэглэж, түүний урам зориг, хууран мэхлэгч тоглоомд анхаарлаа хандуулсан байдаг.⁵⁵ Энэ бүх шинж чанараараа шэйтан нэг талаас хүмүүсийг хорон муу, буруу, нүгэл үйлдэхэд уриалж, нөгөө талаас хүмүүсийг Аллах Эзэндээ мөргөхөөс сэргийлж, Түүнээс холдуулахыг хүсдэг.

Үр дүнд авч үзэхэд чөтгөр оршихуйн хувьд сахиусан тэнгэр, жиннүүдтэй нэг ангилалд багтдаг. Бүтээлийн нэг болох (гал) жиннүүдтэй адил юм. Гэхдээ дээр дурдсанчлан өөрийн шинж чанар, хүнтэй харилцах харилцааны хувьд тэрээр сахиусан тэнгэр болон жин биш өөр нэгэн биет юм.

Шэйтан ба жиннүүд хүмүүст ? хор хөнөөл учруулж чадах уу

Жин нь мэдрэхүйн эрхтнүүдээр мэдрэгддэггүй, янз бүрийн хэлбэрт хувирч чаддаг, галаас бүтээгдсэн сүнслэг, нууцлаг биетүүд юм. Үл үзэгдэгч, муу

53 Ниса, 4/60; Аграф, 7/16-17-18; Анфал, 8/48; Намл, 27/24 гэх мэт.

54 Аграф, 7/200-201; Мүминун, 23/97-98; Фуссилат, 41/36.

55 Иляас Чэлэби, “Шэйтан”, ДИА, 39-р боть, 100-р хуу.

зүйлд хэт хол явдаг, ихэмсэг, тэрслүү, хүмүүсийг төөрөгдүүлэхийг оролддог жиннүүдийг шэйтэн гэдэг.

Жин ба шэйтануудын талаарх бидний мэдлэг нь Куран судар, хадист суурилдаг. Жиннүүдийг бүтээх шалтгаан нь хүн төрөлхтнийг бүтээх шалтгаантай адил юм: Аллахад мөргөл залбирал үйлдэх.⁵⁶ Итгэн үнэмшиж, буян үйлддэг жиннүүд байдгийн адил хүмүүсийг сайн, зөв үйл үйлдэхэд нь саад болох гэсэн үл итгэгчид/чөтгөрүүд бас байдаг.

Аллахад хорогдсон хүнд юу ч хор хөнөөл учруулж чадахгүй. Учир нь мүмин хүн (итгэгч хүн) Аллахын зөвшөөрөлгүйгээр өөрт нь ямар ч ашиг тус, хор хөнөөл учруулахгүй гэдэгт чин сэтгэлээсээ итгэдэг.⁵⁷ Жиннүүдэд хоргодож, тэдэнтэй харилцах гэж оролддог, тэднээс тусламж хүссэн хүмүүс буруу зан үйлийнхээ улмаас бодит байдал болон сэтгэл санааны хохирол амсах магадлалтай.

Мүмин хүн өөрт тохиолдох аливаа муу муухайгаас Аллахад аврал эрэлхийлдэг шигээ жин болон чөтгөрүүдийн бузар муугаас ч бас Аллахад аврал эрэлхийлдэг бөгөөд тэднээс айдаггүй. Жиннүүдийн хор хөнөөлөөс хамгаалахын тулд Аятүл-курси, Фэлак, Нас зэрэг хамгаалалтын шинж чанартай⁵⁸ сүрэнүүдийг уншихыг зөвлөж байна.⁵⁹

56 Зариат, 51/56.

57 Юнус, 10/107.

58 Ибн Ханбэл, IV, 144, 146; Бухари, Вэкалэт, 10

59 Ахмет Саим Килавуз, “Жин”, ДИА, 8-р боть, 8-10-р хуу

Шэйтаны найзууд гэж хэн бэ ?

Аллах Эзэн Куран сударт Шэйтаны өөрийн гэсэн дагалдагчид,⁶⁰ арми⁶¹, найз нөхөдтэй⁶² гэдгийг илчилсэн байдаг. Үүний дагуу, итгэн биширдэггүй,⁶³ удирдан чиглүүлэхээс төөрөгдлийг илүүд үздэг,⁶⁴ Аллахыг санан дурсдаггүй,⁶⁵ сэтгэлээ хорон санаа, хорио цээрээс холдуулдаггүй,⁶⁶ төөрөгдөл ба төөрөгдлийн замыг илүүд үздэг,⁶⁷ Аллахын тухай мэдлэггүй атал маргалддаг,⁶⁸ чөтгөрийн урилгыг дагадаг,⁶⁹ бусдад харуулахын тулд баялгаа үрэн таран хийж, зарцуулдаг⁷⁰ хүмүүс шэйтаны найзууд юм.

Ерөнхийдөө Аллахад итгэдэггүй эсвэл Аллахын зарлигийг дагаж мөрддөггүй, тэдний эсрэг тэрсэлдэг хүмүүс Аллахын дайсан, улмаар чөтгөрийн (шэйтаны) найзууд болдог.

.....
60 Мүжадала, 58/19.

61 Шугара, 26/95.

62 Ниса, 4/76; Ангам, 6/121; Хаж, 22/4.

63 Аграф, 7/27-30.

64 Аграф, 7/27-30.

65 Зухруф, 43/36.

66 Нур, 24/21.

67 Ниса, 4/120.

68 Хаж, 22/3.


69 Ибрахим, 14/22.

70 Исра, 17/27.

Тэнгэрлэг судруудад

ИТГЭХ

ИТГЭЛ



Тэнгэрлэг судруудад ? ИТГЭХ ИТГЭЛ ГЭЖ ЮУ ВЭ

Тэнгэрлэг судруудад итгэх гэдэг нь Аллах өөрийн зарим бошиглогчдод товчлол буюу хэдхэн хуудас тэмдэглэл бүхий айлдвар болон ном хэлбэрээр илчилсэн тэнгэрлэг зарлиг, хориглолтуудыг илгээсэн ба эдгээр бүх илчлэгдсэн Түүний үгс бөгөөд тэдгээрийн агуулга нь бүрэн үнэн бөгөөд бодитой гэдэгт туйлын итгэлтэй байхыг хэлнэ.

Тэнгэрлэг судрууд эзлэхүүн, агуулгын хувьд “хуудас/сухуф” болон “ном” гэж хоёр хуваагддаг. Аллах Эзнээс жижиг бүлгүүдэд илгээсэн тэдний хэрэгцээг хангахуйц хэлбэрээр илгээсэн товхимол, туужийг "хуудас/сухуф" гэдэг бөгөөд; Сухуфаас илүү их хэмжээний, бүх төрлийн мэдээллийг агуулсан бичвэрүүдийг "ном буюу судар" гэж нэрлэдэг.¹

Куран сударт Хз. Ибрахим ба Хз. Мусад сухуф өгсөн гэж мэдээлсэн.² Хадисуудад, Хз. Шийт 50, Хз. Идрис 30, Хз. Ибрахимд 10 ба Хз. Мусад Тауратаас өмнө 10 хуудас илгээгдсэн гэж мэдээлсэн билээ.³ Гэвч эдгээр хуудасны аль нь ч өнөөг хүртэл хадгалагдаагүй байна.

- 1 Илиас Үзүм, “Китап”, ДИА, 26-р боть, 121-р хуу; Өмэр Думлу, “Сухуф”, ДИА, 37-р боть, 477-р хуу.
- 2 Нажим 53/36-37; Агла, 87/14-19.
- 3 Ибн Хиббан, *Сахих*, 2, 276.

Ариун судрууд нь дөрөв байдаг бөгөөд эдгээр нь Хз. Мусад өгсөн Таурат,⁴ Хз. Давутаг Забур,⁵ Хз. Исад Инжил,⁶ бидний Элч Гэгээн Мухаммедэд Куран судар⁷ тус тус илгээгдсэн юм.

Гэгээн Элч нарт номууд ямар арга замаар ирсэн бэ ?

Аллах Эзэн Гэгээн Элч нарт ариун судруудыг вахигаар дамжуулан илгээсэн юм. Толь бичигт "ямарваа нэгэн юмыг нууцлаг байдлаар түргэн хугацаанд айлдах, нууцаар хэлэх, зааж өгөх, онгод оруулах" гэсэн утгатай вахи гэдэг үг нь шашны хэллэгийн үүднээс үзвэл: "Аллах Эзний зарлиг, мэдээллийг Гэгээн Элч нартаа нууцаар мэдэгдэх" гэсэн утгатай юм.⁸

Куран сударт Аллахын зарлигуудыг хүмүүст хүргэх арга зам нь мэдээлэл өгөх, хөшигний цаанаас үг хэлэх, элч илгээх, түүний үгийг тайлагнах хэлбэрээр байдаг гэж заасан байдаг. *"Аллах хүмүүстэй зөвхөн айлдвараар дамжуулан, эсвэл хөшигний цаанаас (үл үзэгдэх байдлаар) үгүй бол гэгээн элч илгээж, өөрийн зөвшөөрснөөр түүнд хүссэнээ амлалт айлдвар болгох замаар ярилцдаг."*⁹ Эхний арга нь вахи ба сургаалаар дамжуулан Гэгээн Элч нарын зүрх сэтгэлд нууц тэмдэг бүхий бурханлаг үгийг элчгүйгээр үлдээж заах замаар хэрэгждэг юм. Энэ төрлийн вахид

4 Маидэ, 5/44.

5 Ниса, 4/163; Исра, 17/55.

6 Маидэ, 5/110; Хадид, 57/27.

7 Ал-и Имран, 3/3; Ниса, 4/47 мөн бусад.

8 Юсуф Шэвки Явуз, "Вахи", ДИА, 42-р боть, 440-р хуу.

9 Шура, 42/51.

Гэгээн Элч нар сэрүүн байдаг. Вахи нь хөндлөнгийн туслалцаагүйгээр Гэгээн Элч нарын зүрх сэтгэлд шууд хоногшуулан үлддэг. Хоёр дахь вахигийн төрөл бол хөшигний цаанаас ярих, жишээ нь Аллах Тур ууланд Элч Мусатай ярьж байсан явдал юм.¹⁰ Энэ төрлийн вахигаар Гэгээн Элч Аллах Эзнийхээ мэдээллийг хүлээн авдаг. Аллах Эзэнтэйгээ ярьдаг. Гэхдээ тэр үүнийг харж чадахгүй. Гурав дахь зам бол Тэнгэрийн Элчээр дамжуулах айлдвар. Аллах айлдвар дамжуулагч Жабрейл нэртэй тэнгэрийн элчээр дамжуулан Өөрийн Гэгээн Элч нартаа таалсан бүхнээ мэдэгддэг.¹¹

Аллах яагаад нэгээс олон ном илгээсэн бэ ?

Аллах бүх нийгэмд өөр өөрсдийнхөө дундаас Гэгээн Элч нарыг илгээж, тэдний амьдарч буй эрин үеийн хэрэгцээ, түвшний дагуу шүүлтүүдийг илчилсэн. Куран сударт өгүүлснээр, Хз. Адамаас ирсэн сүүлчийн Гэгээн Элч, Хз. Мухаммедын үе хүртэл олон Гэгээн Элч нар номлох үүргээ биелүүлж, хүмүүсийг "Аллахаас өөр шүтээн байхгүй" гэдэгт итгэхийг уриалсан юм.

Илгээсэн ариун судар бүр итгэл үнэмшлийн цэгт өмнөх илчлэлтүүдийг баталгаажуулж,¹² шашны өөрчлөгдөөгүй итгэл үнэмшлийн хэмжүүрийг эхний номоос сүүлчийн ном хүртэл бүх хүн төрөлхтөнд тодорхой дурдсан бөгөөд хүн төрөлхтний хөгжил

10 Касас, 28/30.

11 Юсуф Шэвки Явуз, "Вахи", ДИА, 42-р боть, 440-р хуу.

12 Ал-и Имран, 3/3-4.

дэвшилттэй зэрэгцэн орших мэдлэг, шүтлэг, ёс суртахууны тухай заалтууд цаг хугацаа, хэрэгцээ, нөхцөл байдалд тохируулан Аллахын хүслээр Куран судрыг буулгах хүртэл үргэлжилсэн юм.

Бүх нийгэм дэх хүмүүсийн сэтгэл зүй, нийгэм, бие махбодын хэрэгцээ, ойлголтын түвшин, соёл иргэншил өөр өөр байдаг. Гэвч бүх цаг үед хүмүүст шашин хэрэгтэй байсан бөгөөд анхны хүнээс өнөөг хүртэл энэ хэрэгцээг хангах эрэл хайгуул үргэлжилсээр ирсэн. Аллах Куран судраас өмнө илгээсэн ариун бичвэрүүдэд Аллах итгэгчдийн ойлголтын түвшин, чадвар, нийгэм, соёлын онцлогт тохируулан шүтлэг, үүрэг хариуцлага, үүргийг өгсөн юм. Хз. Адам болон түүний амьдарч байсан нийгэмд илчлэгдсэн анхны Гэгээн Элч нарт 10 хуудас бүхий сухуф бичвэр илгээгдэж байх хооронд Хз. Давуд, Хз. Муса ба Хз. Исад сухуф бичвэр биш судрууд илгээсэн билээ.

Хүн төрөлхтний сүүлчийн Гэгээн Элч Хз. Мухаммедын сүүлчийн ном бол Куран судар юм.¹³ Куран судар бол Шүүлтийн өдөр хүртэл бүх нийгмийн асуулт, хэрэгцээнд хариулах ариун ном бөгөөд өөрчлөх, өөрчлөгдөх боломжгүй юм. Куран судрыг хадгалах нь бусад тэнгэрлэг судруудыг хадгалахтай адил биш юм. Аллах Эзэн Куран судрын хамгаалалтыг авсан юм.¹⁴ Бидний Гэгээн Элч Мухаммед бол зөвхөн нийгмийн төдийгүй дэлхийн төгсгөл, сүүлчийн өдөр хүртэл амьдрах бүх хүмүүсийн Гэгээн Элч юм. Куран судартай хамт Тэнгэрлэг судруудын сүүлчийн холбоос

13 Ахзаб, 33/40.

14 Хижр, 15/9.

дууссан юм. Энэ байдлын талаар Гэгээн Элч “Би (ганц тоосго нь будсан төгс барилгын дутууг гүйцээж буй) тоосго шиг бүх Гэгээн Элч нарын сүүлчийнх нь юм”¹⁵ гэх өгүүлбэрээр илэрхийлсэн билээ. Хүн төрөлхтний түүхийн эхэн үеэс баригдсан энэхүү төгс барилгад сүүлчийн ном болох Куран судар болон сүүлчийн Гэгээн Элч Хз. Мухаммедтэй хамт дуусгасан юм.

Куран судар яагаад сүүлчийн ном бэ ?

Куран судар бол бүх хүн төрөлхтөнд илгээгдсэн ном юм. Түүний мэдээллүүд нь бүх нийтийг хамарсан юм. Бүх цаг үеийн хэрэгцээг хангахуйц үнэн ба ухаанаар дүүрэн байдаг. Энэ нь Алладын хамгаалалтад байдаг тул Түүний тогтоолууд шүүлтийн өдөр хүртэл үргэлжилнэ.¹⁶ Куран сударт Аллах Эзэн, тэрээр Хз. Мухаммед бол Гэгээн Элч нарын сүүлчийнх байсан¹⁷ бөгөөд түүнтэй хамт шашин төгс болсон¹⁸ гэж мэдэгджээ. Шашин төгсөнө гэдэг нь үүнээс хойш шинэ шашин ирэхээ больж, сүүлчийн илгээсэн номын заалтууд эцэс хүртэл хүчинтэй байх тул Куран судар нь сүүлчийн ном болно гэсэн үг юм.

.....
15 Мүслим, Фэзаил, 22.

16 Хижр, 15/9.

17 Ахзаб, 33/40.

18 Маида, 5/3.

Хэрэв Куран судар нь илгээгдсэн сүүлчийн ном юм бол бид яагаад Таурат ба Инжилд ч гэсэн итгэх ёстой вэ ?

Хүн төрөлхтөнд илгээгдсэн сүүлчийн тэнгэрлэг ном бол Куран судар юм. Хз. Адамаас Хз. Мухаммед хүртэл ирсэн бүх Гэгээн Элч нарт итгэдэг шигээ эдгээр Элч нарт илчлэгдсэн номуудад итгэх нь бидний итгэл бишрэлийн зайлшгүй шаардлага юм.¹⁹ Түүгээр ч барахгүй энэ итгэл бишрэл нь Таурат болон Инжилээр хязгаарлагдахгүй юм. Энэ нь Гэгээн Элч нарт илгээгдсэн бүх хуудас болон ариун бичвэрүүдийг хамардаг. Учир нь эдгээр судрууд нь Куран судартай адил Жабрайлаар дамжуулан тухайн үед амьдарч байсан хүмүүст илгээгдсэн илчлэлдүүт юм. Эдгээрийг бид тэнгэрлэг судар гэж үздэг ч өнөөг хүртэл эх хувь нь хадгалагдаагүй, мөн тэдгээрт мухар сүсэг, сүсэг бишрэл ихтэй мэдээлэл нэмэгдсээр байгааг мэдэж байгаа тул тэдний эсрэг илүү болгоомжтой ханддаг. Энэ бол Гэгээн Элчийн бидэнд өгсөн зөвлөгөө юм: “Еврей эсвэл Христийн шашинтны үгийг бүү батал мөн бүү үгүйсгэ. Гэхдээ: “Бид Аллахад, бидэнд илгээгдсэн (Куранд), мөн Ибрахим, Исмайл, Исхак, Якуб болон тэдний ач зээ нарт илгээгдсэн сударт, Муса болон Исад илгээгдсэн сударт, мөн бүх гэгээн элч нарт, Эзэнтний зүгээс илгээгдсэн судар номуудад итгэцгээнэ. Бид тэднийг хооронд нь ялгадаггүй, алаг үзэхгүй. Бид гагцхүү Түүнийг дагагч Мусульманчууд.” хэмээн хэлцгээ.²⁰

19 Бакара, 2/285; Ал-и Имран, 3/84.

20 Бакара, 2/136; Бухари, Тафсир, (Бакара) 11.

Куран судрыг ариун ном гэдгийг яаж ойлгох вэ ?

Куран судар бол ариун ном гэдэгт итгэх нь бидний итгэл бишрэлийн зайлшгүй шаардлага юм. Үүнтэй хамт түүний оршин тогтнол, ариун байдлыг түүхэн туршлага, оновчтой нотлох баримтаар нотолж болно.

Сударт чин сэтгэлээсээ итгэдэг хүн Куран судар нь Аллагаас илгээгдсэн бөгөөд агуулга нь бүрэн үнэн/үнэн гэдгийг хүлээн зөвшөөрч, эсрэгээр нь боддоггүй юм.

Түүхэн туршлага нь хүн төрөлхтний түүхийн эхэн үеэс Аллах Өөрийн зарлиг, цээрлэлийг хүмүүст хуудас буюу сахифэ, ном хэлбэрээр илчилдэг. Куран судар нь эдгээр Тэнгэрлэг судруудын сүүлчийнх нь болох нь түүхэн туршлагаар нотлогдсон юм.

Аллах Эзэн үл итгэгчдээс Куран судартай адил, түүний цөөн хэдэн бүлэг эсвэл эшлэлийг авчрахыг хүсдэг. Гэвч арван дөрвөн зууны турш ямар ч хүн, бүлэглэл бидний Рабб Эзний энэхүү хүсэлтийг агуулга, хэв маягийн хувьд биелүүлж чадаагүй, цаашид ч биелүүлж чадахгүй билээ.

Нөгөөтээгүүр Куран судар нь бусад номтой харьцуулахад хэв маяг, агуулгын хувьд төгс, цогц тууштай ном учраас хүний үг болон хөндлөнгийн оролцоо байхгүй болно. Энэ нь түүний ариун байдлын илэрхийлэл юм.

Эдгээр шинж чанаруудыг Куран судрын олон эшлэлд дурдсан байдаг. Юуны өмнө Куран судар нь хүний

үг ба зохиомол биш гэдгийг Аллах Эзэн үл итгэгчдэд хандаж дараах хэллэгийг эсэргүүцэн ашигласан:

*(Аяа, Мухаммед!) : “Хэрэв, та нар үнэн үг хэлэгсэд бол Аллахын зүгээс энэ хоёроос ч (надад болон Мусад илгээгдсэн) илүү нэгэн судрыг олоод ирэгтүн, тэгвээс би түүнийг дагамуй” хэмээн хэлэгтүн.*²¹

*"Ийнхүү хэлэгтүн (Аяа, Мухаммед!) тангараглаж байна Хэрэв хүмүүн болоод буг чөтгөрүүд энэхүү Курантай адил судар зохиох гэж цуглаад, бие биедээ дэмжлэг үзүүлсэн ч зохиож эс чадмуй."*²²

*"Хэрэв тэдний хэлсэн нь үнэн юм бол (зохицол, уран сайхан, өгүүлэмж нь) Курантай адил ганц өгүүлэмж зохиож үзэг л дээ."*²³

*Тэд: “Кураныг Мухаммед өөрөө зохиосон” гэж байна уу? Тэдэнд: “Хэрэв та нарын зөв бол Аллахаас бусад туслуулахаар чадах бүхнээ дуудагтун. Үүнтэй адил арван бүлэг айлдвар зохиож үзэгтүн” хэмээн хэл!”*²⁴

Куран судар илгээгдэж, Мусульман болсон тэр үед амьдарч байсан олон яруу найрагчид, Куран судар дахь уран зохиолын шинж чанарууд нь хүний үг байх боломжгүй гэж үзэж түүнчлэн тэд Куран судар бол бурханлаг бичвэр гэж мэдэгджээ. Тухайн үеийн алдартай, чадварлаг яруу найрагчдын нэг болох Лэбид б. Рабиа эшлэлүүдийн өмнө өөрийн хүч чадалгүй байдлаа "Төгс Хүчит Аллах надад Бакара

.....
21 Касас, 28/49.

22 Ибра, 17/88.

23 Тур, 52/34.

24 Худ, 11/13.

болон Али Имраныг заасны дараа тэрээр би шүлэг уншиж чадахгүй." ²⁵ гэж мэдэгджээ.

Куран судар бусад ариун номуудаас юугаараа ялгаатай вэ ?

Куран судрыг бусад ариун номоос ялгаж буй шинж чанаруудыг дараах байдлаар дүгнэж болно.

- 1- Бусад Тэнгэрлэг судрууд нэг дор бүхэлд нь илгээгдсэн юм. Харин Куран судар нь Гэгээн Элч хорин гурван жилийн гэгээн Элчийн амьдралын туршид эшлэл эшлэлээр эсвэл бүлэг бүлгээр илгээгдсэн юм.
- 2- Куран судар нь сүүлчийн бурханлаг ном учраас өмнөх номуудыг баталж, гүйцээж өгдөг. Учир нь тэдгээр судар номууд бидэнд эх хэлбэрээр нь ирж чадаагүй юм. Тиймээс тэдгээрт юу ч гуйвуулсан байна Куран судар бидэнд үнэнийг хэлдэг.
- 3- Куран судар бол сүүлчийн тэнгэрлэг судар юм. Түүнээс өөр шинэ судар илгээгдэхгүй билээ. Ийм учраас түүний заалтууд дэлхийн төгсгөлийн эцэс хүртэл хүчинтэй байна. Бусад тэнгэрлэг судруудын заалтууд хүчингүй болсон юм.
- 4- Куран судар ямар ч эвдрэлгүй, өөрчлөгдөөгүй өнөөг хүртэл хадгалагдан ирсэн.

.....
²⁵ Мехмет Ёлжу, “Лабид б. Реба ба Таухидэд дуудсан шүлэг”,
Хикмет Юрду, 2008, боть: 1, тоо: 2, 125-р хуу.

- 5- Гэгээн Элч бүр Гэгээн Элч гэдгийг батлах зарим гайхамшгуудыг өгсөн байдаг. Ариун Куран судар бол Мухаммед (с. а. у.)-д өгсөн хамгийн том гайхамшиг бөгөөд түүний Гэгээн Элч болохыг нотолсон явдал юм.
- 6- Куран сударт бусад сударт байдаггүй хялбар цээжлэх онцлогийг өгсөн билээ.
- 7- Бусад ариун судрууд нь тухайн үеийн гэгээн элчнүүдийн үед бичигдээгүй байдаг. Куран судар нь бидний Гэгээн Элчийн үед бичигдсэн билээ.²⁶

Куран судар хадгалагдан өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй? ирснийг би яаж мэдэх вэ

Куран судар бол Аллах Эзнээс шүүлтийн өдөр хүртэл бүх хүмүүст илгээсэн сүүлчийн судар юм. Бидний Гэгээн Элч айлдварууд хэсэгчлэн ирэх бүрт бичээчдээ дуудан бичүүлдэг байсан бөгөөд Түүний үнэнч анд нар (сахаби) эдгээр айлдваруудыг цээжилж, намаз мөргөл үйлдэхдээ үргэлж уншдаг байв. Түүнээс гадна буусан Куран судрын айлдваруудыг, Гэгээн элчийн удирдлага дор хэрэгжүүлсэн, Муслимчүүдийн итгэл ба мөргөл залбирлын амьдралын зүг чигийг тодорхойлсон.

Бидний Гэгээн Элч амьд байхад илчлэлт үргэлжилсэн тул Куран судрыг ном болгох боломжгүй байв. Гэвч Гэгээн Элчийг нас барсны дараа анхны халиф Хз. Абу Бакирын үед тархай бутархай бичвэр айлдваруудыг нэр дор цуглуулж,

.....
²⁶ Өмөр Фарук Харман, “Куран”, ДИА, 26-р боть, 412-414-р хуу.

ном хэлбэрээр бэлтгэсэн. Хоёр дахь халиф Хз. Омарын үед Исламын газарзүй өргөжиж эхэлснээр Куран судрын илүү олон хуулбар шаардлагатай болсон. Гурав дахь халиф Хз. Османы үед Мусхаф хэмээх анхны хуулбарыг Ариун Куран судар бичих замаар хуулбарласан билээ. Куран судрын хуулбарыг Мекка, Куфа, Басра, Дамаск, Бахрейн, Йемен рүү илгээв. Мусульманчууд эдгээр хуулбарууд дээр үндэслэн Куран судрыг олон хувь бичиж, үе бүрт Куран судар цээжлэх хафизуудыг бэлтгэж байсан тул бидний тэнгэрлэг судар өнөөг хүртэл ямар ч өөрчлөлтгүйгээр хадгалагдан үлджээ. Өнөөдөр дэлхийн хаана ч явсан Куран судрыг уншсан, цээжилсэн, хэвлэсэн бүх хувь нь адилхан байгаа нь харагддаг.

Энэ бүхний хажуугаар Аллах Эзэн маань Кураны хамгаалагч нь өөрөө болохыг дараах байдлаар тунхагласан байдаг: *"Кураныг эргэлзээгүй бид илгээсэн бөгөөд түүнийг бид л хамгаалмуй."*²⁷ Төгс Хүчит Аллахын энэхүү айлдвар нь Мусульманчуудын хувьд Куран судар өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй хэвээр байгаагийн хамгийн том баталгаа юм.²⁸

Куран судар дахь зарим айлдваруудыг хүлээн авахаас татгалзах нь бидний итгэлд хор хөнөөл учруулах уу ?

Итгэл бишрэлийн нэг үндэс бол тэнгэрлэг судруудад итгэх явдал юм. Үүний дагуу, Мусульман хүн Аллахын Гэгээн Элч нарт илгээсэн бүх номд, Түүний илгээгдсэн хэлбэрээр нь итгэх ёстой. Куран судар бол

27 Хижр, 15/9.

28 Абдулхамит Биришик, "Куран", ДИА, 26-р боть, 383-388-р хуу.

Аллахын зөв замыг зааж өгөхийн тулд бидний Гэгээн Элч нараар дамжуулан хүн төрөлхтөнд илгээсэн захиас юм. Аллах, *"Та нар номынхоо зарим хэсэгт нь итгэж, зарим хэсгийг нь үгүйсгэж байна уу?"*²⁹ хэмээн айлдваруудын хооронд ямар ч ялгаа гаргахгүй байхыг хүссэн билээ. Куран судрыг өөрөө илгээж, хамгаалдаг Төгс Хүчит Аллах худал хэлэх нь санаанд багтамгүй тул Куран судар дээрх бүх эшлэлүүд нь Түүний үг бөгөөд одоо ч Түүний хамгаалалтад байдаг. Ийм учраас сүсэгтэн хүн Аллахаас илгээсэн эшлэлүүдийн заримыг хүлээн авч, заримыг нь хүлээн зөвшөөрөхгүй байх нь санаанд багтамгүй зүйл юм. Куран судар бол Аллахын үг гэдгийг эхнээс нь дуустал хүлээн зөвшөөрч, итгэх нь бидний итгэл бишрэлийн зарчим юм.

Куран судар яагаад нэг дор биш хэсэг хэсгээр илгээгдсэн бэ ?

Куран судар нь нэг дор илгээгдээгүй, харин Гэгээн Элчийн хорин гурван жилийн турш заримдаа бүлэг бүлгээр, зарим үед хэсэг хэсгээр илгээгдсээр байв. Аллах Эзэн, Куран судар яагаад нэг дор буулгагдаагүйн шалтгааныг дараах байдлаар тайлбарлав: *"Үл итгэгчид: "Куран түүнд яагаад бөөндөө, нэг удаад буулгагдаагүй юм бэ?" хэмээн асууна. Бид Кураныг чиний зүрх сэтгэлд хоногшуулахын тулд ийнхүү нэг нэгээр нь, тус тусдаа айлдсан болой."*³⁰

Куран судар илгээгдэх тэр үед шинээр Мусульман болсон хүмүүсийн зүрх сэтгэлд Ислам шашнаас

29 Бакара, 2/85.

30 Фуркан, 25/32.

авчирсан итгэл үнэмшил, үнэлэмж үндэс суурьшиж, хүчирхэгжихэд тодорхой хугацаа шаардлагатай байв. Тэнгэрлэг зарлигууд нь шинээр Мусульман болсон хүмүүсийн оюун ухаан, зүрх сэтгэлд аажмаар суурьшихын хэрээр тэдний хөгжил, эдгээр зарлигт дасах нь илүү хялбар болж, тэдний илгээгдсэн айлдваруудыг амьдралдаа хэрэгжүүлэх нь хөнгөвчлөгдөж, илчлэлийг сонирхох сонирхол нь үргэлж амилахуйц байсан.

Бидний Гэгээн Элч болон Куран сударт дайсагналцаж буй хүмүүст цаг хугацаа өгөх, тэдний зүрх сэтгэлийг байлдан дагуулж, шаардлагатай үед тэдний асуултад хариулах зэрэг шалтгаануудыг авч үзвэл Куран судрыг хэсэг хэсгээр нь илгээх нь ямар чухал болохыг ойлгоход хялбар юм.³¹

Куран судар яагаад илгээгдэн ирсэн дарааллаар бичигдээгүй вэ ?

Аллахаас илгээгдсэн тэнгэрлэг судруудын сүүлчийнх болох Куран судар нь Гэгээн Элчид хорин гурван жилийн хугацаанд илгээгдэн ирсэн. Куран сударт 114 суре, зургаан мянга гаруй эшлэл байдаг. Айлдваруудын сүре буюу бүлэг дэх дарааллыг Гэгээн Элч өөрөө Жабрейлийн зааж өгсний дагуу гүйцэтгэсэн. Өөрөөр хэлбэл, илгээгдэн ирсэн айлдвар аль бүлэгт орох эсвэл тухайн бүлэг аль бүлгээс өмнө эсвэл дараа бичигдэх нь тэр үед тодорхойлогдсон билээ.

31 Абдулхамит Биришик, “Куран” , ДИА, 26-р боть, 383-388-р хуу.

Жабрейл ба Гэгээн Элчийн хооронд жил бүр Куран судар уншдаг/ харилцан уншдаг гэдгийг бид мэднэ. Хэрэв тэр үеэс айлдваруудын дараалал тодорхойгүй байсан бол Кураныг уншсан ч сонсогч түүнийг дагах боломжгүй байсан. Куран судар ном хэлбэрээр бичигдсэн байхад Гэгээн Элчийн нас барахаас өмнө тогтоосон дарааллыг үндэс болгон авсан бөгөөд тухайн үед энэ талаар санал зөрөлдөөн байгаагүй юм.³²

Куран судар яагаад араб хэлээр илгээгдэв ?

Бүх Гэгээн Элч нар өөрсдийн илгээгдсэн тухайн ард түмний хэлээр ярьдаг байсан бөгөөд энэ нь тэдний хүлээн авагчдад тэнгэрлэг захиасыг ойлгуулахын тулд юм. Энэ асуудлын талаар Аллах Эзэн Куран сударт: *"Аллахын зарлигийг сайтар тайлбарлаж өг гээд Бид гэгээн элч бүрийг зөвхөн өөрсдийнх нь ардад өөрсдийн хэлээр илгээсэн юм. Аллах хүссэн хэн нэгнийг төөрөгдүүлж, хүссэн хүнээ зөв зам руу хөтөлдөг. Аллах машид хүчирхэг бөгөөд мэргэн ухааны эзэн."*³³ Хз. Мухаммед (с.а.у.)-ын анхны ярилцагчид буюу хүлээн авагчид нь арабчууд байсан тул Куран судрыг араб хэлээр буулгасан юм. Хэрэв Хз. Мухаммед (с.а.у.) өөр үндэстний хүн байсан бол Куран судар өөр хэлээр илгээгдэх боломжтой байсан. Энд анхаарах ёстой чухал зүйл бол тэнгэрлэг захиас нь ямар ч хэлээр илгээгдсэн бүх нийтийн мэдээллийг агуулдаг байх явдал юм.

32 Абдүлхамит Биришик, "Куран" , ДИА, 26-р боть, 383-388-р хуу.

33 Ибрахим, 14/4.

Бидний Аллах Эзэн Куран судрыг бүх хүн төрөлхтөнд чиглүүлэгч болгон илгээсэн гэж мэдэгдсэн билээ.³⁴ Куран судрыг араб хэлээр буулгасан нь түүний бүх нийтийн шинж чанарт саад болохгүйтэй адил араб биш хүмүүст ч ойлгоход бэрхшээлтэй бус юм. Аллах Эзэн Куран сударт ийнхүү өгүүлжээ: *"Ухаарах хүмүүсийн хувьд айлдварууд яруу тод өгүүлэгдсэн. Энэ судар Араб хэл дээрх Куран мөн."*³⁵ Хүн төрөлхтөнд чиглүүлэгч болохын тулд илгээсэн сүүлчийн ном судраа Аллах Эзэн араб хэлээр илгээж, хэрэв тэд хүсвэл (хүмүүс) бүх хүмүүст ойлгомжтой байдлаар буулгахыг хүссэн юм.

Товчхондоо, Гэгээн Мухаммед (с.а.у) болон түүний анхны ярилцагчид Арабчууд байсан тул Куран судар нь араб хэлээр илгээгдсэн бөгөөд бүх хүн төрөлхтөнд зориулсан бүх нийтийн мэдээллийг агуулсан гарын авлага юм.

Аллах яагаад Куран сударт өөрийгөө заримдаа "би" заримдаа "бид" гэж дурддаг вэ ?

Куран сударт Аллах заримдаа *би*, заримдаа *бид* гэсэн үгийг ашиглан өөрийнхөө талаар дурддаг. Жишээлбэл, тэрээр дараах эшлэлд Би төлөөний үгийг ашигласан: *"Боолууд минь та нараас Миний тухай асуувал: Би тэдэнд ойрхон байна. Бас надад наманчлан залбирах аваас түүний залбирлыг хүлээн авч соёрхоно. Тэд зөв замаар явна гэвэл Миний урилгыг*

.....
34 Бакара, 2/185.

35 Фуссилат, 41/3. Куран судрын араб хэлээр илгээгдсэний талаар мөн үзнэ үү. Юсуф, 12/2; Рагьд, 13/37; Таха, 20/113; Зүмер, 39/28; Шура, 42/7; Зухруф, 43/3; Ахкаф, 46/12.

хүлээж авагтун, надад итгэцгээгтүн.”³⁶ Өөр нэг эшлэлд: “Бид үнэндээ Кураныг Кадир шөнө буулгасан юм.”³⁷ хэмээн, бид төлөөний үгийг ашигласан. Жишээнүүдийг илүү ихэсгэж болно.

Куран судар дахь бид төлөөний үгийн энэ хэрэглээ нь олон тооны утга агуулаагүй юм. Энэ нөхцөл байдал нь зөвхөн Куран судрын хэв маяг үг хэллэгтэй холбоотой юм. Энэхүү илэрхийлэл нь Алладын алдар суу, сүр жавхланг илэрхийлдэг. Турк хэл дээр нэг хүнд хандахдаа “чи”-ий гээ хэлэхийн оронд “та” гэсэн төлөөний үгийг хэрэглэж буйтай ижил. Бүх зүйлийг бүтээгч Төгс Хүчит Алладын тухай хүндэтгэлтэйгээр дурдах нь хэнээс ч илүү зохистой. Куран судар дахь бид төлөөний үгээр дурдсан олон тоо нь Алладын сүр жавхлан, өргөмжлөлийг илэрхийлдэг байна.³⁸

Куран судар бол гайхамшиг ? энэ нь юу гэсэн үг вэ

Куран судар бол гайхамшиг гэдэг нь үүнтэй адил зүйлийг бүтээх боломжгүй гэсэн үг юм. Куран судар нь үг хэллэг (үг, өгүүлбэр) болон утгын хувьд ч гайхамшиг юм. Хэл ярианы хувьд гайхамшиг гэдэг нь хүмүүс Түүнтэй ижил төстэй үг гаргаж ирж чадахгүй гэсэн үг. Аллах Эзэн энэ талаар: “Эсвэл тэд: ‘Кураныг санаанаасаа зохиосон’ гэнэ үү? Үгүй дээ, тэд өөрсдөө Куранд итгэхийг хүсэхгүй байгаа хүмүүс. Хэрэв тэдний хэлсэн нь үнэн юм бол (зохицол, уран

36 Бакара, 2/186.

37 Кадр, 97/1.

38 Ахмед Даадат, *Гайхамшигийн гайхамшиг Куран*, орчуулга. Юсуф Балжи, Инкилаб хэвлэлүүд, Истанбул, 1992, 74-р хуу.

сайхан, өгүүлэмж нь) Курантай адил ганц өгүүлэмж зохиож үзэг л дээ.”³⁹

“Эсвэл Тэд: “Кураныг өөрөө зохиосон” гэж байна уу? Тэдэнд ийнхүү хэл: ‘Хэрэв та нарын зөв бол Аллахаас өөр тусалж чадах бүхнээ дуудагтун. Үүнтэй адил арван бүлэг айлдвар зохиож үзэгтүн!’ Мөн: “Та нарын дуудсан юмнууд чинь хариу хэлж эс чадах аваас энэхүү Куран Аллахын эрдэм мэдлэгээр илгээгдсэн болохыг мэдтүгэй. Аллахаас өөр ямар ч бурхан үгүй. Та нар одоо хэр нь итгэн сүсэглэхгүй гэж үү?” хэмээн асуугтун!”⁴⁰

“Энэхүү Куран Аллахаас өөр хэн нэгнийх хэмээн гүтгэж болохгүй. Куран бол түүнээс өмнө илгээгдсэн судруудыг бататган Аллахын айлдваруудыг ил тод тайлбарлана. Тэр бүхий л ертөнцийн Эзэнтний зүгээс илгээгдсэн нь ямар ч эргэлзээгүй билээ. Үгүй бол тэд “Кураныг Мухаммед өөрөө санаанаас зохиосон” гэгцгээж байна уу? Аяа, Мухаммед! Тэдэнд: “Хэрэв үнэнч юм бол, Аллахаас өөр дуудаж чадах хүнээ дуудаж, Куран судрын бүлэгтэй адил бүлгийг дуудан зохиогоод аль?!” хэмээн хэлэгтүн.”⁴¹

Дээрх эшлэлүүдэд Аллах Эзэн маань Куран судрыг Гэгээн Мухаммед үүнийг өөрийн санаанаас зохиосон гэж үзсэн хүмүүсийг тэрээр ил тод эсэргүүцсэн билээ. Хамгийн чадварлаг яруу найрагчид хүртэл уран зохиолын чадвараа ашиглаж чадаагүй атал Хз. Мухаммед Куран судрыг зохиосон байх боломжтой юу? Түүнчлэн хүмүүсийн оюун ухаан, сэтгэл хөдлөлийг шингээсэн, бүх түвшний хүмүүст

39 Тур, 52/33-34.

40 Худ, 11/13-14.

41 Юнус, 10/37-38. Мөн үзнэ үү. Бакара, 2/23-24.

ойлгомжтой хэв маягтай, уншлагын өвөрмөц авианы зохицол нь Куран судар бол Аллахын үг гэдгийг тод харуулж байна.

Куран судар нь утга ба агуулгын хувьд гайхамшиг гэдэг нь түүнд агуулагдах мэдээллийг хүмүүс гаргаж ирэх боломжгүй гэдгийг ойлгуулж байгаа юм. Өнгөрсөн үеийн нийгэм, ертөнцийн бүтээн байгуулалт, дэг журам, хүн төрөлхтний бүтэц эсвэл диваажин там, сахиусан тэнгэр гэх мэт мэдрэхүйн эрхтнүүд ба оюун ухаанд үл ойлгогдох сэдвүүдийн талаарх мэдээлэл нь хүмүүсийн өөрсдийн мэдээллийн эх сурвалжаар илчилж болох мэдээлэл биш юм. Нэмж дурдахад, доторх мэдээлэл нь хоорондоо зөрчилддөггүй; хүн төрөлхтөн Шүүлтийн өдөр хүртэл үнэн зөв мэдлэг, зарчимч амьдрах, амьдралын утга учиртай байх хэрэгцээг хангаж байгаа нь Куран судар бол тэнгэрлэг гарал үүслийн гайхамшигт хөтөч болохыг харуулж байна.

Куран сударт ямар сэдвүүд байдаг вэ ?

Куран сударт бид энэ хорвоо болон хойд ертөнцөд аз жаргалтай байхын тулд бидэнд хэрэгтэй зүйлсийн талаар айлдварууд бий. Эдгээр айлдварууд нь дараах сэдвүүдийг голчлон хамардаг:

- 1- Итгэл: Куран сударт итгэл үнэмшилтэй холбоотой янз бүрийн асуудал, ялангуяа Аллахад итгэх итгэл, Гэгээн Элч нар, сахиусан тэнгэрүүд, тэнгэрлэг судруудад итгэх итгэл, хойд ертөнцтэй холбоотой чухал асуудлууд байдаг.

- 2- Мөргөл: Мусульманчуудын хийх ёстой залбирал, мацаг барилт, намаз мөргөл, зекат гэх мэт мөргөл залбирлын тухай айлдварууд бий.
- 3- Ажил хэрэг ёс журам: Худалдан авалт, гэрээслэл, өв залгамжлал, гэрлэлт, гэр бүл салалт зэрэг хувь хүн болон нийгэмд хамаатай хүмүүсийн хоорондын харилцааг зохицуулдаг айлдварууд байдаг. Эдгээр сэдвүүдийн заримыг нарийвчлан авч тайлбарладаг.
- 4- Укубат: Нийгмийн дэг журмыг зөрчиж, Аллахын хорио цээрийг зөрчигчдөд ямар шийтгэл оногдуулах тухай айлдварууд.
- 5- Ёс суртахуун: Эцэг эхээ хүндлэх, хүнтэй эелдгээр харьцах, сайныг захиж, мууг цээрлэх, даруу байх зэрэг ёс суртахууны эрхэм чанаруудыг Аллах Эзэн судартаа онцлон тэмдэглэсэн байдаг.
- 6- Зөвлөгөө: Хүмүүс Аллахын зарлиг, хорио цээрийн талаар мэдээлэлтэй байж, өөрсдийн эго сэтгэлдээ автахгүй байхыг зөвлөдөг. Бидний агуу ном болох Куран сударт, хүмүүсийн энэ ертөнцөд сорилтод байгаа гэдгээ ухамсарлан амьдрахыг зөвлөдөг байна.
- 7- Амлалт: Аллахын зарлигийг дагагчид диваажингаар шагнагдах бөгөөд түүний хориглосон зүйлийг үйлдсэн хүмүүс тамын шийтгэл хүлээх болно гэсэн эшлэлүүд багтдаг байна.

- 8- Шинжлэх ухааны баримтууд: Куран сударт хүн төрөлхтөнд шаардлагатай шинжлэх ухааны баримт, байгалийн хуулиудын нөлөө бүхий эшлэлүүд байдаг. Гэсэн хэдий ч Куран судар нь шинжлэх ухааны ном шиг шинжлэх ухааны баримтуудын талаар ярьдаггүй. Харин орчлон ертөнцийг хараад түүнийг бүтээгчийн хүч чадал, агуу байдлын талаар эргэцүүлэн бодож, Түүнийг адислахыг дурсан Аллаһыг алдаршуулахыг хүмүүст уриалдаг байна.
- 9- Өгүүлэмж: Куран сударт өмнөх Гэгээн Элч нарын амьдрал, тэдний тэмцлийн талаар хүмүүст сургамж авч болохуйц байдлаар өгүүлдэг.
- 10-Залбирал: Хүмүүс хийж буй зүйлдээ үргэлж Аллаһын тусламж хэрэгтэй байдаг тул Куран сударт янз бүрийн залбирал, өмнөх Гэгээн Элч нарын залбирлаас жишээнүүд байдаг. Эдгээр залбирлаар Аллаһ Эзэн маань албатууддаа хэрхэн залбирахыг зааж өгдөг.⁴²

Куран судар дахь сэдэв бүрийг шинжлэх ухааны онол нотлох шаардлагатай юу? Шинжлэх ухаан хөгжихийн хэрээр нотлох баримт нэмэгдэх болов уу?

Куран судар дахь сэдэв бүрийг шинжлэх ухааны онол нотлох боломжгүй юм. Учир нь Куран сударт дурдсан сэдэв бүр шинжлэх ухааны хүрээнд байдаггүй. Жишээлбэл, сахиусан тэнгэр, жиннүүд,

.....
42 Мустафа Чагрижи, “Куран”, ДИА, 26-р боть, 390-393-р хуу.

диваажин, там гэх мэт асуудал нь нотлох шинжлэх ухааны хүрээнээс гадуур байдаг. Үүнтэй зэрэгцэн Аллах Куран сударт тэнгэр ба газрыг бүтээх, тэнгэрээс ус дуслах, хүн төрөлхтнийг бүтээх, ураг эхийн хэвлийд ямар үе шат дамждаг зэрэг шинжлэх ухааны салбарт хамаарах сэдвүүдийг дурдсан байдаг. Тухайн айлдваруудыг ойлгоход олж авсан шинжлэх ухааны мэдээлэл нь тус хүргэх боломжтой, мөн тус хүргэж байгаа.

Куран судар бол Аллахын үг гэдгийг үнэмшүүлэх үүрэг гүйцэтгэх үүднээс шинжлэх ухааны сэдвүүд өөрсдийн сонирхлын хүрээнд хамаарах үйл явдлын талаар ярих нь чухал юм. Гэсэн хэдий ч Куран судар нь шинжлэх ухааны ном биш, харин хүмүүст чиглүүлэх эх сурвалж гэдгийг мартаж болохгүй. Хорвоо ертөнц рүү илгээгдэхийн зорилгыг сануулж, энэ зорилгод нийцсэн амьдралаар амьдрахыг чиглүүлэхийн тулд Куран судар илгээгдсэн юм. Энэ айлдваруудын зорилго нь Аллахын алдар суу, Түүний хүнд өгсөн адисал, үхлийн дараах амьдрал гэх мэтийг хүмүүст итгэл үнэмшлийн бодит байдлын талаар эргэцүүлэн бодох, ухамсрыг дээшлүүлэх явдал юм.

Шинжлэх ухааны мэдлэг нь тасралтгүй өөрчлөлт, хөгжилд нээлттэй байдаг бол Куран судар нь вахи дээр суурилдаг бөгөөд өөрчлөгдөхөд нээлттэй байдаггүй. Ийм учраас Куран судрын айлдварыг шинжлэх ухааны онолоор ойлгохыг оролдоход зарим хүндрэл бэрхшээл гардаг. Ер нь тодорхой хугацаанд хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны онолоор тайлбарласан айлдварыг нөгөө онол нь

өөрөөр нотлогдсон байхад яаж тайлбарлах вэ? Мэдээжийн хэрэг, шинжлэх ухаан бидэнд Куран судрыг ойлгоход тусалж чадах боломжтой, гэхдээ шинжлэх ухааны хөгжил бүрийг Куран судрын холбогдох эшлэлүүдтэй уялдуулахыг хичээх нь -шинжлэх ухааны мэдлэг байнга хөгжиж, өөрчлөгддөг учраас- зөв арга биш юм. Гэсэн хэдий ч шинжлэх ухааны мэдлэгийн сэдэв байж болох асуудлыг хөндсөн Куран судар нь хүмүүст сэтгэн бодох, судлах, сургамж авахад маш чухал хөшүүрэг болдог. Аллах Эзэн маань Али Имран 190-191-р айлдваруудад ийнхүү дурдсан байдаг: *"Тэнгэр, газар бүтэхэд, өдөр шөнө ээлжлэн солигдоход оюун ухааны эздийн хувьд илэрхий нотолгоо бий. Тэд суусан ч, боссон ч, хажуулдан хэвтсэн ч (үргэлж) Аллахыг эргэн бодно. Тэнгэр, газар бүтсэний тухай эргэцүүлэн бодохдоо: "Аяа, эзэнтэн минь ээ! Чи тэднийг дэмий нэг бүтээсэнгүй. Чамайг бүхнээс ариун, үнэн хэмээн үздэг. Биднийг тамын галаас сэргийлэгтүн!"* Куран сударт хүмүүсийг бодох, судлахад түлхэц өгөх олон эшлэл байдаг. Куран судрын агуулгыг шинжлэх ухааны мэдлэгтэй уялдуулах гэж оролдохын оронд Аллах бидний анхаарлыг татсан зүйлийг судалж, сэтгэж, сургамж авах нь эрдэмтдийн цар хүрээг нээж, илүү дэвшилтэт судалгаа хийх боломжийг олгоно.

Куран судрыг ойлгохгүйгээр уншихад хангалттай юу? Куран судрыг турк орчуулгаас унших нь үүнийг ойлгоход хангалттай юу?

Бидний Аллах Эзэн Түүнд хэрхэн мөргөл залбирал хийх талаар суралцахын тулд бидэнд Куран

судар илгээсэн. Куран судар нь бүх хүмүүс түүнд хандаж, шүүлтийн өдөр хүртэл үүнийг ойлгоход зориулагдсан; Энэ нь тэднийг үнэнч, шүтэн бишрэх, ёс суртахуунтай хувь хүн байхад чиглүүлдэг. Бүх хүмүүсийг өөр өөр хэл, үндэстэнд бүтээсэн Аллах Куран судрыг бүтээгч учраас түүнийг араб хэлээр илгээхдээ араб бус үндэстнүүд үүнийг шууд ойлгохгүй, зөвхөн орчуулгаар болон тайлбаруудаар л ойлгох болно гэдгийг мэддэг билээ.

Куран судар бол Гэгээн Элчийн хамгийн чухал гайхамшиг юм. Тиймээс бидний сэтгэлийн эдгэрэлт, зүрх сэтгэлийн тэжээл⁴³ болсон Куран судар унших нь өөрөө шүтлэгийн нэг хэлбэр бөгөөд орчуулга ба тафсирыг (тайлбарын) хамт ашигласнаар түүний утга учрыг ухамсарлаж, түүний айлдварын дагуу амьдралаа чиглүүлэхийг хичээж байгаа нь Аллахын, өөрөөр хэлбэл Исламд зохистой Мусульман хүн байх бидний хүчин чармайлтын зайлшгүй шаардлага юм. Учир нь Куран судрыг зөвхөн уншихын тулд бус, илүү ойлгож, амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд илгээсэн юм.

Куран судар дангаараа хангалтгүй гэж үү? Хадис хэрэгтэй юу ?

Ислам шашны хэллэгт Гэгээн Элчийн үг, үйлдэл, зан үйл, түүний хийхэд зөвшөөрсөн,

.....
43 “Аяа, хүмүүс ээ! Эзэнтний чинь ухуулга сургаал нь та нарын итгэл үнэмшлийн согогийг эдгээнэ. Үнэн сүсэглэгсэдийн хувьд зөв шулуун зам, хайр энэрэл (Куранаар дамжин) ирсэн амуй.” Юнус, 10/57.

баталсан зүйлсийг "хадис" гэж нэрлэдэг.⁴⁴ Аллах, Куран судрыг; асуудал тулгамдахад хүмүүсийг гэгээрүүлж, тэдний хооронд санал зөрчилдөөнтэй үед эвлэрүүлж, тэднийг удирдан чиглүүлдэг хайрт Гэгээн Элчид илгээсэн билээ. Дараа нь түүнээс хүмүүст илгээсэн захиасыг хүргэхийн тулд, өөрөөр хэлбэл түүнийг номлохыг хүссэн юм. Тиймээс Аллахын элч бол (Хз. Мухаммед) Куран судрыг бусдаас илүү сайн ойлгож, Аллахын айлдварт юу хэлж байгааг хамгийн сайн мэддэг хүн юм. Куран судар бол Аллахын үг гэдгийг Гэгээн Элч бидэнд мэдээлэх үед бид суралцдаг. Хэн нэгэн Гэгээн Элчийн үг, үйлдэл, зан авирыг үнэ цэнтэй, найдвартай биш гэж хэлэх нь Куран судар бол Аллахын үг гэсэн итгэл үнэмшилтэй зөрчилддөг.

Айлдваруудыг хүмүүст хүргэсний дараа Гэгээн Элч маань тэднийг үгээрээ тайлбарлаж, заримдаа үйл хөдлөлөөрөө тэдгээрийг хэрэгжүүлж харуулсан. Куран судар дахь зарим заалтыг ерөнхийд нь дурдсан бөгөөд нарийвчилсан тайлбарыг бидний Гэгээн Элчид үлдээсэн болно. Нэмж хэлэхэд бидний Гэгээн Элч зарим тушаалыг хэрхэн хэрэгжүүлэхийг зааж өгсөн. Жишээлбэл, Куран сударт намаз мөргөл үйлдэх нь Мусульманчуудын үүрэг боловч намазыг хэрхэн хийх, хэдэн ракат үйлдэх, намаз мөргөлийн цаг бусад нарийн зүйлсийг дурдаагүй байдаг. Үүний нэгэн адил Исламын шашинд тахил өргөх, мөргөл үйлдэх, зекат өглөг өгөх зэрэг чухал мөргөл үйлдэх нь зайлшгүй хийх ёстой үүрэг боловч үүнийг хэзээ, хэрхэн хийхийг Гэгээн Элчид үлдээсэн юм.

44 М. Яшар Кандэмир, "Хадис", ДИА, 15-р боть, 27-р хуу.

Мусульманчууд бид энэ бүхнийг Гэгээн Элчийнхээ хадисуудаар дамжуулан сурдаг.

Гэгээн Элч вахитэй зөрчилдсөн үг, үйлдэл ба хандлагаас хол байсан. Тэр Аллахын элч байсан тул түүний тайллыг бидний Аллах Эзэн хянадаг байв. Вахигийн явцад бидний Гэгээн Элчийн зарим үг, зан үйлийг Аллах илчлэлээр дамжуулан засаж залруулсан болохыг бид харж байна. Аллах Эзэн *"Тэр өөрийнхөө хүсэл зоргоороо ярихгүй. Түүний ярих зүйл нь өөрт нь яруу тод болсон айлдвар болой."*⁴⁵ хэмээн тэрээр Гэгээн Элч өөрийн хяналтан дор байсан гэдгийг маш тодорхой илэрхийлсэн.

Бидний Гэгээн Элчийн хадисуудыг маш нарийн тэмдэглэж, Куран судартай холилдохгүй байхыг анхаарч үзсэн. Гэгээн Элч маань энэ асуудлын талаар хамтрагчдадаа (асхаб) онцгойлон анхааруулж байсан нь маш тодорхой мэдэгддэг билээ. Нийгэмд худалч гэгддэг нэгнийг бүү хэл, бүр гартаа хоолтой юм шиг хуурч ан амьтдыг дуудаж байгаа хүмүүсийн, хадис хэмээн хэлсэн үгнүүдийг хүртэл хүлээж авдаггүй байсан.

Үүний үр дүнд хадисууд нь Куран судрын эшлэлүүдийг тайлбарлаж, бидний шашны амьдралд чиглүүлэгч хамгийн чухал эх сурвалж юм. Шашны тушаал, хоригийг ойлгож, биелүүлэхийн тулд бидэнд Гэгээн Элчийн удирдамж хэрэгтэй. Үгүй бол бид Аллахад мөргөл залбирал үйлдэхийн тулд Куран сударт илгээсэн залбирал, зарлигийг хэрхэн ойлгож, яаж хэрэгжүүлэхээ мэдэхгүй байх болно.

45 Нажим, 53/3-4.

Өнөөх хүртэл бидний Гэгээн Элчийн үгс бидэнд үнэн зөвөөр хүрээгүй байна гэж үздэг эсэргүүцэгчид Куран судрыг ойлгохын тулд бусад хүмүүсийн тайлбарыг дахин ашиглаж байна. Заримдаа Куран судрыг ойлгохын тулд хүмүүс бидний Гэгээн Элчийн хадисуудын оронд өөрсдийн ойлголтыг илүүд үздэг байна. Энэ нь янз бүрийн мөргөл, шашны тайлбарыг бий болгодог. Бусад тэнгэрлэг шашны доройтлын хамгийн чухал шалтгаан нь шашны зүтгэлтнүүд гэх хэсэг бүлэг хүмүүсийг Алладын үг хэмээн өөрсдийн үзэл бодлоороо удирдаж байсан явдал юм. Аллах Эзэн маань Ислам болон Куран судрыг Гэгээн Элчийн зан үйл, үгсээр дэмжиж, Куран судрын ойлголтыг түүний тайлбар, үйлдлээс бүх цаг үеийн туршид хамааралтай болгосон юм.⁴⁶

Ариун судар хүртэгсэд ? гэж юу гэсэн үг вэ

"Ариун судар хүртэгсэд" гэдэг нь Алладын Гэгээн Элч нарт илгээсэн судруудад итгэдэг хүмүүсийг нэрлэсэн нэр юм. Куран сударт "Эхли китап буюу Ариун судар хүртэгсэд" гэсэн нэр томъёог ерөнхийдөө еврейчүүд болон христийн шашинтнуудад ашигладаг.⁴⁷ Гэсэн хэдий ч энэ хэллэгийг бусад Элч нарт илчлэгдсэн судруудад итгэдэг хүмүүст ч мөн ашигласан.⁴⁸

Куран сударт зөвхөн еврейчүүд болон христийн шашинтнуудыг эхли китап гэж дурдсан байдаг нь энэ хоёр шашны зарим дутагдал, алдаанаас

46 Хадисын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү. М. Яшар Кандэмир, "Хадис", ДИА, 15-р боть, 27-64 р хуу.

47 Ниса, 4/153; Майда, 5/15, 19.

48 Ангам, 6/84-90.

гадна Аллах, Гэгээн Элч, хойд ертөнц, тэнгэрлэг судруудад итгэх итгэл багтсан өөрөөр хэлбэл тэдгээр нь тэнгэрлэг эх сурвалжид тулгуурласан бөгөөд тухайн үед Куран судрыг хүлээн авч байсан хүмүүс тухайн шашин шүтлэгийг мэддэг байсантай холбоотой юм.⁴⁹

"Ариун судар хүртэгсэд" гэсэн хэллэгийг дурдсан эшлэлд; тэдний дунд үл итгэгчид хийгээд⁵⁰ магтаал сайшаалтай хүмүүс байдаг бөгөөд⁵¹ эдгээр үл итгэгчид Алладын эшлэлийг үгүйсгэж,⁵² үнэнийг худал хуурмагтай андуурч,⁵³ итгэлийг үл тоомсорлож,⁵⁴ тэдэнд өгөгдсөн ариун номыг устгаж,⁵⁵ Гэгээн Элч нарыг нь хөнөөж,⁵⁶ Мусульманчуудыг итгэл бишрэлгүй болгохыг хүсэж,⁵⁷ Таурат болон Инжилийн заалтуудыг зохих ёсоор хэрэгжүүлдэггүй байна⁵⁸ гэж заасан байдаг. Куран судар Ариун судар хүртэгсдэд Аллахад мөргөн залбирч, Түүнтэй эн зэрэгцүүлэхгүй байхыг уриалж,⁵⁹ Мусульманчуудыг тэдэнтэй тэмцэхдээ итидал буюу дундын замыг баримтлахыг зөвлөдөг байна.⁶⁰

Куран сударт Мусульманчуудын Ариун судар хүртэгчидтэй харилцах харилцааны талаар нээлттэй бөгөөд тодорхой чиглэл өгсөн байдаг:

49 Рамзи Каяа, "Эхл-и Китап", ДИА, 10-р боть, 517-р хуу.

50 Али Имран, 3/75, 113-115, 119.

51 Бакара, 2/105; Байина, 98/1.

52 Али Имран, 3/70, 98, 112; Ниса, 4/155; Хашр, 59/2.

53 Али Имран, 3/71.

54 Али Имран, 3/75.

55 Али Имран, 3/78.

56 Али Имран, 3/112; Ниса, 4/155.

57 Бакара, 2/109; Али Имран, 3/69, 72, 99, 100.

58 Майда, 5/68.

59 Али Имран, 3/64.

60 Анкабут, 29/46.

"Та нарын дунд харгис зальхай этгээдээс бусад, судрын эзэдтэй хамгийн ёслол төгөлдөр (эрдэмлэг, соёлтой) мэтгэлцээн хийгтүн. Тэдэнд: "Бидэнд буулгагдсанд, та нарт ч буулгагдсанд сүсэглэн итгэцгээлээ. Бидний бурхан, та нарын ч бурхан нэг л шүү дээ. Бид Түүнд итгэн бишрэгчид мөн" хэмээн хэлэгтүн. ⁶¹Үүнээс гадна Ариун судар хүртэгсдийн эмэгтэйчүүдтэй гэрлэхийг мөн тэдний гаргасан малын махыг идэхийг зөвшөөрсөн байна.⁶²

Таурат ба Инжилд итгэдэггүй хүмүүсийн байдал ахирет ертөнцөд ямар байх вэ ?

Таурат (Тора), Инжил (Библи), Забур болон Куран судар нь Аллахаас илгээгдсэн судрууд юм. Илгээгдсэн Гэгээн Элч бүрийн нэгэн адил бүх судрууд өмнөх судруудыг баталгаажуулсан бөгөөд ингэснээр тэдгээр нь нэг бурханлаг эх сурвалжаас гаралтай болохыг илчилсэн. Тиймээс Куран сударт итгэх, түүнээс өмнөх судруудад итгэх хоёрын хооронд ялгаа байхгүй болно. Гэсэн хэдий ч Куранаас бусад судрыг хамгаалж чадаагүй байсан учраас тэдгээр нь цаг хугацааны явцад гажуудсан, өөрчлөгдсөн; Өнөөдрийг хүртэл зөвхөн Куран судар л өвлөгдөн үлджээ.

Бүх тэнгэрлэг судрууд үнэн зөв бөгөөд тэдгээр нь бүгд Куран сударт илчлэгдсэн Гэгээн Элч нараар дамжуулан хүмүүсийг чиглүүлэхээр илгээгдсэн гэдэгт итгэх нь мумин (итгэгч) байхын нэгэн

.....
⁶¹ Анкабут, 29/46.

⁶² Майда, 5/5.


шаардлага нь юм. Тиймээс Таурат болон Инжилийг илгээсэн гэдгийг үгүйсгэж байгаа хүн мүнчин байж чадахгүй, диваажинд ч орж чадахгүй билээ. Учир нь диваажин бол зөвхөн итгэгчдэд (мүнчинчүүдэд) зориулагдсан газар юм.



ГЭГЭЭН ЭЛЧ НАРТ

ИТГЭХ

ИТГЭЛ



Аллах яагаад Гэгээн Элч нарыг илгээсэн бэ ?

Гэгээн Элч нар болон тэдний хүн төрөлхтний түүхэн дэх байр суурийг авч үзэх замаар энэ асуултад хариулахыг оролдохдоо Аллах хоёр үндсэн шалтгаанаар Гэгээн Элч нарыг илгээсэн гэдгийг ойлгох болно. Эхний шалтгаан нь Аллахын ухамсар, оюун ухаантай болгон бүтээсэн хүн төрөлхтөн нь хариуцлагатай нэгэн оршихуй юм. Адамын үр удам, өөрөөр хэлбэл хүн төрөлхтөн бол хийсэн үйлдлийнхээ хариуцлагыг хүлээдэг юм. Хэний өмнө хариуцлага хүлээх вэ? Мэдээжийн хэрэг, өөрийг нь бүтээсэн Аллах Эзнийхээ өмнө болон бүх оршихуйнуудын өмнө хариуцлага хүлээнэ. Нэгэнт хариуцлага хүлээсэн болохоор хариуцлагаа ухамсарлах ёстой. Энэ бол Аллах, Гэгээн Элч нарыг илгээсэн шалтгаануудын нэг юм. Аллах хүн төрөлхтөнд амьдралд нь зөв замыг зааж, үүрэг хариуцлагыг нь сануулж, хожим нь асуугдах болно гэдгийг мэдээлэх Гэгээн Элч нарыг илгээсэн.

Хүн өөрийн оюун ухаан, мэдрэхүйгээр дамжуулан маш их мэдээлэлд хүрч чаддаг. Гэсэн хэдий ч хүний амьдрал маш богино байдаг. Оюун ухаан бас хязгаарлагдмал. Богино амьдрал, оюун санааны хязгаарлагдмал байдал нь хүн төрөлхтнийг өнгөрсөн ба ирээдүйгээ бүрэн ухаарах, амьдралыг төгс утгаар нь төлөвлөх боломжийг хаадаг. Харин

ёс суртахууны үндсэн зарчмуудыг баримталж, дагаж мөрдвөл нийгмийн амьдрал тогтож болно. Гэгээн Элч нарыг илгээх өөр нэг шалтгаан нь энэ ертөнцийн амьдралыг эрүүл аргаар босгож, үргэлжлүүлэхийн тулд хүмүүст хэрэгтэй үндсэн зарчмуудыг хүргэх, эдгээрийг бүх хүмүүс хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэхэд шаардлагатай эрч хүчийг Гэгээн Элч нар болон тэдний зааж сургадаг бурханлаг мэдлэгээр хүмүүст дамжуулах явдал юм. Гэгээн Элч нарын нийгэмд өгсөн хамгийн том бэлэг бол нийгмийн амьдралд ёс суртахууны зарчмуудыг суурьшуулах явдал байв.

Хүн төрөлхтөн нь Гэгээн Элч нараар дамжуулан оюун ухаанаараа олж авч чадахгүй мэдээлэлд хүрдэг. Аллахын шинж чанарууд, үхсэний дараа дахин амилах, хойд ертөнцийн амьдрал, тэнгэрийн элч нар, Аллахад хэрхэн мөргөж залбирах зэрэг нь оюун ухаанаар хүрч чадахгүй асуудал юм. Нэмж дурдахад, Гэгээн Элч нарын ачаар хүмүүс маш урт жилүүдэд хүрч чадах ёс суртахууны зарчмууд, нийгмийн амьдралыг хэрхэн бий болгох мөн үргэлжлүүлэх хэрэгтэй гэх мэдээлэлд хүрдэг байна. Эдгээр хоёр үндсэн шалтгааны улмаас Аллах Гэгээн Элч нарыг илгээсэн билээ.¹

Гэгээн Элч нарын үүрэг юу вэ ?

Гэгээн Элч бол Аллахын зарлиг, зөвлөгөөг нь хүлээн авагчдад хүргэхээр (хүмүүст) сонгогдсон элч юм.² Тодорхойлолтод ойлгомжтойгоор дурдсанчлан

-
- 1 Юсуф Шэвки Явуз, “Нүбүввэт”, ДИА, 33-р боть, 279-285-р хуу.
 - 2 Юсуф Шэвки Явуз, “Гэгээн Элч”, ДИА, 34-р боть, 257-р хуу.

Гэгээн Элч нарын үндсэн үүрэг бол бидний Аллах Эзний зарлигуудыг хүмүүст хүргэх явдал юм. Гэсэн хэдий ч, энэ дамжуулалт нь хоёр нөхцөл байдлыг авчирдаг. Үүний дагуу бид Гэгээн Элч нарын үүргийг "гурван т үсэг" -ээр нэгтгэн дүгнэж болно: "таблиг", "тэбийн", "тэмсил".

“Таблиг” гэдэг нь Аллахаас хүлээн авсан шашны зарчим номлолуудыг тэр чигээр нь ямар ч өөрчлөлтгүйгээр хүмүүст хүргэхийг хэлнэ. Дээр дурдсанчлан Гэгээн Элч нарыг сонгосон шалтгаан нь таблиг (мэдэгдэл) юм. Аллах эзэн Куран сударт Гэгээн Элч нартаа энэ үндсэн үүргээ дараах байдлаар илэрхийлсэн байдаг. *“Аяа, гэгээн элч минь ээ! Эзэнтнээс чамд илгээсэн бүхий л зааврыг тэдэнд дамжуул. Хэрэв, чи дамжуулахгүй юм бол гэгээн элчийн үүргийг эс гүйцэтгэсэн болно.”*³

"Тэбин" гэдэг нь хүмүүст хүргэх тэнгэрлэг зарлигуудыг шаардлагатай үед тайлбарлах явдал юм. Гэгээн Элч нарт ханддаг хүмүүсийн мэдлэг, ойлголтын түвшин өөр байсан тул олон сэдэв болон нарийн зүйлийг тайлбарлах шаардлагатай болсон. Чухамдаа энэ үүргийг Куран сударт дараах байдлаар дурдсан байдаг. *"Хүмүүнд илгээгдсэн хэм хэмжээнүүдийг (шариятын ёс суртахууныг) тодорхой тайлбарлаг гээд мөн тэднийг ухаарч ойлгог хэмээн Бид чамд энэхүү Кураныг буулгасан билээ."*⁴

“Тэмсил” нь тэнгэрлэг бүх зааврыг, зарлигийг бодитоор хэрэгжүүлж, хүмүүст үлгэр жишээ үзүүлэх явдал юм. Гэгээн Элч сахабанууддаа: *"Намаз мөргөл*

3 Майда, 5/67.

4 Нахыл, 16/44.

үйлдэхдээ надаас харсан шигээ үйлд", ⁵"Хаж мөргөлийн зарчмуудыг мөн адил надаас сурцгаа"⁶ хэмээн өөрөөс нь үлгэр дуурайлал авахыг хүссэн.

Хэрхэн Гэгээн Элч болох вэ? Хүн Гэгээн Элч байж чадах уу ?

Аллах Эзэн олон зууны турш Гэгээн Элч нарыг сонгож, илгээсэн. Гэгээн Элч болохыг хүсэх нь энэ сонголтод үр дүн авчирдаггүй юм. Дахин хэлэхэд, тухайн хүн баян, алдартай эсвэл албан тушаал хашиж байгаа нь түүнийг Гэгээн Элчээр сонгогдоно гэдгийг батлахгүй. Шаргуу хөдөлмөрлөж, шүтэн биширсэн ч Гэгээн Элч болох боломжгүй. Гэгээн Элч бол Аллахын бэлэг юм. Куран сударт, "Энэ нь Аллахын хайр энэрэл мөн. Түүнийг хүссэн хүндээ өгнө."⁷ хэмээн айлдсан байдаг. Аллах Эзэн, тэдний дундаас Гэгээн Элчийн үүрэг хариуцлагыг үүрч чадна гэдгийг мэддэг бөгөөд хүссэн хүнээ хүмүүсийн дундаас Гэгээн Элчээр сонгодог.⁸

Дэлхийн түүхэнд олон нөлөө бүхий хүмүүс байдаг, яагаад тэд Гэгээн Элч биш юм бэ ?

Бид дэлхийн түүхэнд нөлөө үзүүлсэн хүмүүсийг харахад тэдний маш чухал гэх хэсэг нь Гэгээн Элч нар байдаг. Өнгөрсөн зуунд өрнөдийн нэгэн судлаачийн бичсэн номд дэлхийн түүхэнд

5 Бухари, Эзан, 18.

6 Мүслим, Хаж, 310.

7 Жума, 62/4.

8 Юсуф Шэвки Явуз, "Гэгээн Элч", 34-р боть, 257-262-р хуу.

хамгийн нөлөө бүхий зуун хүний тухай бичсэн байдаг. Олон сая хүний хувь заяанд нөлөөлж, соёл иргэншлийн мандал, уналтад хүргэсэн, түүхийн замналыг чиглүүлсэн хүмүүсийн жагсаалтыг уг номын зохиогч нэмж оруулсан байна. Уг номд Хз. Иса ба Мусагийн тухай дурдсан зохиолч нь түүхэнд хамгийн их нөлөөлсөн хүмүүсийн дунд нэгдүгээрт, бидний Гэгээн Элч Мухаммед (с.а.у.) -г бичсэн байна.⁹

Дэлхийн түүхэн дэх чухал үйл явдлууд, ялангуяа соёл иргэншил үүсэж, дэлгэрсэн үйл явдлуудыг Гэгээн Элч нар удирдаж байсныг түүхийн чиглэлээр судалгаа хийж буй эрдэмтэд хүлээн зөвшөөрдөг.¹⁰ Хүн төрөлхтний хувьд оюун ухаан ямар чухал билээ хүн төрөлхтний түүхэнд ч гэсэн Гэгээн Элч нар төдий чинээ чухал гэсэн үг юм. Гэгээн Элч нар мөн иргэний зохион байгуулалтын арга барилыг олж, хэрэгжүүлэхэд хүн төрөлхтнийг анхдагч болгосон. Урлаг, техниктэй холбоотой бүх зүйлийн анхны мэдлэгийг Аллахын илгээсэн Гэгээн Элч нараар дамжуулан олж авсан. Гэгээн Элч нар мөн газар тариалан, худалдаа, анагаах ухаан, төмөр хайлуулах болон боловсруулах, хувцас оёх, дарвуулт завь зэрэг олон зүйлд хүмүүсийг удирдан чиглүүлсэн.¹¹ Аллахын элч Давудад төмрийг зөөлрүүлж, хайлсан зэсийг эх үүсвэрээс нь үер шиг асгаж,¹² хуяг дуулга урлахыг¹³ сургасан тухай Куран

9 Майкл Х. Харт, *Дэлхийн хамгийн нөлөө бүхий 100*, Ка Китап, 2016.

10 Юсуф Шэвки Явуз, “Нүбүввэт”, ДИА, 33-р боть, 282-283-р хуу.

11 Шарафаддин Гөлжүк, Исламын итгэл үнэмшил, *Есра хэвлэл*, Истанбул, 1994, 115-р хуу.

12 Саба, 34/10-12.

13 Анбия, 21/80.

сударт өгөгдсөн мэдээллийг авч үзвэл, энэ үеийг "төмрийн эрин" гэж нэрлэж байгааг бодоход Гэгээн Элч нар түүхийн тайзнаа үр дүнтэй дүрүүд байсан гэдгийг илүү сайн ойлгох болно.¹⁴

Бүх Гэгээн Элч нар хүмүүсийг ёс журамтай, зохистой амьдралаар амьдрахын тулд хүчин чармайлт гаргасан билээ. Тэд сайн сайхныг таниулж, тэдгээрийн арга замыг зааж, сайн сайхныг дэлхий дээр ноёрхохын төлөө хүчин чармайлт гаргасан. Үүний үр дүнд шударга ёс, эрх, хуулийг сахиулах, хүн хоорондын харилцаанд үнэнч шударга, итгэлцэл, хайр хүндэтгэл, сайн сайхныг дээдлэх, дарангуйлагч, дарангуйллын эсрэг байх зэрэг сайн сайхан чанаруудыг хүмүүст төлөвшүүлсэн. Үүний зэрэгцээ бузар мууг таниулж, муу муухайгаас хол байхыг зөвлөсөн Гэгээн Элч нар худал хуурмаг, шударга бус байдал, харгислал, хулгай, тохуурхах, бардам зан гэх мэт муу зүйлсийг хүмүүст өөрийн болгохоос сэргийлэхийн тулд тэмцэж байв. Гэгээн Элч нарын хүн төрөлхтөнд таниулж, хэрэгжүүлэхийг хичээсэн энэхүү мэдлэг нь хүн төрөлхтний түүхэнд ямар өндөр үнэ цэнтэй байсан нь тодорхой юм.¹⁵

Гэгээн Элч нараас бусад ? хүмүүст вахи ирж чадах уу ?

Гэгээн Элч нараас бусад хүмүүст вахи ирэх эсэхийг тайлбарлахын өмнө бид вахи гэдэг үгний шууд утга,

14 Юсуф Шэвки Явуз, "Нүбүввэт", ДИА, 33-р боть, 279-285-р хуу.

15 Бэкир Топалоглу, Юсуф Шэвки Явуз, Иляас Чэлэби, *Исламд итгэх итгэлийн зарчим*, 160-162-р хуу.

нэр томъёог тайлбарлахыг хүсэж байна. Толь бичигт Вахи гэдэг нь хэн нэгэнд зааж өгөх, илгээх, зүрх сэтгэлийг хөдөлгөх, хурдан бөгөөд нууцаар хэлэх¹⁶ гэсэн утгатай. Харин шашны хэллэгийн үүднээс үзвэл вахи нь Аллахын шууд эсвэл тэнгэрийн элчээр дамжуулан Гэгээн элч нарт илгээсэн онцгой нэгэн мэдээлэх хэлбэр юм. Энэ утгаараа вахи гэдэг нь Аллах Өөрийн сонгосон албат нарынхаа заримд хүргэхийг хүссэн захиасыг хүмүүст түгээмэл биш онцгой байдлаар дамжуулах явдал юм.

Куран сударт Аллахын тэнгэр,¹⁷ газар,¹⁸ зөгий,¹⁹ Хз. Мусагийн ээж,²⁰ Хз. Мариям,²¹ элч Исагийн удирдагч нар²² болон Гэгээн Элч нартаа илчилсэн гэж дурдсаныг бид харж байна. Гэсэн хэдий ч айлдваруудыг үзэхэд энэ үг нь зөвхөн "Гэгээн Элч нарын" тухайд Аллахын онцгой захиасыг хүмүүст мэдээлэх зорилготой байсан бол бусад эшлэлүүд нь зүрх сэтгэлд өгсөн нэгэн төрлийн эш үзүүлэлт эсвэл урам зоригийг илэрхийлдэг байна. Гэгээн Элч нараас бусад хүмүүсийн хүлээн авсан илчлэл нь тэдэнд Гэгээн Элч нарын үүрэг хариуцлага хүлээлгэдэггүй. Аллахын Гэгээн Элч нарт илгээсэн вахигийн онцлог нь Аллахын захиасыг бусад хүмүүст хүргэх зорилготой юм. Гэгээн Элч нарын

16 Юсуф Шэвки Явүз, "Вахи", ДИА, 42-р боть, 440-р хуу.

17 Фуссилат, 41/12.

18 Зилзал, 99/1-5.

19 Нахыл, 16/68.

20 Касас, 28/7; Таха, 20/38.

21 Мариям, 19/19, 24-26.

22 Майда, 5/111. Исламын эрдэмтэд, Аллах Элч Исагийн удирдагчдад вахи өгсөн гэдэг нь, Хз. Иса мэдээлэл өгсөн эсвэл Аллах тэдний зүрх сэтгэлд эш үзүүлэх замаар нөлөө болгосон гэдгийг харуулж байна.

Аллах болон хүмүүсийн хооронд Түүний захиасыг дамжуулдаг элчээр томилсон юм.

Аллахад итгэдэг хэр нь Гэгээн Элч нарыг хүлээн зөвшөөрдөггүй ? хүн шашнаас гарах уу

Аллах Эзэн мэргэн ухаан, нигүүлслийн үр дүнд Өөрийн албат нарт Гэгээн Элч нарыг илгээсэн юм. Аллахад итгэдэг хүн Аллах Эзэн нь Гэгээн Элч нар илгээсэн гэдэгт итгэдэг. Куран сударт, *"Гэгээн элч өөртөө Эзэнтнээс илгээсэн сударт итгэсэн. Сүсэгтнүүд ч итгэсэн. Тэд бүгд Аллахад, мэлэүүдэд, судар номуудад, гэгээн элчнүүдэд төгс итгэцгээсэн. Тэд: "Аллахын гэгээн элчнүүдийг алагчлан үзэхгүй. Бид Чиний сонордуулгыг сонслоо, зарлигийг чинь хүлээн зөвшөөрлөө. Аяа, Эзэнтэн минь! Бид чамаас өршөөл эрж байна, чам руу буцна" гэгцгээсэн.*²³ хэмээн Аллах бидэнд Гэгээн элч нарыг илгээж, хүмүүс тэдэнд итгэдгийг тайлбарласан байна.

Хүмүүст элчийн заавар зөвлөгөө хэрэгтэй байдаг. Хүний хүч чадлыг давж, дутуу үлдсэн асуудлуудын үед тусалж дэмжсэн, зам мөрийг нь гэрэлтүүлдэг Гэгээн Элч нар мөн. Хүн Аллахад хэрхэн залбиран мөргөх, хойд ертөнцтэй холбоотой нөхцөл байдал, сэтгэлгээ, ёс суртахууны хувьд хэрхэн дээшлэхийг Гэгээн Элч нарын сургаалаар мэддэг. Хэрэв Аллах Гэгээн Элч нарыг илгээгээгүй бол түүнд зөв, сайхан хоёрыг олж, ашиг тустай, хор хөнөөлийг ялгах нь түүнд амаргүй байх байсан. Учир нь хүмүүс сэтгэл хөдлөлийнхөө нөлөөнд автсан үедээ бодит үнэнийг

.....
²³ Бакара, 2/285.

ашиг тустай андуурч, зөв шийдвэр гаргаж чадахгүй байх магадлалтай.

Хүнд хариуцлага тооцож, хийсэн үйлдлийнхээ төлөө шагнуулж, шийтгэгдэхийн тулд түүнд мэдэгдэх ёстой. Ийнхүү тэрээр хожимдоо ч мэдэхгүй, Гэгээн Элч нар илгээгээгүй гэж Аллахын эсрэг шалтаг тоочиж чадахгүй. Аллах, *"Аллахын өмнө хүмүүст шалтаг болгохгүйн тулд Бид итгэн бишрэгсдэд гэгээн элч нарыг баяртай мэдээ дуулгагч болгон, эсэргүүцэгчдэд сэрэмжлүүлэгч болгон илгээлээ."*²⁴ хэмээн энэхүү байдлыг тайлбарлав. Гэгээн Элч нар өөрсдийн дагагсдадаа энэ дэлхий болон хойд ертөнцөд аз жаргалтай байхын тулд хэрэгтэй зарчмуудыг зааж өгсөн.

Мүмин буюу Итгэгч хүн бол Аллах, Гэгээн Элч нар болон түүний хэлсэн зүйлд итгэдэг хүн юм. Исламын шашны үндсэн зарчимд итгэдэггүй хүмүүс Элч Мухаммедийн Аллахаас авчирсан зарчмуудын нэг буюу хэд хэдэн эсвэл бүгдийг үгүйсгэдэг хүнийг кафир буюу үл итгэгч гэж нэрлэдэг. Шашны үндсэн зарчмуудын нэгийг юм уу бүгдийг нь үгүйсгэдэг, эсвэл дургүйцэж, зохисгүй гэж үздэг нь тухайн хүнийг үл итгэгч гэдгийг илтгэх хамгийн онцлог шинж юм. Куранд *"Аллах болоод гэгээн элчнүүдийг эсэргүүцэн, түүнийг бие биеэсээ холдуулах санаа өвөртлөгсөд, тэрчлэн гэгээн элчнүүдийн заримд нь итгэж нөгөөд нь үл итгэж, завсарын замаар оролдогсод бий. Тэд бол жинхэнэ буруу номтон мөн."*²⁵ хэмээн айлдсан байдаг.

24 Ниса, 4/165.

25 Ниса, 4/150-151.

Тиймээс Мүмин хүн Гэгээн Элчийн зааж сургасан зүйлд итгэдэг ба хүлээн зөвшөөрдөг. Кафир, үл итгэгч хүн бол бүхэлд нь эсвэл заримыг нь үгүйсгэдэг хүн юм. Итгэл үнэмшлийн зарчмуудын нэгийг ч үгүйсгэсэн хүнийг Мүмин гэж нэрлэх боломжгүй тул Аллахад итгэдэг ч Гэгээн Элч нарыг хүлээн зөвшөөрдөггүй хүн шашнаас гардаг байна.²⁶

Гэгээн Элч нарын заримд нь итгэж, заримд нь итгэхгүй байвал зүгээр үү? Гэгээн Элч нарыг ялгах нь зөв үү ?

Бүх Гэгээн Элч нарт итгэх нь итгэлийн нэг зарчим юм. Гэгээн Элч нарт итгэх итгэл; Энэ нь тэднийг Аллах илгээсэн бөгөөд тэдний авчирсан бүх мэдээлэл үнэн, зөв гэдэгт итгэхийг хэлнэ. Аллах Эзэн бүх Гэгээн Элч нарыг хооронд нь ялгахгүйгээр тэдэнд итгэхийг үүрэг болгосон билээ. Куранд, *“Тэгээн элч өөртөө Эзэнтнээс илгээсэн сударт итгэсэн. Сүсэгтнүүд ч итгэлээ. Тэд бүгд Аллахад, мэлэжүүдэд, судар номуудад, гэгээн элчүүдэд төгс итгэцгээсэн. Тэд: “Аллахын гэгээн элчнүүдийг алагчлан үзэхгүй. Бид Чиний сонордуулгыг сонслоо, зарлигийг чинь хүлээн зөвшөөрлөө. Аяа, Эзэнтэн минь! Бид чамаас өршөөл эрж байна, чам руу буцна” хэмээн айлдсан.* ²⁷ Ийм учраас зарим Гэгээн Элч нарт итгэж, заримд нь үл итгэх нь хүнийг шашингүй болгодог.²⁸

26 Мустафа Синаноглу, “Итгэл үнэмшил”, ДИА, 22-р боть, 212-214-р хуу.

27 Бакара, 2/285.

28 А. Намди Аксаки, *Ислам шашин*, 50-53-р хуу.

Гэгээн элч нарын хооронд давуу талаараа ялгаа бий юу ?

Гэгээн Элч нар бол Аллахаас авч хүмүүнд дамжуулах үүрэгтэйгээр илгээгдсэн нэр хүндтэй, дээд зэргийн онцгой хүмүүс юм. Тэд бүгд Гэгээн элчийн нөхцөлийг авч явах тал дээр нийтлэг шинж чанартай байдаг. Гэсэн хэдий ч Аллахаас тэдэнд олгосон тэнгэрлэг ивээл, боломжууд, тэдний зан чанар, тэсвэр тэвчээр, тэмцлийн арга барил нь өөр өөр байдаг. Энэ шалтгааны улмаас тэдгээрийн хооронд зэрэглэлийн хувьд ялгаатай байдаг. Энэ асуудлыг Куран сударт дурдсан бөгөөд Гэгээн Элч нар өөр хоорондоо ялгаатай давуу талтай байсан гэж тайлбарласан байдаг.²⁹ Нэмж дурдахад, Аллах зарим Гэгээн Элч нарын сорилтууд хүнд, тэмцэл нь хэцүү байдаг учир тэсвэр тэвчээртэй, зовлон зүдүүрийг тэсвэрлэдэг гэх утгаар “улу'л азм” гэж нэрлэсэн юм.³⁰

Гэгээн Элч нарын энэхүү давуу тал нь тэд шинэ бурханлаг ном авчирсан эсэх, эсвэл өөр өөр мэдлэг, оюун санааны түвшинтэй эсэх зэрэг нөхцөл байдалтай холбоотой юм. Гэгээн Элч байх, нийтлэг шинж чанартай байх тал дээр харин ялгаагүй юм. Бид Мусульманчуудын хувьд бидний үүрэг бол тэд бүгдээрээ Аллахын элч нар гэдэгт итгэх бөгөөд Гэгээн Элч нарыг ялгаварлан гадуурхахгүй байх явдал юм.³¹

29 Бакара, 2/253.

30 Ахкаф, 46/35.

31 Бакара, 2/136.

Гэгээн Элч нар өөрсдийн нийгэм рүү илгээгдсэн үү эсвэл бүх хүн төрөлхтөнд илгээгдсэн үү ?

Дэлхийн өнцөг бүрт өөр өөр хэлээр ярьдаг нийгэмд өөрсдийнхөө дундаас Гэгээн Элч нарыг илгээсэн нь Алладын нигүүлслийн үр дүн юм. Аллах Эзэн эдгээр ард түмний дотроос тэдний хэлээр ярьж, ойлгоход хялбар байхын тулд Гэгээн Элч нарыг дотроос нь сонгосон. Энэ талаар Аллах, Ибрахим бүлгийн 4-р эшлэлд ийнхүү айлдсан байдаг: *“Алладын зарлигийг сайтар тайлбарлаж өг гээд Бид гэгээн элч бүрийг зөвхөн өөрсдийнх нь ардад өөрсдийн хэлээр илгээсэн юм. Аллах хүссэн хэн нэгнийг төөрөгдүүлж, хүссэн хүнээ зөв зам руу хөтөлдөг. Аллах машид хүчирхэг бөгөөд мэргэн ухааны эзэн.”* Эдгээр эшлэлүүд нь Аллах хүмүүст тэнгэрлэг үнэнийг ойлгоход нь туслахын тулд тэдний хэлээр ярьдаг, Гэгээн Элч нараа илгээсэн болохыг харуулж байна. Гэхдээ энд тэнгэрлэг үнэн биш харин зөвхөн тэдний дамжуулж буй хэл нь өөрчлөгддөг болохыг анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл Аллах Эзэн өөрийн илгээж буй бүх нийтийн захиасыг өөр өөр хэлээр илгээсэн юм.

Хз. Салих, Хз. Худ, Хз. Юнус зэрэг зарим Элч нар тодорхой нийгэмд илгээгдсэн ч тэдний авчирсан захиаснууд нь бүх нийтийнх юм. Хз. Мухаммед (с.а.у.) сүүлчийн Гэгээн элч учраас бүх хүн төрөлхтөнд илгээгдсэн билээ.

Гэгээн элч нар өөрсдийгөө Алладын элч нар гэдгээ хэрхэн баталсан бэ ?

Гэгээн Элч нар Алладын тэдэнд өгсөн ер бусын гайхамшгуудын тусламжтайгаар хүмүүст

өөрсдийнхөө элч гэдгийг нотолсон. Мугжиза буюу ер бусын гайхамшиг гэдэг нь "хүн төрөлхтний хүч чадал хүрэхээргүй, Аллахын Элч нарын Гэгээн элч болохыг батлах зорилгоор тэдэнд олгосон ер бусын гайхамшигт үйл явдлууд" гэсэн утгатай.³² Гайхамшигт үйл явдлууд нь хүн төрөлхтний зүгээс бий болгох боломжгүй тул Гэгээн Элч нарын Аллахын Элч болох хамгийн агуу нотолгоо юм. Нөгөөтээгүүр, Гэгээн Элч нар бол нийгэмдээ үнэнч шударга, найдвартай гэдгээрээ алдартай хүмүүс юм. Энэ гайхамшгууд худлаа ярьдаггүй найдвартай эдгээр хүмүүсийн гарт байсан нь бас үнэмшилтэй хэрэг юм.

Гал Хз. Ибрахимд сэрүүн, хор хөнөөлгүй байх нь,³³ Сэмуд ардад илгэгдсэн Хз. Салихыг тэр нийгэмд нэн үнэ цэнтэй амьтанд тооцогдож байсан тэмээний гайхамшгаар дэмжих нь,³⁴ Хз. Муса таягаараа далайг хоёр хэсэг болж хуваасан нь,³⁵ Хз. Сулейманы тушаалд нь салхи өгөгдсөн нь,³⁶ түүнд шувуудын болон бусад амьд биетийн хэлийг заасан нь,³⁷ жин болон чөтгөрүүдийг эрхшээлдээ оруулах нь³⁸ Куран сударт дурдсан ер бусын гайхамшгуудын нэг жишээ юм. Аллах өөрийн Гэгээн элч нарыг илгээсэн нийгэмд хамгийн их хөгжин өрнөж буй бүс нутагт хүмүүсийг хүч чадалгүй болгож чадах ер

32 Бэкир Топалоглу, Юсуф Шэвки Явуз, Иляас Чэлэби, *Ислам дахь итгэл бишрэлийн үндэс* 389-р хуу. Мөн үзнэ үү. Халил Ибрахим Булут, "Ер бусын гайхамшиг", *ДИА*, 30-р боть, 350-352-р хуу.

33 Анбия, 21/69.

34 Аграф, 7/73; Худ, 11/64.

35 Таха, 20/77; мөн үхнэ үү. Шугара, 26/63.

36 Анбия, 21/81; Сад, 38/36.

37 Намл, 27/16.

38 Саба, 34/12-13; Анбия, 21/82.

бусын гайхамшгуудыг үзүүлэн дэмжсэн. Жишээлбэл, Хз. Мусагийн амьдарч байсан Египетийн нийгэмд ид шид хөгжсөн тул Аллах түүнийг луугийн гайхамшгаар хүчирхэгжүүлж, илбэчдийг чадваргүй болгосон аж.³⁹ Хз. Иса түүний амьдарч байсан нийгэмд анагаах ухаан хөгжсөн учраас үхэгсдийг амилуулах, сохор алаг нэгийг эмчлэх, шавраар шувуу хийж, жинхэнэ шувуу болгох гэх мэт гайхамшгуудаар дэмжигдсэн билээ.⁴⁰ Хз. Мухаммедын хамгийн агуу бөгөөд мөнхийн гайхамшиг бол Куран судар юм. Энэ тухай Аллах ийнхүү айлдав: *"Тэд: Түүнд Эзэнтнээс нь яагаад өөр нотолгоо бүхий ер бусын гайхамшгууд буулгагддаггүй юм бэ?" гэлцэнэ. Чи тэдэнд: "Нотолгоот ер бусын гайхамшгууд гагцхүү Аллахад буй. Харин би бол зөвхөн илэрхий сэрэмжлүүлэгч болой" хэмээн хэлэгтүн. Өөрсдөд нь уншигдаж буй Судрыг чамд Бид буулгах нь тэдэнд хангалтгүй гэж үү? (Үүнээс илүү ямар гайхамшиг хэрэгтэй юм бэ?) Энэхүү сударт сүсэглэн итгэсэн хүмүүсийн хувьд хайр талархал, ухуулга таниулга буй нь эргэлзээгүй."*⁴¹ Уран үгийн урлаг хөгжсөн нийгэмд Аллах, Гэгээн элчийг Куран судраар дэмжсэн бөгөөд үүнтэй төстэй зүйлийг авчрах боломжгүй юм.

Гэгээн Элч нар бүгдийг мэддэг үү? Гайбын талаар ямар нэгэн мэдээлэлтэй юу ?

Гэгээн Элч нар ч мөн адил хүн учраас тэд бүгдийг мэдэхгүй, мэдэж чадахгүй. Аллах вахигаар дамжуулан тэдэнтэй харьцдаг нь Гэгээн Элч нарын

39 Таха, 20/69-70.

40 Али Имран, 3/49.

41 Анкабут, 29/50-51.

бусад хүмүүсийн мэдэхгүй зүйлд эзэн болдог байна. Гэсэн хэдий ч Гэгээн Элч нар вахи хүлээн авсан ч тэдгээр нь тус бүр нь үндсэндээ хүн билээ. Мөн хүн зөвхөн Алладын зөвшөөрөгдсөн хэсгийг мэдлэгээрээ хүрээлж чадна. Тиймээс хэн ч, түүний дотор Элч нар хүртэл Аллах Эзний мэдэгдээгүй зүйлийг мэдэж чадахгүй. Гэвч Гэгээн Элч нар бүгдийг мэддэггүй байх нь тэдний буруу эсвэл дутуугаас үүдэлтэй биш юм. Энэ талаар Аллах Эзэн Куран сударт, Гэгээн Элч нартаа хандан хэлэхдээ: *“Тэдэнд: “Би та нарт, Алладын буян хишиг надад буй гэж хэлэхгүй. Мөн далдын нууцыг ч мэдэхгүй, өөрийгөө мэлэж (тэнгэрийн элч) гэж хэлэхгүй. Би гагцхүү Алладын илгээсэн бүхнийг дагаж мөрдөнө” хэмээн хэлэгтүн.*”⁴²

Гайб гэдэг нь бидний таван мэдрэхүйгээр ойлгож чаддаггүй хэсэг гэж тодорхойлж болно. Алладын мөн чанар, амин сүнс гэж юу болох, шүүлтийн өдөр болон ахирет ертөнцтэй холбоотой үйл явдлууд нь хүмүүс бидний хувьд үл үзэгдэх хамгийн энгийн асуудлууд юм. Бидний үл үзэгдэх (гайб) зүйлсийн талаарх мэдээллийн цорын ганц эх сурвалж бол садик (үнэн) мэдээ юм. Харин энэ мэдээг бидэнд, Аллах Эзний маань дамжуулсан шиг Гэгээн элч нар хүргэдэг юм.

Гэгээн Элч нар гэм нүгэлгүй гэж үү ?

Гэгээн Элч нарын "сыдк", "аманат", "фатанат", "исмат", "таблиг" гэсэн таван үндсэн шинж чанартай байдаг. "Сыдк" Гэгээн Элч нарын шударга үнэнч байх, "аманат"; тэдний итгэл найдвартай байдал,

.....
42 Ангам, 6/50.

“фатанат”; саруул ухаантай, сэргэлэн байх, “исмат”; нүгэл хилэнцээс ангид байх, нүглээс хамгаалагдах, “таблиг” гэдэг нь Аллахаас хүлээн авсан зарлиг, хорио цээрийг хүмүүст бүрэн дүүрэн хүргэхийг хэлдэг.

Гэгээн Элч нар амьдралынхаа аль ч үед үл итгэлцэл, олон бурхант үзэл, үгүйсгэлийн байдалд байгаагүй бөгөөд санаатайгаар нүгэл үйлдэж байгаагүй. Гэсэн хэдий ч тэд хүн төрөлхтөн учраас Элч нарын жижиг алдаанууд (зэллэ) нь Куран сударт хүмүүст илчлэгдсэн бөгөөд ингэснээр тэд бидний Аллахын албат нарт үлгэр дуурайлал болж чадна. Хз. Адам хориотой мод руу ойртох нь,⁴³ Хз. Муса санамсаргүйгээр хүний үхэлд хүргэсэн баримт,⁴⁴ Хз. Юнус номлолын бүс нутгийг орхиж явсан нь⁴⁵ Куран сударт дурдсан Гэгээн Элч нарын зэллэнүүд юм. Эдгээр нь Гэгээн Элч нарын зэрэглэлд хор хөнөөл учруулахгүй. Учир нь Гэгээн Элч нарын хэн нь ч бардам зан, өчүүхэн алдаан дээрээ тууштай байгаагүй билээ.

Куран судар дахь Абаса сурагийн буулгасанд хүргэсэн үйл явдал бол манай Гэгээн Элчийн зэллэгийн жишээ юм. Нэгэн өдөр манай Элч Мухаммед (с. а. у) харь шашны удирдагчидтай ярилцаж, хэрэв тэднийг ятгавал тэднийг дагасан хүмүүс Исламыг илүү амархан хүлээн авах болно гэж бодож байв. Харь шашны удирдагчдын нэгэнд Исламын шашныг тайлбарлаж байх үед тэдэнтэй хамт Абдулла б. Умму Мактум ирлээ. Гэгээн Элч (с. а. у.) яриагаа тасалдуулахыг хүсээгүй тул Абдулла (р. а.)-г ирэхэд сэтгэл нь түгшиж, сэтгэл дундуур

43 Бакара, 2/35-36; Аграф, 7/19-20.

44 Касас, 28/15.

45 Анбия, 21/87-88; Саффат, 37/139-148; Калэм, 68/48-49.

байгаа нь царайнаас нь илт байв. Үнэн хэрэгтээ энэ хамтрагч тухайн нөхцөл байдлын талаар мэдээгүй байв. Гэсэн хэдий ч Аллах өөрийн Гэгээн Элчдээ зэмлэсэн илэрхийллээр сэрэмжлүүлсэн Абаса бүлгийн эхний эшлэлүүдийг илгээсэн. Эдгээр эшлэлүүдээр Гэгээн Элчийн итгэгчдэд өгөх хүчин чармайлт нь илүү үр дүнтэй байх болно гэж хэлсэн бөгөөд энэхүү зөвлөгөө хэнд ашигтай вэ гэдгийг тэрээр тодорхой мэдэх боломжгүй бөгөөд ардын дотор нэр хүндтэй хүмүүст хариуцлага хүлээхгүй гэдгээ мэдэгдэв.⁴⁶ Гэгээн Элч маань Абдуллаг үе үе хараад “Өөрөөс нь болж Аллах намайг зэмлэсэн хүн та сайн байна уу!” хэмээн магтаж байсан гэж мэдээлсэн байдаг.⁴⁷ Энэ үйл явдалд санаатай болон байнгын үйлдсэн нүгэл байхгүй бөгөөд харин давтагдаагүй алдааны сэрэмжлүүлэг бий болохыг харуулж байна.

Расул болон Наби хоёрын ялгаа юу вэ ?

Аллахын зарлиг, хорио цээрийг хүмүүст хүргэхээр томилогдсон элч нараас сонгон авсан элч нарыг "Гэгээн Элч" гэж нэрлэдэг. Гэгээн Элч гэдэг үгийг перс хэлнээс манай хэлэнд орчуулсан байдаг. "Расул" гэдэг үгийг Араб хэлэнд Гэгээн Элч гэдэг үгэнд хэрэглэдэг. Расул бол шинэ ном, шинэ шариат, өөрөөр хэлбэл шинэ дүрэм, дадал зуршил бүхий хүмүүст илгээсэн Гэгээн элч юм. Нөгөөтээгүүр, “Наби” нь шинэ ном, шинэ шариатаар илгээгдээгүй, харин өмнөх Гэгээн элч нарын ном, шариатыг өөрийн ард түмэндээ хүргэх үүрэг хүлээсэн Элч юм.⁴⁸

46 Абаса, 80/1-12.

47 Ахмед б. Мухаммед б. Ибрахим эс-Салэби, *ел-Каиф вэл-Баян ан Тафсирил-Куран*, Дару Ияит-Түрасил-Араби, Баирут, 2002, X, 131.

48 Юсуф Шэвки Явуз, “Гэгээн Элч”, ДИА, 34-р боть, 257-262-р хуу.

Хз. Мухаммед сүүлчийн Гэгээн Элч мөн үү ?

Хз. Мухаммед бол хүн төрөлхтөнд зөв замыг харуулахын тулд Аллахаас илгээсэн удирдагчдын сүүлчийнх нь юм. Аллах Эзэн үүнийг Куран сударт бидэнд тодорхой илэрхийлсэн байдаг: *"Мухаммед бол та нарын дунд буй эрчүүдийн хэн нэгний эцэг нь бус. Тэр Аллахын гэгээн элч нарын сүүлчийнх нь болой. Аллах алив бүхнийг мэдэж байдаг."*⁴⁹ Энэ айлдвар нь Хз. Мухаммедээр Гэгээн Элчийн төгсгөл болсон гэсэн үг билээ. Энэ эшлэлд Хз. Мухаммед бол Гэгээн Элч нарын сүүлчийнх нь гэдгийг Аллахын илэрхийлэхийг илүүд үзсэн "хатем" гэдэг үг нь тамга гэсэн утгатай. Тамга гэх нь аливаа ажил, захидал, зарлиг гэх мэтийг битүүмжлэх мөн бичиж дуусгасны дараа хаах, дуусгахад хэрэглэгддэг. Ямар нэг зүйлд тамга дарах үед тэр үйл ажиллагаа дууссан гэх баталгаа юм. Иймээс Хз. Мухаммед бол Гэгээн Элч нарын сүүлчийнх бөгөөд Гэгээн элчийн дуусгавар болгож, бусад бүх Элч нарын нэгэн зэрэг хүлээн зөвшөөрдөг бурханлаг тамга юм.

Аллах бидний Гэгээн Элч Мухаммедыг дэлхий ертөнцөд өршөөл болгон илгээсэн нь юу гэсэн үг вэ. ?

Гэгээн Элч илгээх нь Аллахын хувьд үүрэг биш юм. Гэсэн хэдий ч тэрээр Гэгээн элч нар илгээсэн билээ. Аллах Гэгээн Элч нар илгээсэн нь Түүний нигүүлслээс өөр юу ч биш юм. Хүн мэдлэгийг бий болгож чадна, гэхдээ энэ шинж чанар нь

.....
49 Ахзаб, 33/40.

хязгаарлагдмал. Түүнээс гадна маш богино насалдаг. Энэхүү хязгаарлагдмал оршихуйн хувьд оршихуйн өргөн цар хүрээг бүрэн ойлгож, түүний практик болон онолын асуудлуудын талаар тайлбар өгөхөд маш хэцүү байдаг. Энэ утгаараа хүнийг удирдан чиглүүлэх Гэгээн Элч нарыг илгээх нь Алладын нигүүлсэл юм.⁵⁰

Өөрийн нигүүлслийн үр дүнд Гэгээн Элч нарыг илгээсэн бидний Аллах Эзэн бол сүүлчийн Элч Хз. Мухаммед (с. а. у.) -ыг *"дэлхий ертөнцөд энэрэл болгон"* илгээсэн.⁵¹ Учир нь Гэгээн Элч зөвхөн тодорхой нийгэмд төдийгүй бүх хүн төрөлхтөнд илгээгдсэн юм. Бидний Гэгээн Элчээр дамжуулан бүх хүн төрөлхтөн энэ ертөнц болон ахирет ертөнцөд аз жаргалыг хангах тэнгэрлэг илчлэлтэйд (вахид) хүрсэн юм.⁵²

Хз. Мухаммедэд маш олон салауат хэлэх нь Таухид итгэл үнэмшилд хор хөнөөл учруулж байна уу ?

Салауат бол Алладын нигүүлсэл, амар амгалан нь Гэгээн Элчид байхын төлөө хийсэн залбирлын нэр юм. Гэгээн Элчийг хайрлах, чин бишрэл, дэмжлэгийг илэрхийлдэг салауат нь тавхидын итгэл үнэмшилтэй зөрчилддөг гэж төсөөлшгүй юм. Учир нь Куран сударт: *"Аллах үнэндээ Гэгээн элчийг энэрэн хайрладаг. Мэлэжүүд ч түүнийг өргөмжлөн хүндэтгэдэг. Аяа, сүсэгтнүүд минь! Та нар ч түүнийг*

50 Бэкир Топалоглу, Юсуф Шэвки Явуз, Иляас Чэлэби, *Ислам дахь итгэл үнэмшлийн үндэс*, 151- руу.

51 Анбия, 21/107.

52 *Куран судрын зам*, 3-р боть, 705-р хуу.

дээдлэн, амрыг айлтгаж байгтун."⁵³ хэмээжээ. "Шүүлтийн өдөр надад хамгийн ойр байдаг хүмүүс бол надад хамгийн их салауат илгээдэг хүн байх болно."⁵⁴ хэмээн бидний Гэгээн Элч сүсэгтэн олонд салауат уншихыг уриалсан бөгөөд тэрээр Исламын эрдэмтэд салауат хэлэх нь сүннет гэж мэдэгджээ. Түүхийн туршид Гэгээн Элчийн тухай ярихдаа түүнд хүндэтгэлтэй хандаж, салауат илгээхийг үргэлж онцлон тэмдэглэж, түүний шафагатыг хүсэн хүлээсэн мүминууд үргэлж салауат их уншдаг байжээ.⁵⁵

Иудаизм, Христийн болон Ислам шашны хувьд Хз. Ибрахим ямар ач холбогдолтой вэ ?

Куран судар нь Ислам, Христ, Иудаизмын аль алинд нь чухал байр суурь эзэлдэг. Тэрээр "ханифуудын" нэг байсан гэж хэлдэг. ⁵⁶ Хз. Ибрахим ямар ч байсан зөв, үнэний талд байж, шударга бус явдалд бууж өгөхгүйгээр зөв замыг илүүд үзсэн учраас ийнхүү нэрлэгдсэн юм. Ялангуяа тавхидын итгэл үнэмшлийг баримталдаг бөгөөд тэрээр амьдарч байсан нийгэмдээ харийн үзлийг эсэргүүцдэг гэдгээрээ алдартай байв. Аллах, бидний Гэгээн элчээс ханиф болох Хз. Ибрахимыг шашныг дагаж,

53 Ахзаб, 33/56.

54 Тирмизи, Витр, 21.

55 Мехмет Суат Мертоглу, "Салатүсэлам", ДИА, 36-р боть, 23-24-р хуу.

56 "Ибрахим Еврей ч, Христ ч байгаагүй, Гагцхүү тэр, ханиф (Аллахын цорын ганц гэдгийг хүлээн зөвшөөрч, үнэн зөврүү тэмүүлдэг) мусульман юм. Олон бурхан шүтэгч буруу номтон ч биш ээ." Али Имран, 3/67.

замаа үргэлжлүүлээсэй гэж хүссэн.⁵⁷ "Ханиф" гэдэг үгийг үнэнч, чин сэтгэлтэй мусульманчуудын нэр томъёо болгон ашигладаг байна. Бидний Гэгээн Элч Мухаммедын (с.а.у) нэгэн хадист *"Би иудаизм, христийн шашинтай биш, харин хүлээцтэй ханиф шашинтай хамт илгээгдсэн болно."* хэмээн илэрхийлсэн байдаг.⁵⁸

Хз. Ибрахимын эхнэр Сарагийн хүүгийн нэрийг Исхак, нөгөө эхнэр Хажарын хүүг Исмаил гэдэг. Иудаизм ба Христийн шашин нь түүний хүү Исхакийн үр удам бөгөөд тэрээр өөрсдийгөө израйлчууд гэх гарал угсаагаас үүдэлтэй хэмээсэн байв. Бидний Гэгээн Элчийн удам угсаа нь Хз. Исмайлаар дамжуулан Хз. Ибрахимтэй холбоотой билээ. Еврейчүүд Хажарыг боол учраас хүлээж авдаггүй. Саре, Хз. Ибрахимийн эхнэр байсан тул амласан газар нь Хз. Ибрахимын өв залгамжлагчийн хувьд тэд түүнийг хүү Исаагаар дамжуулан өвлөн авсан гэж үздэг.

Энэ талаар онцлох хамгийн чухал зүйл бол элч Ибрахим бол гурван агуу бурханлаг шашны гишүүдийн зүгээс удирдагч хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн гэгээн элч юм. Иймээс иудаизм, христийн шашин ч мөн адил эвдрэхээс өмнө тавхидын зарчимд суурилж байсан бөгөөд эхний илчлэлийн үед энэ хоёр шашин Исламын нэгэн адил тавхидын зарчмыг хамгаалж байжээ. Хожим нь хүмүүс шашин шүтлэгийнхээ мөн чанарыг хадгалж чадаагүй учраас Аллахтай энэ зэрэгцэн

57 Нахыл, 16/120; Бакара, 2/135.

58 Ибн Ханбэл, V, 266.

тавхидаас холдсон тул бидний Аллах Эзэн Гэгээн Элч Мухаммедыг (с.а.у.) сүүлчийн Гэгээн элчээр илгээсэн юм.

Хэрэв анхны хүн элч юм бол бид бүгд элчийн удам мөн үү ?

Бүх хүн төрөлхтөн, анхны хүн ба анхны Гэгээн элч Адамаас гаралтай. Гэсэн хэдий ч Гэгээн элчийн удмаас ирсэн нь диваажинд орох болон тамаас холдох давуу тал биш юм. Хз. Адамын хоёр хүүгийн нэг нь дүүгээ хөнөөсөн, Хз. Нухын хүү эцгийгээ үгүйсгэж үерт живсэн нь үүний хамгийн тод жишээ юм. Товчхондоо, бид бүгд Гэгээн элч нарын удам угсаатай боловч Аллах биднийг итгэл бишрэл болон үйлдлээрээ энэхүү итгэл бишрэлд нийцсэн үйлдлээр үнэлдэг байна.

Хз. Мухаммедээс өөр бусад Гэгээн элч нар бас Мусульман байсан уу ?

Аллах өөр өөр цаг үед илгээсэн шашны үндэс нь ижил байдаг. Бүх Гэгээн элч нар хүмүүсийг зөвхөн Аллахад итгэхийг, өөрөөр хэлбэл тавхидэд урьсан. Хз. Адамаас эхлэн илгээсэн бүх жинхэнэ шашны нэр нь Ислам бөгөөд энэ шашинд итгэдэг хүмүүсийг мусульманчууд гэж нэрлэдэг. Аллах Эзэн үүнийг Куран сударт дараах байдлаар илэрхийлсэн байдаг: *"Та нар "Бид Аллахад, бидэнд илгээгдсэнд (Куранд), мөн Ибрахим, Исмайл, Исхак, Якуб болон тэдний ач зээ нарт илгээгдсэн сударт, Муса болон Исад илгээгдсэн сударт, мөн бүх гэгээн элч нарт,*

*Эзэнтний зүгээс илгээгдсэн судар номуудад итгэцгээнэ. Бид тэднийг алаг үзэхгүй, бид гагцхүү Түүнийг дагагч Мусульманчууд.” хэмээн хэлцгээ!*⁵⁹

Үнэн хэрэгтээ, “Ибрахим Еврей ч, Христ ч ч байгаагүй, эсрэгээр нь тэр ханиф мусульман байсан. Олон бурхан шүтэгч буруу номтон ч биш ээ.”⁶⁰ гэх айлдварт Бидний Аллах Эзэн өөрөө Ибрахимд "Мусульман" гэсэн нэр томъёог ашигласан байна. "Үнэндээ Аллахын дэргэдэх шашин бол Ислам юм."⁶¹ Хүмүүсийн хувьд Исламыг шашин болгон сонгосон Аллах болон түүний илгээсэн бүх Гэгээн элч нар нь үндсэндээ Мусульман байсан нь зүй ёсны хэрэг юм.⁶²

Хэрэв бүх Гэгээн элч нар Исламын шашныг хүлээн авсан бол яагаад тэд өөр өөр нэртэй янз бүрийн шашныг авчирсан бэ ?

Дэлхийн түүхийн туршид Аллах янз бүрийн үндэстэнд Гэгээн элч нар болон судар номуудыг илгээж, хүмүүсээс Өөрт нь мөргөн залбирахыг хүссэн. Хүн мөн чанар, бүтээлийн хувьд аль ч үед адилхан юм. Шашны зорилго нь хүмүүст Аллахад хэрхэн мөргөн залбирахыг зааж, улмаар амар амгаланг авчрах явдал юм.

Ислам гэдэг үгийн нэг утга нь Аллахын Гэгээн элч нарт илгээсэн шашны ерөнхий нэр юм. Бусад Элч нар өөр өөр нэртэй өөр шашныг авчраагүй

59 Бакара, 2/136.

60 Али Имран, 3/67.

61 Али Имран, 3/19.

62 Юсуф Шэвки Явуз, “Гэгээн элч”, ДИА, 34-р боть, 257-262-р хуу.

болно. Куран судраас сурснаар Гэгээн Элч бүрийн авчирсан шашин бол Ислам юм. Хэ. Адамаас Хэ. Мухаммед хүртэлх бүх Элч нар Ислам шашныг үнэн зөв аргаар дамжуулахаар илгээгдсэн: *"Үнэндээ Аллахын бататгасан шашин бол Ислам шашин юм. Өмнөх судрын эзэд (Иүдэй болон Христүүд) өөрсдөд нь үнэн мэдээлэл ирсний дараа хоорондын атаархлаар маргалдав. Хэрэв хэн нэгэн Аллахын айлдваруудыг үгүйсгэн эсэргүүцвэл (Аллах түүнийг цээрлүүлнэ) учир нь Аллах үтэр түргэн тооцоо хийнэ."*⁶³

Ислам бол бидний Гэгээн элч Мухаммедын авчирсан шашны оноосон нэр юм. Аллахын илгээсэн бүх шашин нь итгэл үнэмшил, шүтлэгт тулгуурладгаараа нийтлэг байдаг. Шашны үндэс болох итгэл бишрэл нь бүгдэд нь хэвээр байгаа ч амьдралын хэв маяг, мөргөлийн зан үйлийн хувьд тэдгээрийн хооронд зарим ялгаа бий. Бидний Аллах Эзэн, улс үндэстэнд тодорхой шариат, зам мөрийг тодорхойлсон аж.⁶⁴ Тиймээс тухайн иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн илгээсэн заалтад үе үе өөрчлөлт орж ирсэн. Жишээлбэл, манай шашинд мөргөл залбирал таван удаагаар хязгаарлагддаг бол Хэ. Мусагийн хуульд олон удаа үйлддэг байсан. Мөн зарим хоол хүнс Хэ. Мусагийн ард түмэнд хориотой байсан бол Гэгээн элч Мухаммедын үмметэд нь хориглогдоогүй байв.

63 Али Имран, 3/19.

64 Майда, 5/48.

Мугжиза буюу ер бусын гайхамшгууд нь зөвхөн Гэгээн элч нарт байдаг уу? Жирийн хүмүүст ч гэсэн гайхамшиг тохиолдож болох уу?

“Гайхамшиг” гэдэг нь Аллах Өөрийн Гэгээн элч болгон сонгосон албатаа бататган, дэмжихийн тулд бүтээсэн ер бусын үйл явдлуудыг хэлдэг бөгөөд хүмүүс үүнийг бий болгох боломжгүй байдаг. Гайхамшиг нь Гэгээн элч нарын гараар бий болж тохиолддог, гэхдээ тэдгээрийг бүтээсэн нь Аллах юм. Хэдийгээр зарим ер бусын нөхцөл байдал нь ер бусын гайхамшиг мэт харагддаг ч тэдгээрийн хооронд асар их ялгаа бий. Юуны өмнө ийм ер бусын гайхамшиг нь Элч биш хүмүүст ажиглагддаг. Ер бусын гайхамшигийг дуурайх ямар ч боломжгүй ч бусад онцгой үйл явдлыг дуурайж болно. Гэгээн элчийг үнэнчээр сахиж, түүнийг нямбай дагаж мөрддөг гэгээнтнүүдийн харуулсан ер бусын байдлыг "керамет" гэж нэрлэдэг. Нөгөөтээгүүр, "Мэунэт" бол бидний Аллах Эзэн өөрийн Мусульман боолыг зовлон зүдүүр, тарчлалаас нь аварсан онцгой үйл явдал юм.⁶⁵

Исламын шашны ойлголт дахь ер бусын гайхамшгууд (мугжиза) ба ер бусын үйл явдал (керамет) хоорондох ялгаа нь бусад шашинд байдаггүй. Тийм ч учраас тэд тэнгэрлэг хүчээр шашны болон энэхүү сэдвийн талаар хангалттай мэдлэгтэй хүмүүсийн илчилсэн ер бусын үйл явдлуудыг гайхамшиг гэж тодорхойлдог.⁶⁶

65 *Илмихал*, 1-р боть, 113-115-р хуу.


66 Салима Лайла Гүркан, “Ер бусын гайхамшиг”, *ДИА*, 30-р боть, 352-р хуу.



Ахирет ертөнцөд

ИТГЭХ

ИТГЭЛ



Ахирет гэж юу вэ ?

Исламын шашны итгэл үнэмшлийн дагуу хүний амьдралын үе шат, түүнийг ирээдүйд хүлээж буй нөхцөл байдлыг дөрвөн үе шаттайгаар илэрхийлдэг. Эдгээрийн эхнийх нь амин сүнс бий болсон цагаас бие махбодод үлээлгэх хүртэл дамждаг "сүнсний үе шат" юм. Хоёр дахь нь төрсөн цагаас эхэлж үхлээр төгсдөг "дэлхий дээрх амьдрал", гурав дахь нь үхлээр эхэлж дахин амилах хүртэл үргэлжлэх "булшин дахь амьдрал", сүүлийн шатанд "хойд ертөнцийн амьдрал (ахирет ертөнц)" байдаг. Энэ нь дахин амилалтаас эхэлж үүрд үргэлжилдэг юм.¹

Ахирет гэдэг нь араб үг. Энэ нь "эцсийн, дараагийн" гэсэн утгатай ахир гэдэг үгнээс гаралтай юм. Оршин буй бүхэн төгсгөлтэй байдаг шиг ертөнцийн амьдрал төгсгөл байдгийг сануулсан энэ үг ертөнцийн дараа эхэлж, мөнхөд үргэлжлэх бидний амьдралыг илэрхийлдэг. Куран судар дахь Гэгээн Элч нарын дамжуулсан үхлийн тухай итгэл үнэмшил нь итгэлийн зарчмуудад тодорхой багтсан бөгөөд эцсийн ертөнцийг үгүйсгэдэг хүмүүст төөрөлдсөн гэж анхааруулдаг. *"Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахад, Түүний элч нарт, тэдэнд илгээсэн ариун сударт итгэцгээгтүн. Хэн Аллахад, Түүний мэлэкүүдэд,*

1 Бекир Топалоглу, Юсуф Шэвки Явуз, Иляас Чэлэби, *Ислам дахь итгэл үнэмшлийн үндэс*, 265-р хуу.

*ариун судруудад, гэгээн элч нарт үл итгэж, ертөнцийн төгсгөлийн өдрийг үгүйсгэвэл үнэнхүү төөрөгдөлд орно."*²

Куран судар бидэнд ахирет ертөнцөд болох болон оюун ухаанаар мэдэх боломжгүй бөгөөд мөн түүнчлэн үхэл, дахин амилалт, шүүлтийн өдөр, мизан, диваажин, тамын тухай мэдээллийг өгдөг. Куран судраас сурсан зүйлийнхээ дагуу бидний амьдарч буй ертөнц болон түүний доторх бүх зүйл түр зуурын хугацаанд бүтээгдсэн билээ.³ Цаг нь ирэхэд орчлон ертөнцийн дэг журам эвдэрч, амьд ба амьгүй бүхэн мөхөх болно. Куран сударт энэ үйл явдлыг “киямет” буюу шүүлтийн өдөр гэж тодорхойлсон байдаг. Исрафил хэмээх сахиусан тэнгэр бүрээ үлээж⁴, ертөнцийн төгсгөл ирж, киямет бүх аймшигтайгаар сүйрэх болно. *"Нарны илч унтарсан цагт, Одод нуран унасан цагт, Уулс байрнаас хөдөлсөн цагт..."*⁵ гэсэн хэллэгүүд хэрхэн хорвоо ертөнц сүйрч, орчлонгийн дэг журам алдагдахыг тод илэрхийлдэг. Хоёр дахь удаагаа бүрээ үлээхэд бүх амьд биет дахин амилах болно.⁶ Хоёр дахь удаагаа амилсны дараагаар махшэр гэх өргөн уудам газарт цугларах⁷ ба үйлсийн дэвтэр тараагдсаны дараа тооцоолол хүртэл харагдах⁸ бөгөөд эцсийн нарийн зүйл, мөн үр дүнгийн дагуу там ба диваажин руу явах хүмүүс тодорхой болохыг⁹ Куран сударт тодорхой өгүүлсэн байдаг. Энэхүү шинэ амьдрал эхлэх өдрөөс эхлэн үүрд үргэлжлэх

2 Ниса, 4/136.

3 Анкабут, 29/64; Мүмин, 40/39; Хадид, 57/20.

4 Лүтфуллах Жэбэжи, “Исрсфил”, ДИА, 23-р боть, 180-181-р хуу.

5 Такуир, 81/1-3.

6 Наба, 78/18.

7 Худ, 11/103.

8 Анбия, 21/47.

9 Кариа, 101/6-9; Аграф, 7/8-9.

бодит бөгөөд мөнхийн амьдрал бол бидний ахирет буюу хойд насны амьдрал юм.

Ариун Куран судар болон үнэн зөв хадиснуудад тодорхой тусгаж, дэлгэрэнгүй тайлбарласны дагуу хойд насны итгэл үнэмшил нь хүн төрөлхтний түүхийн эхэн үеэс эхлэн Бурханы оршин тогтнохыг хүлээн зөвшөөрдөг бараг бүх шашин, сэтгэлгээний системд багтсан байдаг.¹⁰

Ахирет ертөнц байдаг ? гэдгийг хэрхэн ойлгох вэ ?

Ахирет ертөнцөд итгэх итгэл нь Ислам шашны итгэл үнэмшлийн үндсэн зарчмуудын нэг юм. Куран судрын олон эшлэлд Аллаhad итгэх итгэл нь хойд ертөнцөд итгэх итгэлтэй хамт дурдагддаг бөгөөд үүнийг үгүйсгэгчид Аллаxыг үгүйсгэдэг гэж тодорхойлсон байдаг.¹¹ Ахирет бол Аллах болон бүх Гэгээн элч нарын бидэнд маргаангүй тайлбарласан итгэл бишрэлийн нэг юм. Бүх бурханлаг шашин ийм итгэл үнэмшилтэй байдаг. Гэтэл хойд хорвоогийн амьдрал бол бидний нүдээр харж, мэдрэхүйгээр ойлгодог амьдрал биш билээ. Ирээдүйн оршихуйг шинжлэх ухааны аргуудаар нотлох боломжгүй. Киямет хэрхэн тохиох ба ахирет ертөнцийн талаар зөвхөн эшлэлүүдээс болон үнэн зөв хадиснуудаас мэдээлэл авч болно.

Куран сударт үхлийн дараах амьдралын тухай дурдаагүй суре/бүлэг бараг байхгүй билээ. Үхсэний

10 Бекир Топалоглу, “Ахирет”, ДИА, 1-р боть, 543-р хуу.

11 Бакара, 2/4, 62, 177; Ниса, 4/38; Рагьд, 13/5.

дараа дахин амилах нь хэрхэн боломжтойг өвлийн улирлаас хаврын улирал руу шилжих үед тохиолддог байгалийн үйл явдлуудаар тайлбарладаг.¹² Зарим эшлэлүүдэд хүн төрөлхтнийг бүтээх нь энэхүү эмх цэгцтэй, системтэй орчлон ертөнцийг бүтээхээс илүү хэцүү биш гэдгийг өгүүлсэн бөгөөд дахин бүтээх нь анх бүтээж байгаагаас хамаагүй хялбар болохыг үлгэр жишээ болгон бидний оюун ухаанд суурилуулж өгсөн байдаг.¹³ Мөн хойд насанд (ахирет) итгэдэггүй хүмүүс чин сэтгэлээсээ үйл хөдлөл гаргадаггүй, ихэмсэг, өршөөлгүй, үгүйсгэгчид байдаг тухай эшлэлүүдэд өгүүлсэн байдаг.¹⁴

Куран судраас гадна биднийг хойд ертөнцийн оршихуйд хөтлөх оюун санааны олон нотолгоонууд бий. Аллах биднийг хамгийн үзэсгэлэнтэйгээр бүтээж, орчлон ертөнцийг бидний төлөө бий болгосон юм. Энэ амьдрал үхлээр төгсгөл болдог нь оёдолчны гоё даашинз оёж үүнийг хаяхтай адил юм. Бидний амьдрал гагцхүү хойд ертөнц оршин тогтнож байж утга учиртай болдог. Амьд байхдаа тайлбарлаж чадахгүй бүх төрлийн үйл явдал, харгислал, шударга бус байдал, зовлон шаналлыг нөхөн төлөх цаг хугацаатай байх нь бидний шударга ёсны мэдрэмжийг хангадаг байна. Энэ дэлхий дээр хүн бүр гэмт хэргийнхээ төлөө бүрэн шийтгэгддэггүй билээ. Шударга ёс биелэх, муу муухай шийтгэгдэх, сайныг шагнадаг амьдрал байхгүй бол тохиолдсон шударга бус байдал, харгислал, зовлон шаналлыг ойлгох боломжгүй болно.

.....
12 Зухруф, 43/11; Ясин, 36/33.

13 Рум, 30/27; Ясин, 36/79; Саффат, 37/11; Мүмин, 40/57.

14 Нахыл, 16/22; Жасия, 45/24; Мутаффифин, 83/10-14.

Бидний амьдрал дахь "урт наслах хүсэл" нь ахирет ертөнцийн бий болохыг мэдрүүлдэг нэгэн баталгаа юм. Бид бүгдэд хязгааргүйн хүсэл мөрөөдөл бий. Энэхүү хүслийн ханах газар бол хойд нас ахирет юм. Бүх зүйл үхлээр төгсдөг нь биднийг цөхрөл, стресст оруулдаг. Төгсгөлийн ертөнц (ахирет) байгаа нь бидний амьдралыг сэтгэл зүй, нийгмийн талаас илүү утга учиртай болгодог байна.

Ахирет ертөнцөд итгэх нь бидний өдөр тутмын амьдралд хэрхэн нөлөөлөх вэ¹⁵?

Ахирет ертөнцөд итгэх нь бүх хүмүүсийн үхлээр төгсдөг мөхлийн дараах мөнх амьдрал оршин тогтнох болно гэдэгт итгэх явдал юм. Хүн угаасаа үүрд мөнхийг хүсдэг ба мөнх амьдрахыг хүсдэг. Хүмүүсийн зарим сүнслэг мэдрэмжүүд нь энэ ертөнцийн түр зуурын таашаал ханамж авч чадахгүй гэдгийг сэтгэлгээний түүх харуулж байна. Энэ утгаараа, ирээдүйд итгэх итгэл нь хүний өөрийн бий болсон мөн чанартай нийцүүлэн ажиллах боломжийг олгодог. Бидний Аллах Эзэн хүмүүсийг янз бүрийн зүйлд хэрэгцээтэй байхаар бүтээсэн бөгөөд эдгээр хэрэгцээг хангах буян хишгийг ч бий болгосон юм. Жишээ нь, Тэрээр идэж уух хэрэгцээтэй бүтээсэн албат нарынхаа хэрэгцээг хангахын тулд төрөл бүрийн хоол, ундыг бүтээсэн билээ. Хайрлах чадварыг зүрх сэтгэлд нь суулгахын зэрэгцээ хайраа чиглүүлж чадах эцэг эх, үр хүүхэд,

.....
15 Сэдвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү. Темел Ишилжурт, Мехмет Ташдэлэн, "Ахирет ертөнцөд итгэх итгэлийн бодит тусгал", *Калам судлалын сэтгүүл*, 2012, 10/2, 55-68-р хуу.

хань ижил бий болгосон. Тэр Өөрийн боолыг тодорхой мэдрэмж, хэрэгцээ шаардлагаар бүтээгээд дараа нь тэр хэрэгцээнд нь хариу өгөхгүйгээр түүнийг ганцаарыг нь орхисонгүй. Хүнд мөнхийн хүсэл тэмүүллийг өгдөг Аллах түүний хүсэл, хэрэгцээг хангахын тулд хойд амьдралыг бүтээжээ. Хүн төрөлхтний түүхийн шинжлэх ухаан, урлаг, соёлын өв нь хүн төрөлхтөнд үхэшгүй мөнхийн эрэл хайгуулын үр дүн юм.

Ирээдүйд итгэх итгэл нь хүмүүст амьдралын итгэл найдвар төрүүлж, амьдралыг хялбар болгодог. Хүн өөрт тохиолдсон олон асуудал болон зовлон зүдүүрийг даван туулахад амаргүй байдаг. Ахирет ертөнцөд итгэх нь хүмүүст тайвшралыг олж, өвдөлтөөс өөрийгөө хамгаалахад тусалдаг. Энэ нь найдвар, амьдралын баяр баясгаланг сэргээдэг. Энэ хорвоод өөрт тохиолдох үйл явдалд тэвчээртэй хандаж, хүлээцтэй хандсаныхаа хариуд хойд насандаа хэд дахин их шагналыг хүртэх болно гэдэгт итгэх нь хүнийг амьдралын бэрхшээлд тэсвэртэй болгодог. Ахирет ертөнцөд итгэдэггүй хүн аливаа бэрхшээлийг даван туулах чадвараа хурдан алдаж, цөхрөлд ордог.

Ахирет ертөнцөд итгэдэг хүн сайн үйлсийнхээ үр шимийг хүртэнэ гэдгээ ухамсарлаж, энэ хорвоод амьдралаа дэмий хоосон зүйлээр өнгөрөөхийн оронд өөртөө болон бусдад ашиг тустай зүйлээр өөрийгөө завгүй байлгадаг. Өөрөөр хэлбэл, хойд ертөнцөд итгэх итгэл нь хүнийг муу муухайгаас сэргийлж, төрөлхийн хүний мөс чанар, шударга ёсны мэдрэмжийг хангадаг. Жинхэнэ шударга ёс

энэ хорвоод биш, хожимдоо тогтоно гэдэгт итгэдэг хүн шударга бус явдлын өмнө цөхрөхгүй. Хорвоо дээр байх хугацаандаа чадах бүхнээ хийснээрээ Аллах Эзэндээ хорогддог.

Ахирет ертөнцөд итгэх итгэл нь хүний үүрэг хариуцлагаа ухамсарлаж, амьдралд нь утга учир нэмдэг. Хэрэв бид энэ хорвоод хийсэн сонголтдоо хариуцлага хүлээхгүй, энэ хариуцлага тооцогдох амьдрал гэж байхгүй байсан бол дэлхий ертөнц бий болох цагаасаа эхлээд шүүлтийн өдөр хүртэл хүчирхэг талын шударга бусаар хийсэн бүх зүйл өөрт ашигтай байх байсан. Ахирет ертөнцөд итгэх итгэл нь хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ гэсэн бодол нь хүмүүсийг өөртөө болон бусдад шударга бус авирлахаас сэргийлж, түүний зан үйлийн чиглэл, зорилтыг тогтоодог.

Эцэст нь, хойд ертөнцөд итгэх итгэл нь хүмүүсийн үхэл болон цаашлаад үл мэдэгдэх зүйлийн талаарх түгшүүрийг бууруулдаг. Үхлийн дараах амьдрал байдаг гэдэгт итгэдэггүй хүн ирэх бүрийг хар бараан төгсгөл, мөхөл рүү хөтөлнө гэж бодож зовж шаналах болно. Тэрээр хоосон мэдрэмж төрж, төгсгөлийн тухай бодохоос сатааруулах бүх төрлийн сөрөг үйлдлүүдийг хийж эхэлдэг. Ахирет ертөнцөд итгэдэг хүн харин ч эсрэгээрээ үхлийг мөхөх биш мөнх амьдралын эхлэл гэж үзэж, сайн үйлс, зан үйлээрээ өөртөө болон бусдад тустай байхын тулд бэлтгэлээ базаахыг хичээдэг байна.

Одоо дэлхийн бүх хүмүүс хойд насандаа итгэж, том жижиг гэлтгүй хийсэн бүхнийхээ хариуцлагыг

үүрэх, хэзээ ч мултарч чадахгүй шүүх өдөр байгаа мэтээр сэтгэж ажиллана гэж төсөөлье. Дэлхий ямар байх байсан гэж та бодож байна вэ?

Дэлхийн төгсгөл гэж бий юу? ?

Исламын шашны итгэл үнэмшлийн дагуу дэлхий ертөнц эхлэлтэй төдийгүй төгсгөлтэй байдаг. Куран сударт энэ ертөнцийн амьдрал түр зуурынх гэдгийг онцолсон байдаг. Рабб Эзэн маань *“Энэ хорвоогийн амьдрал ахуй бол түр зуурын хуурамч зугаа төдий зүйл. Жинхэнэ баттай мөнх орон бол хойд хорвоо мөн!”*¹⁶ Дэлхийн төгсгөл ирнэ гэсэн итгэл нь иудизм, христийн шашинд ч байдаг.

Аллах Эзэн бол орчлон ертөнцийг бүтээж, байгалийг зохицуулах хууль тогтоомжийг тогтоодог юм. Цаг нь ирэхэд, өөрөөр хэлбэл Исрафил хэмээх сахиусан тэнгэрт бүрээ үлээхийг тушаахад тэрээр эдгээр хуулиудыг тогтоож шүүлтийн өдөр бүх зүйлийг орвонгоор нь эргүүлэх нь зөвхөн Аллахын хүслээр юм. Хүний амьдралтай адил ертөнцийн амьдралыг Төгс Хүчит Аллах тогтоодог. Мусульман хүн ертөнц төгсгөл болж, киямет өдөр ирнэ гэдэгт итгэдэг.¹⁷

Киямет өдөр ойртож байгааг бид яаж ойлгох вэ ?

Шүүлтийн өдрийг бидний Аллах Эзнээс өөр хэн ч хэзээ болохыг мэдэх боломжгүй. Гэтэл энэ

.....
¹⁶ Мүмин, 40/39.

¹⁷ Мустафа Чагрижи, “Газар”, ДИА, 43-р боть, 476-478-р хуу.

мэдээллийг биднээс нуун Аллах Эзэн маань Куран судар болон Гэгээн Элч (с.а.у.)-ын үгсээр дамжуулан кияметийн тэмдэг/шинж тэмдгийг бүх хүмүүст илчилсэн юм.

Шүүлтийн өдөр зарим шинж тэмдгүүд нь үүссэн байдлын хувьд удаан хугацаанд тархаж, шашны зарлигийг үл тоомсорлох, ёс суртахууныг завхруулах зэрэг хүний хүслийн улмаас үүсдэг. Бидний Гэгээн Элчийг илгээж, үүний дараа ахин Гэгээн элч илгээгдэхгүй болох нь, мэдлэг устаж, мунхаглал нэмэгдэх, архи дарс ууж, садар самуун явдал ил тод болох, мэдлэггүй хүмүүсийн дуу нь чанга гарах, аллага ихсэх, дэлхийн эд хөрөнгийн элбэг дэлбэг байдал, зекат өгөх ядуу хүмүүс олдохгүй байх гэх мэт шүүлтийн өдрийн шинж тэмдгүүдийг дурдаж болно.¹⁸

Эдгээр шинж тэмдгүүдээс гадна Гэгээн Элч (с.а.у.) *“Шүүлтийн өдрөөс өмнө арван шинж тэмдгийг харахгүйгээр дэлхий ертөнц мөхөхгүй.”*¹⁹ гэж айлдаж, мөхлийн өмнөхөн ар араасаа гарч болох зарим үйл явдлуудын талаар өгүүлсэн байдаг. Эдгээр үйл явдлууд нь байгалийн хуулиас давж, хүний хүсэл зориг, хөндлөнгийн оролцоогүйгээр тохиолддог үүнд; мэдээлсэн утаа, антихрист, даббатул арз, баруунаас мандах нар, Яжуж, Мажуж гарч ирэх, Элч Иса тэнгэрээс бууж ирэх, газар нурах ба гал гарч ирэх.²⁰

18 Бухари, Тафсир, (Назиат) 1, Худуд, 20, Фитен, 25; Тирмизи, Фитен, 34; Ибн Маже, Фитен, 25;.

19 Мүслим, Фитен, 39; Ебу Давуд, Мелахим, 11; Ибн Маже, Фитен, 28.

20 Мүслим, Фитен, 39; Ебу Давуд, Мелахим, 11; Ибн Маже, Фитен, 28.

Киямет хэзээ болох вэ ?

Түүхийн туршид хүмүүс энэ талаар гайхаж ирсэн бөгөөд цаг үе бүрт энэ сэдвээр янз бүрийн таамаглал, зөгнөл гарч ирсэн. Гэсэн хэдий ч сүүлчийн өдөр хэзээ ирэхийг зөвхөн бидний Аллах Эзэн л мэднэ. Куран сударт: *“Аяа, Мухаммед) Тэд чамаас ертөнцийн төгсгөлийн өдөр хэзээ болохыг асууцгаана. Ийн хэл: “Түүний талаарх мэдээллийг зөвхөн Рабб эзэн мэднэ. Хүссэн цагт ирүүлнэ.Тэдэнд: “Түүний хэзээ тохиохыг Аллах л мэднэ. Ертөнцийн төгсгөл нь тэнгэр, газарт (түүнд буй бүхэнд) хүнд нүсэр ачаалалтай үйлс. Тэр та нарт ч гэсэн санамсаргүйгээр тохиох болно” гэж хэл. Тэд энэ тухай чамайг тодорхой мэддэг юм шиг асуудаг бөлгөө. Тэдэнд: “Түүнийг зөвхөн Аллах мэднэ. Гэвч, хүмүүсийн олонх нь үүнийг үл ойлгодог” хэмээн хэлэгтүн.*²¹

Хүмүүс үхлийг хүлээж авдаггүй ч хүн бүрийн мөхөл өөрийн үхлээс эхэлдэг. Гэгээн элчээс: "Аяа Аллахын элч минь, шүүлтийн өдөр хэзээ болох вэ?" гэж асуусан хүнд, *"Чи хариу өөрөө юу бэлдсэн бэ?"* хэмээн хариу өгсөн билээ.²² Мусульман хүн сүйрлийн өдөр хэзээ ирэх вэ гэдэгт санаа зовох хэрэггүй, харин түүнд бэлдэх хэрэгтэй. Хэрвээ бид Аллах Эзэн ба Гэгээн Элчээ чин сэтгэлээсээ хайрлаж, Аллах болон Түүний элчийн хүссэн замаар амьдрахыг хичээвэл бид шүүлтийн өдөрт хамгийн сайнаар бэлтгэгдэнэ.²³

21 Аграф, 7/187.

22 Бухари, Едеб, 96.

23 Бекир Топалоглу, “Киямет”, ДИА, 25-р боть, 516-522-р хуу.

Шүүлтийн өдрийн дараа бид юутай тулгарах вэ ?

Куран сударт өгүүлснээр киямет өдөр, Исафил хэмээх сахиусан тэнгэр “сур” хэмээх бүрээ үлээхэд төгсгөл ирнэ.²⁴ Бидний тодорхой мэдэхгүй хэсэг хугацааны дараа бүрээ хоёр дахь удаагаа үлээгдэн дахин амилах (ба'с) болно.²⁵ Энэ амилалтад бие болон амин сүнс цуг байх болно. Амилсан хүмүүсийг Махшар (арасат) хэмээх газар цуглуулж,²⁶ хүн бүрд өөрсдийн үйлсийн дэвтэр өгөгдөх бөгөөд энэ нь дэлхий дээрх тэдний амьдралын нэгэн төрлийн бүртгэл юм.²⁷ Кирамин, Катибин хэмээх тэнгэр элчнүүдийн тэмдэглэсэн эдгээр дэвтрүүд нь баруун талаасаа диваажинд очих хүмүүст, зүүн эсвэл ар талаас нь тамд орох хүмүүст танилцуулагдах болно.²⁸ Энэ үед Аллах хүмүүсийг нэг нэгээр нь шүүн тооцож эхэлнэ.²⁹ Энэхүү бүртгэлийн явцад хүмүүс хаана, хэрхэн амьдралаа өнгөрөөсөн, залуу насаа хэрхэн өнгөрөөсөн, баялгаа хаана олж, хаана зарцуулсан, мэдсэн зүйлээ хэрэгжүүлсэн эсэхийг асуух болно.³⁰ Шүүлтийн дараа тэнгэрлэг шударга ёсны хэмжүүрээр (мизан)³¹ ертөнцөд хийсэн үйл, үйлс нь жинлүүр дээр хэмжигдэж, хэний ч эрх хэнд ч үлдэхгүй, жин нь хүнд байгаа нь аврагдаж, жин нь хөнгөн нь тамд очно. Мизаны дараа хүн

24 Ясин, 36/49.

25 Ясин, 36/51. Бүрээ хоёр удаа үлээх тухай хадисүүдийн талаар үзнэ үү. Бухари, Анбия, 35; Мүслим, Фитен, 116, 141, Фезаил, 159.

26 Али Имран, 3/158; Ангам, 6/51, 72, 128; Саба, 34/40; Ахкаф, 46/6.

27 Ангам, 6/60; Анбия, 21/94; Каф, 50/18; Зухруф, 43/80.

28 Хакка, 69/18-26; Иншикак, 84/6-12.

29 Бухари, Тафсир, (Бен Израил) 5; Мүслим, Иман, 322-328.

30 Тирмизи, Сыфатул-кыяме, 1.

31 Анбия, 21/47.

тамд байрладаг Сиратыг дайран өнгөрөх болно; Диваажингийн хүмүүс энэ замыг хурдан бөгөөд амархан гүйцээх бол тамын хүмүүс туулж чадахгүйд хүрнэ.³² Энэ үеэс хойш мөнх амьдрал эхлэх болно.

Дахин амилалт ямар байх вэ ?

Дахин амилалт буюу "ба'с" гэдэг нь Шүүлтийн өдөр Аллах албатуудаа булшнаас нь гаргаж, мөнх амьдрал эхлэхийн тулд тэднийг дахин амилуулна гэсэн үг юм. Дахин амилалт нь Исламын шашны итгэл үнэмшлийн нэг үндэс бөгөөд үүнийг үгүйсгэсэн хэн бүхэн шашнаас гардаг.³³ Бидний Аллах Эзэн амилалтын тухай *"Та нар амьгүй байхад (хараахад бий болоогүй байхад) та нарыг амилуулсан (энэ ертөнцөд) Аллаhad яагаад үл итгэцгээнэ вэ? Цаг нь болоход бас л үхүүлж, дараа нь дахин амилуулна. Тэгээд (хамгийн сүүлд) тайлан тавихын тулд Аллахын өмнө очигцоох болно."*³⁴ хэмээн айлдав. Эхийнхээ хэвлийд оргүйгээс бүтсэндээ гайхдаггүй хүн яаж дахин бүтээгдэх бол гэж гайхдаг нь хачирхалтай. Аллах Эзэн маань Мариям бүлэгт: *"Хүмүүс: "Би үхсэнийхээ дараа үнэхээр дахин амилан (булнаасаа) гарах юм гэж үү дээ?" хэмээн асуудаг. Урьд нь юу ч биш байхад, Бид түүнийг хоосноос бий болгон бүтээснийг хүмүүсийн үр сад бодохгүй гэж үү?"*³⁵

Бидний Аллах Эзний хэлснээр бол оргүй хоосноос бий болгож байгаагаас хоёр дахь удаагаа бүтээх нь илүү хялбар байдаг. *"Амьд ахуйг үгүйгээс (хоосон) бий*

32 Бухари, Езан, 129; Тавхид, 24; Мүслим, Иман, 302, 329.

33 Юсуф Шевки Явуз, "Ба'с", ДИА, 5-р боть, 98-99-р хуу.

34 Бакара, 2/28.

35 Мариям, 19/66-67.

болгосон, түүнийг үхүүлж дахин амилуулдаг нь Аллах. Энэ бол Түүнд машид хялбар."³⁶ Мэдээжийн хэрэг, хэцүү зүйлийг бүтээсэн нь илүү хялбар зүйлийг бүтээж чадна. Ахкаф бүлгийн 33-р эшлэлд, Тэнгэр газрыг бүтээж, бүтээхдээ ядрахгүй байсан Аллах үхэгсдийг амилуулах чадвартай гэж өгүүлсэн байдаг. Үхсэн байгалийг дахин дахин амилуулдаг Аллах ч бас хүнийг амилуулж чадна.³⁷ Аливаа зүйлийг эсрэг тал болгон хувиргадаг түүний адил зүйлийг дахин бүтээж чадна. Жишээлбэл, ус ихтэй ногоон модноос гал гарах бараг боломжгүй ч ногоон модноос гал гаргаж авдаг Аллах³⁸ мөн хүнийг дахин бүтээж чадна.

Бүрээний эхний үлээлтээр бүх амьд биетүүд алга болсны дараа, хоёр дахь үлээлтээр үхсэн амь бүхэн амилж байрнаасаа босон,³⁹ гүйж байгаа мэт хөдөлж,⁴⁰ Аллах Эзнийхээ өмнө гарч ирнэ⁴¹ гэдгийг Аллах Эзэн бидэнд илчилсэн юм. Амилалт нь үнэнийг олж мэдэхийн тулд болон дэлхий дээрх үйлдлийнхээ үр дагаврыг харахын тулд амилах болно.⁴² Ахли Суннагийн итгэл үнэмшлийн дагуу амилалт нь бие махбодь болон амин сүнсний аль алианаар нь тохиолдох болно. Диваажин, тамын хүмүүст өгөх адислалууд, Куран судар болон хадисуудад хэрэглэгдэх шийтгэлүүдийг харахад хойд насны амьдрал нь бие махбод, өөрөөр хэлбэл бие болон амин сүнснээс (өөрөөр хэлбэл хийморь) бий болох

36 Рум, 30/27.

37 Хажж, 22/5-7.

38 Ясин, 36/80-81.

39 Зүмер, 39/68.

40 Магариж, 70/43.

41 Ясин, 36/51.

42 Нахыл, 16/38-39; Тагабун, 64/7.

нь тогтоогдож үргэлжилж байгаа нь тодорхой харагдаж байна.⁴³ Үүний дагуу хүн үхэж, ялзарсны дараа Аллах түүний биеийн чухал хэсгүүдийг нэгтгэж эсвэл ижил төстэй зүйлийг бүтээж, сүнсийг нь энэ биед буцааж оруулах болно. Гэгээн Элчийн хэлснээр бол хүн нас барсны дараа ахар сүүлний яс (ажбүз зенеб) -аас бусад бүх зүйл ялзарч алга болно. Шүүлтийн өдөр хүн энэ мууддаггүй хэсгээс амилах бөгөөд амилалтынхаа үеэр булшнаас эсвэл энэ мууддаггүй хэсэг нь байгаа газраасаа хөрснөөс ургамал гарч ирэх шиг хурдан амилах болно.⁴⁴ Хүмүүст хариуцлага тооцож, үйлсийг нь хэмжих бөгөөд үйлсийнхээ хариуд диваажин эсвэл там руу илгээгдэнэ.⁴⁵

Диваажин, там хоёр мөнх мөн үү ?

Диваажин дахь амьдрал мөнх байх болно гэдэгт Исламын эрдэмтэд санал нэгддэг.⁴⁶ Ариун Куран судар диваажин дахь амьдрал ямар байхыг илэрхийлэхдээ мөнх байхын тухай олон эшлэлд онцолсон байдаг. Эдгээр эшлэлүүдийн нэгэнд энэ байдлыг дараах байдлаар илэрхийлсэн байдаг: *"Тэнд сэтгэл сэргээх, нүд баясгах зүйлс хүрэлцээтэй буй. Та нар диваажинд эгнэгт оршмуй."*⁴⁷

Чухамдаа диваажингийн хүмүүс тэндээс хөөгдөхгүй, үхлийг амсахгүй, диваажингийн ерөөл барагдахгүй,

43 Юсуф Шевки Явуз, "Ба'с", ДИА, 5-р боть, 99-р хуу.

44 Бухари, Тафсир, (Наба) 1; Мүслим, Фитен, 141-142.

45 Сэдвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү. Юсуф Шевки Явуз, "Ба'с", ДИА, 5-р боть, 98-100-р хуу; Сүлейман Топрак, "Хашыр", ДИА, 16-р боть, 416-417-р хуу.

46 Бекир Топалоглу, "Диваажин", ДИА, 7-р боть, 385-386-р хуу.

47 Зухруф, 43/71.

мөнхөд байх болно гэж янз бүрийн эшлэлд өгүүлсэн байдаг.⁴⁸ Там мөнх мөн үү гэх асуултын хувьд хэдий там өөрөө мөнх ч⁴⁹ зарим хүмүүсийн тамын амьдрал мөнх биш юм. Үл итгэх байдал болон ширк нь тамд үүрд үлдэх шалтгаан юм. Кафир болон мүшрик хүмүүс үл итгэсэн учраас тамд үүрд үлдэх болно. Итгэл бишрэл байгаа нөхцөлд "нүгэл үйлдэх" нь тамд үүрд үлдэх шалтгаан биш юм. Тиймээс гэм нүгэл үйлдсэн боловч итгэл үнэмшилтэй хүмүүс нүглийнх нь хариуд хэсэгхэн хугацаанд тамын шийтгэл хүлээдэг ч итгэл бишрэлтэйгээр хойд ертөнцөд очсон тохиолдолд нэг л өдөр тамаас гарах нь гарцаагүй билээ.⁵⁰

Бид диваажинд орохын тулд ямар амьдралаар амьдрах ёстой вэ ?

Диваажин бол энэ ертөнцөд Аллаһыг хараагүй ч гэсэн Түүнд итгэсэн, итгэсэн шиг амьдрахын тулд чадах бүхнээ хийдэг Өөрийн албат нарт үхсэний дараа амласан, хариуцлага байхгүй мөнх бөгөөд төгс амьдралын нэр юм. Хэдийгээр хүний оюун ухаан ямар төгс диваажин байдгийг бүрэн ойлгож чадахгүй ч өөрийн ойлголтын дагуу зарим талаар төсөөлж чаддаг. Диваажингийн хамгийн том шагнал бол Аллаһтай уулзах хэдий ч энэ ертөнцөд хариуцлага хүлээсэн учраас хүссэн бүхнээ хийж

48 Худ, 11/106-108; Рагьд 13/35; Хижр, 15/48; Сад, 38/54; Духан, 44/56.

49 Гэсэн хэдий ч Куран судар дахь зарим эшлэл дэх мэдэгдэл болон зарим сахаба нарын үзэл бодолд үндэслэн там бол мөнх биш бөгөөд хүн бүр ялаа эдэлсний дараа алга болно гэж маргах хүмүүс ч байсан. Харна уу. Бекир Топалоглу, "Там", ДИА, 7-р боть, 232-р хуу.

50 Бекир Топалоглу, "Там", ДИА, 7-р боть, 231-р хуу.

чадаагүй хүн тэнд хүссэн бүхнээ, хүссэнээрээ хийж чадна гэсэн санаа, сэтгэл татам байсаар ирсэн.

Аллах диваажингийн эзэн болохын тулд өөрийн албат нараас юу хүсдэг нь үнэхээр тодорхой юм. Тэрээр хүнийг энэ дэлхий дээрх өөрийн байр суурь, үүрэг хариуцлагын талаар бодож, Аллах Эзнээ мэдэж, Түүний хязгааргүй хүч чадал, хүчийг таньж мэдэхийг хүссэн. Шалгалтад бэлдэхийн тулд хязгаарлагдмал хугацаанд бүх хүчин чармайлтаа гаргах шаардлагатай байдагтай адил энэ хязгаарлагдмал амьдралд албат эхлээд Аллахын илгээсэн тушаал, хоригийг зөв эх сурвалж болох Куран судар болон Гэгээн Элчийн Сүннэтээс олж мэдэх ёстой ба дараа нь тэдгээрийг хэрэгжүүлэхийн тулд хүчин чармайлт гаргана. Хэрэв тэр энэ хугацаанд алдаа гаргасан бол алдааныхаа төлөө уучлал эрж, дахин оролдоход хангалттай юм.

Диваажинд хүрэхийн тулд хүний хийх ёстой зүйлсийг бид дараах байдлаар жагсааж болно: Өөрийгөө албат гэдгээ ухамсарлаад Аллаhad бат итгэл бишрэлээр хандах, мөргөл залбирлаа биелүүлэхийн тулд хүчин чармайлт гаргах, өөрийг нь үргэлж Аллах харж байдаг гэдгийг мэдэх тэрээр өөрийн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээх, өөртөө болон гэр бүлдээ мөн бусдад шударга, ёс суртахуунтай хандах, энэ ертөнц бидэнд даатгасан гэдгийг бодолцон үүний дагуу үйл хөдлөл хийх, ашигтай ба сайн үйлсээр завгүй байх, хийсэн алдаа дутагдал ба үйлдсэн нүглээсээ Аллахаас өршөөл эрэх тэдгээрийг цайруулах хэрэгтэй. Эцэст нь хэлэхэд, энэ бүхнийг хийхдээ чөтгөр, бидний шунал

хүсэл, бидний эргэн тойронд байгаа сөрөг нөхцөл байдал, хүмүүс биднийг хорлон сүйтгэж, зөв үйлээс няцаахыг хичээж байгааг ухамсарлан, залбирлаар Аллагаас тусламж гуйх хэрэгтэй.

Бид диваажинд хайртай хүмүүсээ харах уу ?

Диваажинд орсон хүн гэр бүлийн бусад гишүүд эсвэл ойр дотны хүмүүс нь диваажинд орж, тэдэнтэй хамт сайхан амьдрахыг харах болно. Энэ асуудлыг Куран сударт дараах байдлаар илэрхийлсэн байдаг. *"Тэд Адн нэртэй диваажинд орцгооно, тэдний өвөг дээдсийн, хань ижлийн,, үр хүүхдүүдийн буянтнууд ч тэнд орцгоох болно."*⁵¹ Энэ нь диваажинд орох эрхтэй хүн гэр бүлийнхний бусад гишүүдтэй хамт байх болно гэсэн үг юм.

Гэхдээ түүний гэр бүлийн бусад гишүүд эсвэл найз нөхөд нь диваажинд очих хүмүүсийн дунд байхгүй бол яах вэ? Тэднийг харж чадах болов уу? Энэ асуултын хариултыг бид Куран судраас олдог. Диваажинд залрагсад бие биедээ элгэмсэг хандаж, хүүрнэлдэнэ. Тэдний нэг нь энэ хорвоод байх хугацаандаа ахирет ертөнцөд итгэдэггүй найзаа бодоод диваажин дахь нөхдөөсөө асуугаад: *Надад нэг найз байсан билээ. Тэр надад хандан: "Чи үнэхээр сүсэглэн итгэгсдийн юм уу?" Бид үхээд өмхий шороо, хувхай яс болсон хойноо ч дахин амилж тооцоо бодогдох гэж үү?"* Энэ асуултыг асуусан хүнд найз нь үгүйсгэлийнхээ улмаас тамд байгааг мэдээд, өнөөх буруу номтон найзаа тамын голоос олж хараад;

51 Рагьд, 13/23.

Тамд байгаа найздаа "Аллах өршөөх болтугай! Чи намайг ч хөнөөх шахсан байна шүү дээ" гэв. Хэрэв Эзэнтний маань хайр энэрэл үгүйсэн бол, би ч халуун тамд орогсдын нэг нь болох байж л дээ."⁵² Энэхүү айлдвараас ойлгож байгаагаар диваажинд очсон хүн диваажинд байхгүй найз нөхөдтэйгөө уулзах боломжтой болно.

Куран судар дээрх эдгээр эшлэлүүдийн илэрхийллээс бид диваажинд орсон хүн диваажинд орох эрхтэй бусад гэр бүлийн гишүүдтэйгээ хамт сайхан амьдрах болно гэдгийг ойлгож байна. Тэр ч бүү хэл тамд очсон танилуудынхаа байр байдлын талаар мэдэж байх болно.

Куран сударт диваажин ба тамын хүмүүсийг хэрхэн дүрсэлсэн байдаг вэ ?

Куран сударт Аллах итгэгчдийг авралд хүрсэн тухай сайн мэдээг өгч, тэдний шинж чанарыг дараах байдлаар дурдсан байдаг: Мүмин хүмүүс (итгэгчид) бол мөргөл залбиралдаа хушу (буюу гүн хүндэтгэл) -д байдаг хүмүүс, тэд хоосон яриа, үр ашиггүй зүйлсээс ангид байдаг хүмүүс, тэд уншлага мөргөлөө нямбай ёсчлон үйлдэцгээдэг. Эдгээр чанаруудыг эзэмшсэн сүсэгтэн олны хойд ертөнцөд орших газар Фирдаус хэмээх диваажинг өвлөн авч, тэндээ үүрд үлдэцгээнэ.⁵³ Аллах диваажинд орох итгэгчдийг зөвхөн Аллахад болон Түүний вахигаар дамжуулан илчилсэн зүйлд итгэдэг хүмүүс төдийгүй

52 Саффат, 37/50-60.

53 Мүминун, 23/1-11.

итгэл үнэмшилдээ тууштай амьдардаг итгэгчид буюу Мүмин гэж дурдсан нь үнэхээр анхаарал татаж байна.

Диваажингийн амьдралыг Куран сударт янз бүрээр дүрсэлсэн байдаг. Диваажинд орох эрхтэй хүмүүс бол ариун хишгээр дүүрэн диваажинд Аллаһад хамгийн ойр байдаг хүмүүс юм. Тэд эрдэнийн чулуугаар гоёсон сэнтий дээр сууна. Бие биеийнхээ өөдөөс харан тухлан сууна. Тэдэнд өтөлшгүй мөнх, нэг янздаа байх залуус үйлчилнэ. Тэд диваажингийн рашаанаас хүртэх аваас толгой өвтгөхгүй, согтоохгүй. Тэдэнд таалсан үр жимс болон хүссэн шувууны мах зэргийг зоог болгон өргөнө. Диваажинд хоосон худал үг сонсохгүй бас гэм нүгэл учруулах зүйл байхгүй. Аллаһ Диваажинд байгаа хүмүүст цэвэр ариун хань заяадаг.⁵⁴ Диваажинд байгаа хүмүүст үл дундрах буянаар шагнахын зэрэгцээ оюун санаанаас урган гарсан сэтгэл ханамжийн бэлэг ч өгдөг бөгөөд хамгийн том шагнал бол Аллаһыг харах юм.

Ариун Куран сударт үл итгэгчид болон хоёр нүүрт хүмүүсийн энэ ертөнцөд хийсэн үйлдлийн хариуд хойд насандаа тамд байх болно гэж заасан байдаг. Там дах амьдралыг Куран сударт дараах байдлаар илэрхийлсэн байдаг: Тамын оршин суугчид шатаж буй гал, буцалж буй усаар хүрээлэгдсэн бөгөөд сэрүүн ч биш, тааламжтай ч биш хар утааны сүүдэр дор байх билээ. Тамд тэд ангасан тэмээ мэт залгилан Заккумын модноос идэцгээнэ, буцлам халуун

54 Уакига, 56/10-38. Диваажингийн тухай Куран судар дах Рахман, Уакига, Инсан, Гашия гэсэн бүлгүүдийг уншиж болно.

усыг ууцгаана.⁵⁵ Аллах үл итгэгчдийг өршөөхгүй,⁵⁶ тэднийг Өөрөөсөө холдуулна.⁵⁷

Үл итгэгч ба хоёр нүүрт хүмүүсийн хувьд тамын амьдрал мөнхийн байдаг бол нүгэлт Мүмин хүний хувьд энэ нь түр зуурынх юм. Диваажин зөвхөн Мүминчүүдийн хувьд л бэлтгэгдсэн бөгөөд тэнд амьдрал мөнх байдаг. Үүнийг бид мэдрэхүйгээр мэдрэх боломжгүй тул диваажин, тамын амьдралыг хүмүүсийн хамгийн их хайрладаг, хамгийн их зовдог зүйлсээр дүрсэлсэн байдаг. Гэсэн хэдий ч ахирет ертөнц нь энэ амьдралтай адилгүй гэдгийг мартаж болохгүй.

Мусульман биш мөртөө буянтай амьдарч байгаа хүмүүс ? хойд насандаа ямар байх бол

Дэлхий бол хүмүүс бидний хувьд туршилтын газар юм. Бидний сорилтын сэдэв бол эхлээд итгэн бишрэх, дараа нь итгэл бишрэлийнхээ шаардлагыг биелүүлэх явдал юм. Бидний итгэл бишрэлийн шаардлага бол Аллах Эзний таалалд нийцсэн энэ ертөнцөд сайн сайхан, буянтай амьдрах явдал юм. Итгэл үнэмшилгүй мөртөө сайн сайхан, буянтай амьдарч байгаа хүн итгэл бишрэлийн анхны үүрэг хариуцлагаа биелүүлээгүй болно. Энэ тохиолдолд тэдний үйлдэл нь сайхан амьдралаар амьдрах эсвэл сайн хүн болох хүсэл эрмэлзлээс үүдэлтэй. Гэсэн хэдий ч Аллах биднээс Түүний тааллыг хүртэхийг

.....
⁵⁵ Уакига, 56/41-56.

⁵⁶ Ниса, 4/168.

⁵⁷ Мутаффифин, 83/15.

хүсдэг. Үл итгэгч хүнд энэ ухамсар дутмаг ба итгэл үнэмшилгүй учраас хойд насандаа диваажингийн шагнал хүртэж чадахгүй. Энэ асуудлыг эшлэлд дараах байдлаар илэрхийлсэн байна: "(Аяа, Мухаммед) Тэдэнд : “Та нарт хийсэн үйлдлийнхээ хэрээр хор хөнөөлд учруулагсдын тухай мэдүүлэх үү?” гэв. Тэдний амьд ахуйдаа хийсэн хөдөлмөрийн үр дүн талаар болсон ч тэд өөрсдийгөө сайн үйл бүтээгсэд хэмээн ойлгодог. Ийнхүү тэд Эзэнтнийхээ айлдварууд хийгээд Түүнтэй нүүр тулахаа үгүйсгэсэн учраас бүх үйл хэрэг нь талаар өнгөрсөн бөлгөө. Дахин амилахуйн өдөр Бид ямар ч үйл хэргийг өчүүхэн ч тоож үзэхгүй.”⁵⁸

Үүнтэй зэрэгцэн Аллах шударга юм. Буянтай амьдралтай мөртлөө сүсэг бишрэлгүй хүмүүс диваажинд орж чадахгүй ч гэсэн хойд насандаа хөнгөн тарчлалыг амсах болно гэж найдаж байна.⁵⁹

Аллахын оршихуйг хүлээн зөвшөөрдөг ч ахирет ертөнцийг хүлээн зөвшөөрдөггүй хүн ? шашнаас гарах уу

Ахирет ертөнцөд итгэх итгэл бол итгэл бишрэлийн зарчмуудын нэг юм. Ирээдүйн амьдрал бол мэдрэхүйгээс гадуур, үл үзэгдэх сэдэв учраас энэ талаарх бидний мэдлэг нь Куран судар болон жинхэнэ хадис дээр тулгуурладаг. Үндсэндээ хүн шударга ёс эрхэмлэдэг учраас дараагийн амьдралд итгэх шаардлагатай

58 Кахф, 18/103-105.

59 Бекир Топалоглу, Юсуф Шевки Явуз, Иляс Челеби, *Ислам дах итгэл үнэмшлийн үндэс*, 483-484-р хуу.

болгодог байна. Энэ хорвоод хүн бүр үйлдсэн гэмт хэргийнхээ төлөө бүрэн шийтгүүлдэггүй, зарим нэг шударга бус явдал гардаг. Ахирет ертөнцөд юу ч нууцлаг биш бөгөөд шударга ёс тогтох болно. Хүний хариуцлага хүлээх чадвар нь хойд насанд итгэхэд хялбар болгодог. Бидний Аллах Эзэн хүнийг сайн муу, зөв буруу, сайн мууг ялгаж салгаж, сонгодог нэгэн болгон бүтээж, энэ сонголтынхоо төлөө хариуцлага хүлээлгэсэн болно. Хүн тодорхой үйлээ хариуцна гэдэг энэ хариуцлагыг хүртэх амьдрал, амьдрах орон шаарддаг. Учир нь хүн төрөлхтөн хий хоосон, зорилгогүй бүтээгдээгүй билээ.

Куран сударт: *"Аяа, сүсэгтнүүд минь ээ! Аллахад, Түүний элч нарт, тэдэнд илгээсэн ариун сударт итгэцгээгтүн. Хэн Аллахад, Түүний мэлэкүүдэд, ариун судруудад, гэгээн элч нарт үл итгэж, ертөнцийн төгсгөлийн өдрийг үгүйсгэвэл үнэнхүү төөрөгдөлд орно."*⁶⁰ Хожуу ертөнцийн оршин тогтнохыг хүлээн зөвшөөрдөггүй хүн Куран судрын эшлэлүүдийг үгүйсгэсэн учраас шашнаас гардаг байна.⁶¹

Булшинд ямар нэгэн тарчлал байдаг уу? Булшин дахь амьдрал ямар байх вэ ?

Булшин дах амьдрал нь тухайн хүний үхэхээс эхэлж, киямет өдрийн дараа махшарт дахин амилснаар төгсдөг. Булшин дах амьдралыг

60 Ниса, 4/136.

61 Мустафа Синаноглу, "Итгэл бишрэл", ДИА, 22-р боть, 212-214-р хуу.

“барзах” гэж ч ашигладаг. Хүн яаж нас барсан болон нас барсан газраасаа шалтгаалж булшлагаагүй ч (жишээлбэл, шатаж үхсэн хүн) хүн бүр булш/барзагийн үеийг мэдэрдэг. Барзах бол хүний бие махбодын хувьд бус харин амин сүнс (хийморь) хувьд амьдрах үе юм.⁶² Гэгээн Элч (с.а. у.) -ын сургаснаар Барзах бол *“ахирет ертөнцөд очих хамгийн эхний үе шат”* юм.⁶³

Гэгээн Элч (с.а.у.)-ын хадисуудын дагуу тухайн хүнийг булшинд тавьсны дараа Мункар, Накир хэмээх байцаагч сахиусан тэнгэрүүд ирж, тэр хүнээс итгэл үнэмшлийн болон хийсэн үйлдлүүдийн талаар хэдэн асуулт асуудаг. Эдгээр асуултын хариултаас үзэхэд үл итгэгчид болон хоёр нүүрт хүмүүс булшинд тарчилж, итгэгчид диваажингийн ариун хишгийг амсаж эхэлнэ.

Холбогдох эшлэлүүдийн шинж тэмдэг болон хадисуудын илэрхийллийг авч үзвэл бид булшинд тарчлал байхгүй гэж хэлж чадахгүй. Фиргауын болон түүний дэмжигчид өглөө, оройгүй халуун гал дээр шарагдана. Ертөнцийн төгсгөлийн хамгийн хүнд гэсгээлийг амсах болно,⁶⁴ Хз. Нухын ард иргэд усан галавт живцгээсэн бөгөөд тамын галд шидэгдсэн⁶⁵ тухай эшлэлүүд булшны тарчлал хэрхэн болохыг харуулж байна. Эдгээрээс гадна сайн муу хүмүүст энэ хорвоогийн болон хойд насандаа хандах хандлага нь адилгүй байх тухай,⁶⁶

62 Жүнейт Гөкче, “Барзах”, ДИА, 5-р боть, 525-р хуу; Сүлейман Топрак, “Кабир”, ДИА, 24-р боть, 37-р хуу.

63 Ибн Ханбел, I, 64.

64 Мүмин 40/46.

65 Нух, 71/25.

66 Жасия, 45/21-22.

хоёр нүүртэнгүүдийг хоёр удаа (энэ яваа насанд хийгээд хойд ертөнцөд) гэсгээн цээрлүүлсний дараа тамын их гэсгээл рүү түлхэгдэх болсны тухай,⁶⁷ үл итгэгч ба хоёр нүүртнийг хойд насанд хамгийн том гэсгээлийн өмнө энэ хорвоогийн гэсгээлийг ч амсуулах⁶⁸ тухай өгүүлсэн эшлэлүүд булшин дахь тарчлалын нотолгоо гэж хүлээн зөвшөөрөгддөг байна.

Хадисуудад өгүүлснээр Гэгээн Элч (с.а.у) булшинд тарчилж байгаа зарим хүмүүсийн дуу хоолойг сонсож,⁶⁹ булшны гэсгээлээс Аллахаас аврал эрэлхийлж, хамтрагчдаа Аллаhad хорогдохыг захисан⁷⁰ бөгөөд тэрээр жаназа мөргөл үйлдэн нас барсан хүний булшин дах тарчлалаас аврагдахын тулд Аллаhad залбирч,⁷¹ мөн түүнчлэн амьтад тарчлан зовсон хүмүүсийн дууг сонсдог⁷² гэж мэдээлсэн.

Хүн муулах, хов жив ярих,⁷³ өртэй үхэх,⁷⁴ худал хэлэх, завхайрах, хүү идэх, архи уух⁷⁵ зэрэг үйлдлүүд булшинд гэсгээлт хүртэх шалтгаануудын нэг болохыг хадисуудад өгүүлсэн байдаг.

Үл итгэгчид болон олон нүгэл үйлдсэн Мүмин хүний хувьд булшны тарчлал шүүлтгийн өдөр хүртэл

.....
67 Тауба, 9/101.

68 Саждэ, 32/21; Тур, 52/47.

69 Мүслим, Жаннат, 67-69.

70 Мүслим, Жаннат, 67.

71 Мүслим, Жанаиз, 86.

72 Нэсаи, Жанаиз, 115.

73 Бухари, Вуду, 56, Жанаиз, 81, 88.

74 Ибн Мажэ, Садакат, 12.

75 Бухари, Жанаиз, 93, Табирүр-рүяа, 48.

үргэлжлэх бөгөөд нүгэл багатай Мүминий хувьд түр зуурынх болох нь батлагдсан болно.

Дээр иш татсан эшлэл болон хадис дээр үндэслэн энэ яваа насан дээр бидний хийсэн зүйлийн хариуд булшинд (эерэг эсвэл сөрөг) үйлдэл хийх боломжгүй гэж хэлж болохгүй. Гэхдээ энэ үйлдэл хэрхэн явагдах, ямар нөхцөл байдал үүсэх талаар нарийн мэдээлэл бидэнд алга.

Нас барсан хүн өөрийнх нь булшинд очсон ? хүмүүсийг мэдэрч чадах уу

Үхлээр хүний ертөнцийн амьдрал дуусаж, хүний биеийн үйл ажиллагаа дуусдаг. Газарт булагдсан хүний бие тодорхой хугацааны дараа түүнтэй холилдон хөрс болдог. Хүн нас барсны дараа булшинд амьдрах үйл явцыг барзах гэж нэрлэдэг. Барзах бол хүн бие махбодын хувьд биш харин сүнслэг байдлаар амьдрах үе юм. Ийм учраас булшинд энэ амьдралаас ялгаатай нь гаднын өдөөлтийг мэдэрч, хариу үйлдэл үзүүлэх боломжгүй байдаг. Харин Гэгээн Элч булшинд очиж, тэнд байгаа хүмүүстэй мэндчилж,⁷⁶ залбирч булшин дээр нь далдуу модны ногоон мөчир тавьж, булшинд буй хүний тарчлал намдана⁷⁷ хэмээн талийгаач болон талийгаачийн дотны хүмүүсийн хоорондын харилцаа холбоо, харилцан үйлчлэлийн шинж тэмдэг гэж үзэж болно.

76 “Сайн байна уу, энэ нутгийн үнэнч, Мусульманчууд аа! Бид та нартай нэгдэх болно. Аллах бидэнд болон та нарт сайн сайхныг хүсэн ерөөг.” (Мүслим, Жанаиз, 104)

77 Бухари, Вуду, 55.

Үүний үр дүнд бид Гэгээн Элчийн үхэл ба хойд насыг сануулахын⁷⁸ тулд бидэнд талийгаачийн булшинд очиж байх тухай зөвлөгөө сургамжийг үнэлж үүнийг амьдралдаа хэрэгжүүлэх хэрэгтэй.

Нас барсан хүмүүс амьд хүмүүст ? ямар нэгэн нөлөө үзүүлдэг үү

Ухлийн дараах амьдрал нь бидний мэдрэхүйн эрхтнүүдээр хүлээн зөвшөөрөгдөхгүй хэсэг учраас бид энэ талаар иш татах эх сурвалжууд нь Куран судар, Сунна юм. Үхсэн хүмүүс амьдыг сонсож чаддаггүйг Аллах дараах эшлэлүүдэд тодорхой илэрхийлсэн байдаг: *“Амьд ба үхсэн хоёр адил биш. Аллах үнэндээ чин үнэнийг таалсан хүндээ сонсгомуй. Харин чи бол булшинд байгсдад (буруу номтнуудад) албадан сонсгож эс чадмуй.”*⁷⁹ *“Чи үхэгсдэд сонсгож чадахгүй мөн нуруугаа эргэж явахад нь дүлий хүмүүст дуудлагыг сонсгож чадахгүй гэдгийг мэд.”*⁸⁰ Хэдийгээр эдгээр эшлэлд үхэгсэд гэдэг нь “үл итгэгчид” гэсэн утгатаар илэрхийлсэн хэдий ч тэднийг тэнгэрлэг дуудлагыг сонсоогүй гэсэн үндэслэлээр үхэгсэдтэй адилтгадаг. Энэ нь үхэгсэд амьдыг сонсох боломжгүй гэсэн үг бөгөөд бурханлаг зарлигийг сонсохдоо үл итгэгчид үхсэн хүмүүстэй адил юм.

Аллах Куран сударт: *“Аллахын төлөө алуулсан хүмүүсийг “үхэгсэд” гэж бүү хэлэгтүн. Тэд амьд. Гэвч та нар үүнийг мэдэрдэггүй юм.”*⁸¹ *“Аллахын төлөө амь эрсдэгсдийг үхсэн гэж бүү бодоцгоогтун! Аллахын төлөө*

78 Тирмизи, Жанаиз, 60; Еб Давуд, Жанаиз, 75, 77.

79 Фатыр, 35/22.

80 Намл, 27/80. Мөн үзнэ үү. Рум, 30/52.

81 Бакара, 2/154.

амь эрсдэгсдийг үхсэн гэж бүү бодоцгоогтун! Мэдээж, тэд амьд. Тэд Аллахын дэргэд хувь хишиг хүртэцгээнэ. Тэд Аллахын хайрласан энэрэл хайрд баярлаж, ардаа үйлдэгсдэд: “Өөрт нь ямар ч аюул занал, уй гашуу үгүй” гэдгийг баяртайгаар дуулгахыг хүсдэг.”⁸² Гэсэн хэдий ч, шэхид (эх орныхоо төлөө амиа алдагсад) хүмүүс бидний ойлгомжгүй байдлаар амьдралаа үргэлжлүүлж байгаа нь дэлхий дээрх хүмүүсийн амьдралд нөлөөлж чадна гэдгийг харуулахгүй болно.

Үхлийн дараах амьдралын тухай Куран ба Сунна дахь бидэнд өгсөн мэдээлэл хязгаарлагдмал байдаг. Үхсэн хүмүүсийн бие нь ялзарч байхад сүнс нь барзах ертөнцөд бидэнд үл мэдэгдэх амьдралаар амьдардаг. Гэсэн хэдий ч барзах ертөнц, бидний амьдарч буй ертөнц бие биеэсээ тэс өөр. Тэгвэл үхсэн хүмүүс амьд хүмүүст ямар нөлөө үзүүлж чадах билээ?

Булшинд очихдоо хүмүүс бунхан дахь салих хүмүүсээс гэр орон, машин тэрэг, аз хийморь, амжилт бүтээл эсвэл зовлон зүдүүрээс ангижрахад туслах гэх мэтийг гуйдаг энэ нь ширк юм. Учир нь залбирах нь мөргөлийн нэг хэлбэр бөгөөд мөргөл нь зөвхөн Аллахад хийгддэг. Түүнээс гадна хүнд хэрэгтэй зүйлийг өгөх нь зөвхөн Аллахын гарт байдаг. Нас барсан хүмүүс, хүмүүсийн зовлон зүдүүрийг арилгаж, хэрэгцээг нь хангаж чадахгүй.

82 Али Имран, 3/169-170.

Исламын шашинд хойд насандаа? эргэн төрөх итгэх итгэл байдаг уу?

Тэнасүх (шилжих) ба хойд төрөл нь бие биеэсээ үндсэндээ ялгаатай. Гэхдээ талийгаачийн сүнс өөр биед дахин төрнө гэсэн итгэл энэ хоёр үзэлд байдгаараа адилхан. Тэнасүх буюу шилжих, хувирах гэсэн итгэл үнэмшлийн дагуу сүнс нь амьтан эсвэл ургамлын биед ч дахин ирэх боломжтой. Хойд төрөл гэх бодлын хувьд сүнсэнд ухралт байдаггүй. Үхэж буй хүний сүнс янз бүрийн хүний биед ахин төрдөг. Гэсэн хэдий ч, хоёр итгэл үнэмшлийн дагуу сүнс нь төгс төгөлдөрт хүрэхийн тулд (сүнслэг хувьслыг хангахын тулд) ертөнцөд буцаж ирдэг. Сүнс нь төгс төгөлдөрт хүрсний дараа дахиж төрөхгүй. Мэдээжийн хэрэг, шинээр ирэх болгонд сүнс өмнөх амьдралдаа хийсэн алдааныхаа төлөө бага зэрэг шаналж, тэр алдааныхаа төлөөсийг төлдөг.⁸³

Эдгээр итгэл үнэмшлийн гарал үүсэл нь эртний Египетийн соёл иргэншлийн үеэс эхэлдэг. Хинду, Буддизм зэрэг дорно дахины шашинд ч мөн адил энэхүү итгэл үнэмшил бий. Одоо ч гэсэн төрөл бүрийн шашны хүмүүс хойд төрөлд итгэдэг байна.⁸⁴

Хүний энэ ертөнц дэх амьдрал бол зөвхөн сорилт,⁸⁵ энэ ертөнцийн амьдралын үр дүнд хүн бүр үхэх

83 Кенан Хас, “Шашны түүхийн үүднээс маргаантай үзэл баримтлал: Хойд төрөл”, *Ислам судлал*, 2004, боть: XVII, тоо: 4, 390-400-р хуу.

84 Олон улсын судалгааны Галлуп компанийн хийсэн судалгаагаар Баруун Европын орнуудын хүмүүсийн 18% нь хойд төрөлд итгэдэг байна. А.г.м-ээс иш татав, Иан Стевенсон, Хойд төрөл: Сэдэвийн судалгаа, онолын асуудал. Бүх нийтийн хууль: Дахин төрөлт. Ергүн Арикдал, Истанбул, 1997, 55-р хуу.

85 Мүлк, 67/2.

болохыг,⁸⁶ үхсэний дараа хорвоод эргэн ирж, сайн хүн болохыг хүссэн ч гэсэн зөвшөөрөгддөггүйг Куран сударт өгүүлсэн байдаг. Энэ асуудлыг эшлэлд дараах байдлаар тайлбарлав. "Эцэст нь үл сүсэглэгсдийн хэн нэгэнд үхэл тохиолдвол: "Эзэнтэн минь! Намайг энэ хорвоод илгээгтүн" хэмээгээд залбирна. Тэр: "Магад би дэмий өнгөрүүлсэн энэ хорвоод сайн үйл үйлдэх сэн" гэнэ. Үгүй ээ! Энэ бол түүний хэлсэн хоосон үг. Тэднийг дахин амилахуйн өдөр хүртэл энэ хорвоод буцаахад саад болох нэгэн хаалт бий."⁸⁷

Чухамдаа үүнтэй төстэй эшлэлд харамсаж буйгаа илэрхийлж, ертөнцийн амьдрал руу буцахыг хүссэн үл итгэгч хүнд ийнхүү хариулсан: "Аллах: "Бид та нарт ухуулга сургамж авахыг хүссэн хүний амьдралтай тэнцэх хугацаа болон ухуулга сургамж авч чадахуйц хорвоог өгөөгүй сэн билүү? Та нарт сэрэмжлүүлэхээр гэгээн элчийг илгээсэн биш билүү?"⁸⁸

Ахирет ертөнц болж дэлхийн амьдрал бүрэн дууссаны дараа үхсэн хүн бүр хойд насыг эхлүүлэхийн тулд дахин амилах болно. "Ертөнцийн төгсгөл ирэх нь бас эргэлзээгүй. Аллах бушинд байгаа бүхнийг амилуулан гаргамуй."⁸⁹ Үүний дараа үйлийн дэвтэр илчлэгдэж, үйлсийг дэнсэлсний дараа сайн нь диваажинд, муу нь тамд мөнхөд оршино. Исламын авчирсан хойд ертөнцийн тухай ойлголтыг ийм байдлаар нэгтгэн дүгнэж болно. Мөн энэ тайлбарыг Куран судрын олон эшлэлд дүрсэлсэн байдаг.⁹⁰

86 Анкабут, 29/57.

87 Мүминун, 23/99-100.

88 Фатыр, 35/37.

89 Хаж, 22/7.

90 Бекир Топалоглу, "Ахирет ертөнц", ДИА, 1-р боть, 543-547-р

Куран сударт Аллах (үхлийн дараа эсвэл шүүлтийн өдөр) дахин төрж сайн хүн болохыг хүсдэг хүмүүст зөвшөөрөл үгүй болохыг тодорхой заасан байдаг,⁹¹ Шүүлтийн өдрийн дараа хойд амьдрал эхэлнэ, диваажин ба тамын амьдрал тэр цагт л эхэлнэ гэсэн Исламын мэдэгдэл нь хойд төрөлтийн тухай ойлголттой зөрчилдөж байна. Хэрэв хойд төрөл болох боломжтой бол тэр хүн хойд насандаа аль биеийн үйлсийн төлөө хариуцлага хүлээх вэ?⁹² Хойд төрөлтийн үзэл бодол нь диваажин ба тамыг энэ ертөнцөд гэж тодорхойлдог. Гэсэн хэдий ч, Куран сударт диваажин эсвэл тамын амьдрал ахирет ертөнцөд байдаг гэдгийг тодорхой дурдсан байдаг.⁹³

Товчхондоо, хойд төрөлд итгэх итгэл нь хойд нас, диваажин там, тэнцвэр зэрэг итгэл үнэмшлийн үндсэн зарчимтай зөрчилддөг тул Исламын шашинд хойд төрлийн тухай ойлголт байж болохгүй гэдгийг ойлгох болно.

Онгод дуудах гэж байдаг юм уу ?

Спиритизм гэдэг нь нас барагсдын сүнс амьдардаг бөгөөд тэдэнтэй ярилцах боломжтой гэсэн итгэл үнэмшил юм.⁹⁴ Энэ итгэл үнэмшлийн дагуу нас барагсдын сүнстэй харилцах замаар зарим мэдээллийг олж авдаг. Ирээдүйн талаарх мэдээг

хуу.

91 Мүминун, 23/99-100; Ибрахим, 14/44; Мүнафикун, 63/10-11 гэх мэт.

92 "Ямар ч нүгэлтэн бусдын нүглийг үүрэхгүй." Фатыр, 35/18.

93 Кенан Хас, "Шашны түүхийн үүднээс маргаантай үзэл баримтлал: Хойд төрөл", 390-400-р хуу.

94 Орхан Ханчерлиоглу, "Испиритизма", *Дэлхийн итгэл үнэмшлийн толь бичиг*, Истанбул, 2010, 224-р хуу.

хүлээн авах хүсэл эсвэл үл мэдэгдэх, түүнтэй холбоотой чиг хандлага бараг бүх соёлд байдаг. Гэсэн хэдий ч Куран судар болон хадисуудад хүмүүс сүнстэй харьцдаг тухай мэдээлэл байдаггүй билээ. Ийм учраас янз бүрийн аргаар сүнс дуудах нь шашны үндэслэлгүй юм.

Нөгөөтээгүүр, хүмүүсийн дунд алдартай болсон сүнсийг дуудах аргууд логик талаас нь харахад эдгээр дадал зуршил нь дотоод уялдаа холбоогүй байгаа нь илт харагдаж байна. Сүнс дуудах үед ерөнхийдөө үйл явдлыг зохион байгуулдаг мэргэ төлөгч/зөөгч, ширээ, ширээн дээрх зарим эд зүйлс байдаг. Одоо эдгээр арга барилуудыг цөөн асуултаар товч дүгнэхийг хичээцгээе.

Хэрэв сүнс хүмүүсээс/биднээс дээд оршихуй хийгээд хүний мэдэхгүй зүйлсийг мэддэг бол яагаад тэднээс доогуур хүмүүстэй харьцаж, тэдэнд мэдээлэл дамжуулахыг хүсдэг вэ? Бидэнд мэдэгдэхийг хүсэж байгааг бид хүлээн зөвшөөрсөн ч яагаад зөвхөн биднийг дуудахад ирэхийг зөвшөөрч байна вэ? Хамгийн гол нь тэд ирэхэд инээдтэй, ид шидийн ёслол яагаад хэрэгтэй байна вэ? Мэдээллийг ирэхэд нь шууд дамжуулахын оронд яагаад бидэнтэй хүн болон объектоор харилцдаг вэ? Яагаад эдгээр ёслолд зөвхөн нэг хүнээр (зөнч, үзээч) харилцаа холбоо хязгаарлагддаг ч, бусад хүмүүс энэ харилцааны шууд ярилцагч болж чадахгүй байна вэ?


Мэдээжийн хэрэг эдгээр асуултуудыг нэмэгдүүлэх боломжтой. Гэсэн хэдий ч сэдвийг нэгтгэн дүгнэхэд дараах өгүүлбэрүүд хангалттай байх болно. Онгод дуудаж байна гэсэн мэдэгдэл нь худал, зохиомол

ЗАЛУУЧУУДЫН ИТГЭЛ СҮСЭГ БИШРЭЛИЙН АСУУЛТУУД

зүйл бөгөөд ихэнх зохиомол зүйлүүд нь үнэн зөвөөс хол байдаг. Түүнчлэн онгодыг өдөөх үед хэрэглэдэг ид шид, мэргэ төлөг, зөгнөл зэрэг бүх үйлдлүүд манай шашинд хориотой бөгөөд мухар сүсэгт тооцогддог юм.⁹⁵

.....
95 Темел Ешилюурт, *Орчин үеийн итгэл бишрэлийн асуудлууд*, 115-120-р хуу.

**КАДЭР БА КАЗАД
ИТГЭХ
ИТГЭЛ**



Кадэр ба казад итгэх нь юу гэсэн үг вэ ?

"Кадэр" болон "Каза" гэсэн үгс нь Аллах Өөрийн бүтээлүүд болон байгалийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө хэрэгжүүлдэг гэсэн утгаар хэрэглэгддэг.¹ "Кадэр хувь тавилан" гэдэг нь Аллах энэ ертөнц ба ирээдүйд болох үйл явдлуудын цаг хугацаа, орон зайг мөн бий болгон Өөрийн хязгааргүй мэдлэгээрээ урьдчилан мэдэж болгоохыг хэлнэ. "Каза буюу хувь тавилангийн биелэлт" гэдэг нь албат сонголтоо хийх тэр мөчид Алладын зөвшөөрлөөр биеллээ олохыг хэлдэг.

Кадэр ба казад итгэх нь Алладын мэдлэг, хүсэл зориг, хүч чадал, бүтээлийн шинж чанаруудад итгэхийг шаарддаг. Өөрөөр хэлбэл, албат кадэр ба казад итгэснээрээ Аллах бүхнийг мэддэг, зөвхөн Түүний мэдлэг, хүслээр бүх зүйл тохиолдох боломжтой, Түүний хүч бүх зүйлд хангалттай, Өөрийн хүссэн бүхнээ бүтээхдээ цорын ганц гэдэгт итгэдэг байна. Өөрөөр хэлбэл кадэр ба казад итгэх нь хүний хязгаарлагдмал оюун ухаан ойлгож чадах эсэхээс үл хамааран өнөөг хүртэл тохиолдсон болон ирээдүйд тохиолдох бүх зүйл Алладын мэдлэгт байдаг бөгөөд зөвхөн Түүний хүсэл, хязгааргүй хүчээр л тохиолдохыг хэлнэ.

1 Сэдвийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараахаас үзнэ үү. Юсуф Шевки Явуз, "Кадэр буюу хувь тавилан", ДИА, 24-р боть, 58-63-р хуу.

Кадэр ба казад итгэх нь итгэл ? үнэмшлийн нэг үндэс мөн үү

Кадэр, казад итгэх нь сүсэгтэн хүний заавал итгэх ёстой үндсэн зарчмуудын нэг бөгөөд үүнийг "Аменту" гэж нэрлэдэг. "Аменту" гэдэг нь араб үг бөгөөд "Би итгэдэг, би тунхаглаж байна" гэсэн утгатай бөгөөд итгэл үнэмшлийн үндсэн гол түлхүүр болох зүрх сэтгэлээс гарах илэрхийлэл юм. Вахийн сахиусан тэнгэр болох Жабрайл түүнээс "Итгэл бишрэл гэж юу вэ?" гэж асуухад манай Гэгээн Элч (с.а.у.) *"Итгэл бишрэл бол Аллахад итгэх явдал юм, сахиусан тэнгэрүүдэд, судар номуудад, Түүний элч нарт, хойд нас, сайн ба муугаар ирэх хувь тавиланд итгэх юм"*² Тэрээр итгэл бишрэлийн зарчмуудын дунд хувь тавиланд итгэх итгэлийг дурдсан байна.

Нэг утгаараа хувь тавилан гэдэг бол бидний Аллах Эзний хязгааргүй хүч, чадал мэдлэгээрээ орчлон ертөнц дээр тавьсан тушаал, хэмжүүр нь юм. Оршихуйн ертөнц тодорхой зохицолтой үргэлжилдэг нь "сансар огторгуй", өөрөөр хэлбэл орчлонгийн төгс зохицлын тухай онолын талаар эрдэмтдийн хийсэн судалгаанаас ч тодорхой харагдаж байна. Орчлон ертөнцийн энэхүү дэг журам нь бүх зүйл харилцан уялдаатай байдаг төгс тогтолцоог тайлбарладаг юм. Бидний Аллах Эзэн бүхий зүйлийн эзэн учраас ертөнцийн өөрийн тэнхлэг, нарыг тойрон хөдөлгөөнийг мэддэг, мөн тэрээр ертөнцийн төгсгөлийг төлөвлөсөн учраас үүнийг ч бас мэддэг. *"Нар бол тодорхой өөрийн хязгаарын хүрээнд хөвнө. Энэ нь яруу алдарт, эрдмийн*

2 Мүслим, Иман, 1; Ебу Давуд, Сүннет, 16.

эзэн Аллахын товлосон хувь заяа мөн."³ Тэр атомын хүч, энергийг мэддэг шигээ хүний чадвар, үйлдэл, хөдөлгөөнийг ч мэддэг, учир нь Тэр бол хүнийг бүтээгч юм. Аллах бол өнгөрсөн болон ирээдүйн бүх зүйлийг өчүүхэн жижиг зүйл хүртэл мэддэг цор ганц юм. *"Аллах ил, далд бүхнийг мэдмүй. Тэрбээр, аугаа бөгөөд онцгой эрхэмсэг бөлгөө."*⁴ *"Тэр газар руу юу орж, газраас юу гарч буйг, бас тэнгэрээс юу бууж, тэнгэр өөд юу хөөрч буй бүхнийг мэднэ. Тэр машид энэрэгч хийгээд нэн өршөөгч бөлгөө."*⁵

Куран сударт бүх зүйл бидний Аллах Эзний хүсэл, үзэмжээс шалтгаална гэж бичсэн эшлэлүүдээс гадна Аллахын мэдлэг нь болсон, болох бүх оршил, үйл явдлыг хамардаг гэсэн эшлэлүүдэд хувь тавилан ба хувь тавилангийн биелэлтэд итгэх шаардлагатай шинж тэмдгүүд байдаг.⁶

Аллах бол бүхнийг бүтээгч бөгөөд орчлон ертөнцийн бүх зүйл Түүний хүсэл, мэдлэгээр бий болсон тухай эшлэлүүд нь хувь тавилан, хувь заяаг шийдэх эрх мэдэл нь цорын ганц бүтээгч Аллах бөгөөд орчлон ертөнцийн бүх зүйл зөвхөн тодорхой болсон хувь заяанаас хамааралтай болохыг харуулж байна.⁷

3 Ясин, 36/38.

4 Рагид, 13/9.

5 Саба, 34/2. Үүнтэй төстэй эшлэлийг үзнэ үү. Хадид, 57/4.

6 Фуркан, 25/2; Рагид, 13/8.

7 Тауба, 9/51; Зүмер, 39/62; Саффат, 37/96; Аграф, 7/178; Уакига, 56/60.

Хэрэв бидний хувь заяа урьдаас тодорхойлогдсон бол бид яагаад үйлдлийнхээ төлөө ? хариуцлага хүлээдэг вэ

Хүний амьдралд өөрийн оролцох боломжгүй нөхцөл байдал байдаг. Хүн өөрийн өнгө, хүйс, эх хэл, гэр бүл, яс үндсийг шийдэж чадахгүй. Тэр эдгээрийг өөрийн сонголт, хүслээр тодорхойлох боломжгүй. Эдгээр нь бидний Аллах Эзний хувь тавилан гэж тогтоосон зүйл бөгөөд түүний хувьд хамгийн сайн нь юм. Өөр өнцгөөс харвал, хувь тавилан гэдэг нь хүний оршин тогтнох мөчөөс үхэх хүртэлх амьдралын адал явдал юм. Хүн ойрын хоромд юу тохиолдохыг мэддэггүй ч бүх амьдралаа эхнээс нь дуустал мэдэх боломжгүй нь мэдээж. Бидний Аллах Эзэн бол өнгөрсөн болон ирээдүйн бүх зүйлийг өчүүхэн төдий хүртэл мэддэг цорын ганц оршихуй юм. Хүнд юу тохиолдохыг мөн хүнд тохиолдсон үйл явдалд хэрхэн хандахыг Аллах л мэднэ гэхлээр эдгээр бүх зүйл Аллахын мэдлэгт байдаг нь хүний үүрэг хариуцлагыг байхгүй болгодог уу?

Энд хамгийн чухал асуудал бол хүмүүс өөрсдийн хүсэл зоригоор сонголтоо хийдэг үү, үгүй юу гэдэг асуудал. Мэдээжийн хэрэг, хүн амьдралынхаа туршид тулгарах нөхцөл байдалд ямар шийдвэр гаргахаа урьдчилан мэдэж чадахгүй. Гэхдээ тэр цаг нь ирэхээр одоо ч, ирээдүйд ч тэр цаг мөчид гарах шийдвэрээ сайн, муугийн хооронд үнэлэлт дүгнэлт хийж, өөрийн хүслээр гаргаж, хэрэгжүүлж чадвал Эдгээр шийдвэрүүд - хэрэгжүүлж ч чадна - энд хариуцлага орж ирдэг. Хариуцлагатай байна гэдэг нь хүн төрөлхтөн өгөгдсөн хүсэл зориг,

өөрөөр хэлбэл сонгох эрхээ эдэлж, өөрийн итгэл үнэмшил, үйл хэргийг эзэмшиж, түүний талаар асууж шалгадаг гэсэн үг юм.

Аллах Эзний мэдлэг, хүч чадлын байдал, албат өөрийн хүсэл сонирхол, хүсэл эрмэлзэл аль чиглэлд ашиглахыг Тэр урьдчилан мэддэг нь албатын шийдвэр гаргах үүрэг биш юм. Бид энэ асуудлыг жишээгээр тайлбарлаж болно. Тухайлбал, их сургуулиа төгссөний дараа хаана ажиллахаа зөв шийдэх ёстой хүн боломжит боломжоо дүгнэхдээ байнга шийдэмгий байж, гаргасан шийдвэрээ амьдралд хэрэгжүүлэхээсээ өмнө дахин шийдвэр гаргах, зөвлөлдөх нь зүйн хэрэг бөгөөд түүний найз нөхөд, гэр бүлийнхний санаа бодол, энэ мэргэжлийг эзэмшдэг хүмүүсийн үзэл бодол нөлөөлнө. Энэхүү эрчимтэй шийдвэр гаргах үйл явцын үр дүнд тухайн хүн эдгээр сонголтуудын дунд өөрийн хүсэл зоригийг ашиглан сонголт хийдэг. Хэдийгээр түүний сонголтод гаднын нөлөөлөл байсан ч эцсийн шийдвэрийг өөрөө гаргасан. Түүний гаргасан шийдвэр, түүний сонголтын хариуцлагыг одоо өөрөө хариуцна. Түүнд учирч болзошгүй сөрөг зүйл тохиолдоход “Таны нөлөөнд автсан учраас би ийм шийдвэр гаргасан, надад тохиолдсон үйл явдлыг та өөрөө хариуцна” гэж өөр бусдыг буруутгаж хариуцлага тооцож чадахгүй.

Өмнө нь болж байсан, одоо болж байгаа, ирээдүйд ч тохиолдох бүхнийг хязгааргүй мэдлэгээрээ мэддэг, хязгааргүй их хүчээрээ бүхнийг чадагч Аллах, өөрийн онцгой мэдлэгээрээ ингэж энэ хүн ингэж шийднэ гэдгийг мэддэг юм. Цаг хугацааг

бүтээгч Аллах бидний адил өмнө ба дараа гэсэн хязгаарлалт байхгүй тул Тэр энэ хүний шийдвэрийг мэдэж, урьдчилан тэмдэглэх ёстой бөгөөд Аллах цаг хугацаа, орон зайгаар хязгаарлагдахгүй, Тэр бүхнийг мэддэг, бүх хүч чадалтай учир. Тухайн хүн шийдвэр гаргахдаа өөрийн хүсэл зоригийг ашигласан; Аллах хязгааргүй мэдлэгээрээ тухайн хүний яаж шийдвэр гаргахыг нь мэддэг учраас хувь заяаг нь ингэж тэмдэглэсэн байдаг.

**Аллах хүссэн хүнээ зөв зам руу
хөтөлж, хүссэн хүнээ
төөрөлдүүлэхийн утга учир юу вэ?
Энэ байдал нь хүсэл зориг, сорилтын ?
асуудалтай хэр нийцэж байна вэ**

"Хидаят" гэдэг үг нь толь бичигт "зам зааж, үнэн рүү хөтлөх, үнэн рүү хүргэх" гэсэн утгатай. Харин шашны хэллэгийн хувьд "Аллах хүмүүст зөв замыг зааж, Гэгээн элч, ном илгээснээр тэднийг энэ замд чиглүүлдэг" гэсэн утгатай.⁸ Аллахын хүссэн хүнээ зөв зам руу хөтлөхийн өөр нэг төрөл бол Аллах хүмүүсийг үүнийг хүлээн авах чадвартай мөн чанараар бүтээж, тэдэнд удирдамж (эш үзүүлэгч ба илчлэл) ирэх үед хүлээн авч, ойлгох ухаанаар тэднийг хангадаг явдал юм.⁹ Эдгээр удирдамжийн хэлбэр нь бүх хүмүүст хамаардаг байна. Хидаят хүн бүрийн хаалгыг тогшдог. Гэсэн хэдий ч зарим хүмүүс түүнд хаалгыг нээж өгдөг, зарим нь нээдэггүй

8 Жихат Тунч, "Ислам Шашны хувьд зөв зам ба төөрөгдөл", *Эржиес их сургуулийн теологийн факультетийн сэтгүүл*, Кайсери, 1989, тоо: 6, 26-р хуу.

9 Режеп Ардоган, *Системчилсэн теологи ба одоогийн итгэл үнэмшлийн асуудлууд*, 144-р хуу.

байна. "Хэн зөв замд орно, түүний ашиг тус өөрт нь оногдоно. Хэн төөрөлдөнө, түүний уршиг өөрт нь ирнэ."¹⁰

Толь бичигт далалет гэдэг нь "замаас төөрөх, зөв замаас гарах, төөрөлдөх" гэсэн утгатай. Шашны нэр томъёоны хувьд далалет гэдэг нь хидаят гэх үгний эсрэг хэрэглэгддэг юм. Зөв замаас мэдсээр байж эсвэл мэдээгүй их, бага хэмжээгээр хазайх гэсэн утгатай.¹¹

Зөв зам руу хөтлөх дуудлага бол бүх хүмүүст зориулсан дуудлага юм. Аллах энэ дуудлагад эергээр хариулсан хүмүүст зөв замд хүрэх боломжийг олгоно. Тэр тэдний хүслийн дагуу тэднийг зөв зам руу оруулна. Аллах албатыг удирдан чиглүүлэх, өөрөөр хэлбэл албат нь хүсэхгүй аваас түүнийг зөв зам руу оруулах нь бий болгох боломжгүй юм.¹²

Аллах Өөрийн албатуудаа итгэгч эсвэл үл итгэгч байдлаар бүтээдэггүй. Итгэл, үл итгэх хоёрын аль нэгийг нь тухайн хүн өөрөө сонгодог. Итгэл бишрэл, өөрөөр хэлбэл зөв зам руу орох нь боолын хүслийн үр дүнд бий болдог. Тэгэхгүй бол хүн өөрийн хариуцлага хүлээх нь утгагүй болно.¹³

Хүн ямар ч эрин үед, ямар ч улс оронд амьдарч

10 Юнус, 10/108.

11 Мехмет Булут, "Зөв зам болон төөрөгдөл ба хүний үүрэг хариуцлага", ДЕТУ Теологийн факультет сэтгүүл, Измир, 1995, тоо: IX, 231-р хуу.

12 Мехмет Булут, "Зөв зам, төөрөгдөл ба хүний үүрэг хариуцлага", 238-р хуу.

13 Мехмет Булут, "Зөв зам, төөрөгдөл ба хүний үүрэг хариуцлага", 238-р хуу.

байсан, ямар үндэс угсаа, итгэл үнэмшил, үзэл бодолтой байх нь хамаагүй, тэр бол Аллахын бүтээсэн боол учраас Аллахаас, бидний мэдэх мэдэхгүй, мэдэх боломжгүй, мэдэж чадахааргүй олон янзын боломжоор соригддог. Зөв үнэнийг, зөв замыг олохын тулд соригддог. Түүнд Гэгээн элч нар, судар номууд, номын мэдлэгтэй хүмүүсээр дамжуулан зөв зам руу хөтлөх арга замыг харуулдаг. Эсвэл хүн хүч чадлаасаа давсан бэрхшээлийг туулах хэрэгтэй болдог. Тэрээр өөрийнхөө болон бусад хүмүүсийн ямар ч хүч чадалгүй гэдгийг ухаардаг байна. Зөвхөн Аллах л түүнийг энэ бэрхшээлээс аварч чадна гэдгийг тэр хүн зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэрдэг. Ийнхүү Аллах Өөрийн оршихуйг албатынхаа зүрх сэтгэлд шууд мэдрүүлдэг. Энэ бүхний үр дүнд хэрэв хүн итгэл үнэмшилд хандах юм бол Аллах түүнийг зөв зам руу удирдан чиглүүлэх болно.¹⁴ Хэрэв энэ хүсэлдээ хандахгүй, итгэл үнэмшилгүй амьдралаа үргэлжлүүлбэл тэр хүн зөв зам руу чиглэгдэхгүй. Өөрөөр хэлбэл, үл итгэгчид тэднийг итгэл үнэмшилд хүргэх бүх төрлийн баримт/мэдээллийг дотор болон гаднаас нь тууштай үгүйсгэдэг. Тэд өөрсдийн гартаа атгасан итгэх боломжийг ашигладаггүй. Тэдэнд үнэнийг харуулах нь бараг боломжгүй мэт харагддаг. Өөрөөр хэлбэл, тэд өөрсдийнхөө замыг өөрсдөө сонгосон хэрэг. Түүний сонголтын дагуу тэр хүнд үл итгэх байдал үүсдэг. Энд хэдийгээр Аллахад хамаатай үйлдэл нь төөрөгдөл бий болгох боловч өөрийн хүслээр буруу замыг сонгох нь албатынх юм. Тиймээс тэр албатыг буруу замд оруулахыг Аллах хүсэх нь үнэндээ зүйрлэл юм. Аллах тухайн

14 Мехмет Булут, “Зөв зам, төөрөгдөл ба хүний үүрэг хариуцлага”, 239-р хуу.

хүнийг өөрийн сонгосон төөрөгдлийн замд нь үлдээдэг гэсэн үг.¹⁵

Иймээс Аллах юуны түрүүнд боол сайн муу замыг сонгосны дараа хүссэн хүнээ төөрөлдүүлж, хүссэн хүнээ чиглүүлдэг байна. Хэрэв тийм биш байсан бол Аллах энэ хүнийг зөв зам руу чиглүүлж, энэ нь буруу замд орох болно гэж зарлигдсан бол Аллах Гэгээн элч нар, судар ном илгээх нь утгагүй байх байсан. Гэгээн элч нар ч бас хүмүүсийг зөв зам руу уриалах нь утгагүй болно. Чухамдаа Аллах сайн сайхны замыг сайн дураараа сонгосноор боолоо зөв замд хөтөлж, түүний зүрх сэтгэлийг Исламын шашинд нээж өгдөг. Бузар муу, үл итгэлийн замыг сайн дураараа сонгосон хүнийг төөрөлдүүлэх нь Аллахын шударга ёсны шаардлага юм. Мэдээжийн хэрэг, Аллах ийм хүнд зөв замыг хүчээр бий болгохгүй, зүрх сэтгэлд нь итгэлийг хүчээр суурилуулахгүй юм.¹⁶

Хувь тавилан өөрчлөгдөх үү? Юу ч хийсэн бид мөн адил хувь тавилантайгаа эвлэрч амьдрах уу ?

Кадер буюу хувь тавилан нь Аллахын болгоож товлосныг хэлдэг ба каза буюу хувь тавилангийн биелэлт нь хугацаа нь болоход уг зүйл Аллахын зөвшөөрлөөр биеллээ олох гэж тодорхойлогддог. Бидний Аллах Эзэн хязгааргүй мэдлэгээрээ болсон ба болох бүхнийг мэддэг. Тэр бүхнийг мэддэг байх нь Түүний бурханлаг чанарын шаардлага юм. Хувь

15 Мехмет Булут, “Зөв зам, төөрөгдөл ба хүний үүрэг хариуцлага”, 240-р хуу.

16 Жихат Тунч, “Ислам шашны хувьд зөв зам ба төөрөгдөл”, 39-40-р хуу,

заяаг өөрчлөх гэдэг нь Аллахын мэдлэгийг өөрчлөх гэсэн үг бөгөөд энэ нь боломжгүй юм.

Хувь тавилан өөрчлөгдөж болно гэж үздэг зарим эрдэмтэд садаа өглөг нь зовлон бэрхшээлийг зайлуулж, сила-и Рахим, өөрөөр хэлбэл төрөл төрөгсдийг халамжлах нь насыг уртасгана гэсэн хадисуудыг өөрсдийн үзэл бодлын нотолгоо болгон ашигласан байдаг. Гэсэн хэдий ч, ийм болзолт асуудалд бидний Аллах Эзэн албатуудынхаа хувь заяаг мөнхийн мэдлэгээрээ тэдний хувь тавиланг урьдаас тодорхойлсон аж. Өөрөөр хэлбэл, энэ бүх өөрчлөлтүүд нь бидний Аллах Эзний мэдлэгт байгаа хүний хувь заяанд багтдаг юм. Харин хүн өөрийнхөө хувь заяа юу болохыг мэддэггүй. Тэрээр Аллахын зарлиг, хорио цээрийн дагуу өөрийн хүслээр үйлдэж, үүрэг хариуцлагаа хамгийн сайн гүйцэтгэх үүрэгтэй.¹⁷

Залбирал хувь тавиланд нөлөөлдөг үү?

Залбирал бол Аллахын сүр жавхлангийн өмнө албат өөрийн хүч чадалгүй байдлаа хүлээн зөвшөөрч, Аллах Эзнээсээ тусламж хүсэх явдал юм. Нэг ёсондоо хүн залбирахдаа Аллахад боолчлолоо харуулдаг бөгөөд залбирлынхаа ачаар Аллах Эзнийхээ өмнө боолчлолын дээд зэрэгт хүрдэг.¹⁸ Гэгээн Элч: “Залбирал бол мөргөлийн нэг хэсэг” гэж хэлсэн хадисаас залбирах нь чухал мөргөлийн үйлдэл гэж тооцогддог байна.¹⁹

17 Юсуф Шевки Явуз, “Кадэр”, ДИА, 24-р боть, 58-63-р хуу; <https://kurul.diyaset.gov.tr/Cevap-Ara/26/kader-degisir-mi->

18 Фуркан, 25/77.

19 Тирмизи, Даават, 1.

Тэдний хэрэгцээ, алдаанаас болоод, эсвэл Түүний өгсөн адислалд талархаж байгаагаас үүдэн Аллахыг дурсан санаж, дурсах нь хүмүүст сэтгэл зүйн тайтгарал, амар амгаланг өгдөг.²⁰ Зарим хүмүүс зарим залбирлын үгсийг уншиж, давтан уншсанаар ертөнцийн хүсэл, хэрэгцээ нь шууд биелнэ гэж боддог. Гэвч Гэгээн Элчийн хэлснээр, хүний залбирлыг энэ ертөнцөд хүссэн зүйлээ өгөх, хойд ертөнцөд хойшлуулах, эсвэл түүнээс ирж болох муу муухайг арилгах зэрэг нь хүлээн зөвшөөрөгддөг.²¹

Хүн амьдралд тохиолдох бэрхшээлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авдаг. Гэсэн хэдий ч тэрээр ирээдүйгээ мэдэхгүй тул зарим нөхцөл байдалд өөрийгөө хангалтгүй гэж үзэж, залбирах замаар үүнийг хүлээдэг. Гэвч, Аллахын тушаасан зүйл мөнхөд тохиолдохоос сэргийлэхийн тулд залбирах эсвэл Түүний тогтоолгүй зүйлийг биелүүлэхийн тулд залбирах нь мөргөлийн хүрээнд залбирал гэж үзэх боломжгүй юм.

Болох үйл явдлуудыг Аллах учир шалтгаан үр дагаврын холбоогоор холбодог гэдгийг мартаж болохгүй. Аллах бүх зүйлийг хамарсан мэдлэгээрээ өөрийн албатын юу хийснийг, юу хийхийг мэддэг, мөн түүний үйлдэх залбирлыг мэддэг бөгөөд үүний дагуу хувь заяаг нь тодорхойлдог. Тиймээс хүний залбирал нь Аллахын хүслийн нэг хэсэг болдог. Өөрөөр хэлбэл, хэрэв Аллах залбирлын үр дүнд үүрд мөнхөд өөрчлөлт хийхийг хүссэн бол энэ өөрчлөлт цаг нь ирэхэд гарч ирнэ, хэрэв Тэр хүсээгүй бол биеллээ олохгүй.²²

20 Рагьд, 13/28; Агла, 87/15.

21 Ибн Ханбел, III, 17.

22 Салахаттин Парладир, “Залбирал”, ДИА, 9-р боть, 530-535-р хуу; <https://kurul.diyaset.gov.tr/Cevap-Ara/772/dua-kader-ilis-kisi-nedir-duanin-eceli-degistirdigi-belalari-uzaklastirdigi-so-zu-ne-anlama-gelmektedir>

Тауаккүл ба хувь тавилан хоорондоо юугаараа холбоотой вэ ?

Тауаккүл буюу эрс шийдэмгий, сэтгэл шулуудах гэдэг нь аливаа юманд хүч чадлаа бүрэн дайчилж, чадах ядахаар оролдож, Аллахад найдаж, үр дүнг нь Аллахад даатгах гэсэн үг юм.

Бидний амьдралд тохиолддог бүх үйл явдлууд учир шалтгаан үр дагаврын холбоогоор үргэлжилдэг. Бид их сургуулийн шалгалтад хичээлээ давтахгүйгээр хүссэн үр дүндээ хүрч чадахгүй. Үр тарихгүйгээр бид ургац авч чадахгүй. Бид ажил хийхгүйгээр амьжиргаагаа залгуулж чадахгүй. Бид оюун ухаан, хүсэл зоригороо хариуцлагаа ухамсарлаж, хөдөлмөрлөж, хичээж, үр дүнг нь Аллагаас хүлээдэг. Энэ бол жинхэнэ тауаккүл юм. Урьдчилан сэргийлэх бүх арга хэмжээгээ авсны дараа бидэнд тулгардаг үр дүн бол бидний хувь тавилан юм. Тауаккүл бол бидний хувь заяанд итгэх үр дүн юм.

"Бидний хувь тавиланд юу тохиолдоно түүгээр амьдарна." гэх үзэл бодол урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хүчин чармайлтыг орхиж, Аллахад үлдээх нь итгэл биш, харин залхуурал юм. Энэ бол манай шашны итгэлийн тухай ойлголт биш. Зөв итгэл/зөв тауаккүл нь биднийг хувь заяаны хуурамч итгэлээс хамгаалдаг.

Хүссэн зүйлээ авахын тулд зөвхөн ажиллах нь хангалттай юу ?

Хүн төрөлхтөн амьдралдаа хүссэн зүйлдээ хүрэхийн тулд хөдөлмөрлөж, Аллахад итгэн мэхийх ёстой.

Дэлхий дээр Аллахын тогтоосон тогтолцоо нь хүмүүс орлого олохын тулд хөдөлмөрлөхийг шаарддаг. Гэсэн хэдий ч хүн хийсэн ажлынхаа хариуд зөвхөн Аллах түүнд өгсөн хэмжээгээр л авах боломжтой. Хүн өөрт ноогдох хувиасаа илүүг олох боломжгүй, харин Аллах ч мөн адил хүний хөдөлмөрт хүний өөрөөс нь хамааралтай байлгадаг. Энэ талаар өгч болох хамгийн сайн жишээ бол рызык буюу хувь хишиг юм. Хувь хишгийг бүтээх ба өгөх нь бүхэлдээ Аллахад хамаатай. Харин халал аргаар идэж уух хэрэглэх бүхий л зүйлийг олох нь албатын үүрэг юм. Албат ажиллаж байхдаа Аллах өөрт нь хэчнээн их хувь хишиг өгснийг мэдэхгүй, зөвхөн үүрэг хариуцлагаа биелүүлдэг. Гэрлэх, ажил олох, шалгалтад бэлтгэх гэх мэт энэ нь амьдралын бусад салбарт ч мөн адил юм. Бид Аллахын өгсөн боломжуудыг ашигласнаар ялах хүслээ урагшлуулдаг бөгөөд Аллах бидэнд хүссэн хэмжээгээрээ өгдөг. Мэдээжийн хэрэг, аман залбирлыг ч үл хайхарч болохгүй.

Хайхрамжгүй байдал ба хувь тавилан хоёрын хооронд ямар холбоо байдаг вэ? Зам тээврийн осол, газар хөдлөлт гэх мэт үйл явдлын тухай түүний хувь тавилантай холбоотой гэдгийг бид хэрхэн тайлбарлах вэ ?

Хүмүүс өөрсдийн хүсэл зоригоор хийхийг хүсдэг үйлдлүүдийг Аллах бүтээдэг. Аллах бол Бүтээгч гэдэг нь муу болон буруу үйлсийг Түүнд хамааруулж болно гэсэн үг биш юм. Энэ нь хувь заяанд итгэх итгэлийг урвуулан ашигласан хэрэг болно. Түүнчлэн

хувь заяанд итгэж, ажлаа зогсоох, шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахгүй байх, хайхрамжгүй хандах нь Исламын хувь заяаны тухай ойлголттой нийцэхгүй. Хүн хувь заяаг шалтаг тоочоод хариуцлагаас мултарч чадахгүй. Бидний Аллах Эзэн бүх зүйлийг тодорхой шалтгаантай холбодог. Хэрэв хүн эдгээр шалтгааныг биелүүлбэл Аллах эдгээр шалтгаануудын үр дүнг бүтээдэг. Аллах үүрэг хариуцлагыг өгсөн тохиолдолд албатад өөрийн гэсэн хүсэх эрх чөлөө нь байдаг. Иймд хүн хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ гэдгээ мэдэж байх ёстой.²³

Аллах, *"Газар дэлхийд буй болсон, өөрсдөд чинь тохиосон гай зовлонгууд Бид бүтээхээс аль эрт Лаухул махфуз сударт бичигдсэн болой. Энэ нь Аллахад хялбар байх нь маргаангүй шүү дээ."*²⁴ ийнхүү айлдав. Өнгөрсөнд болсон ба ирээдүйд тохиолдох бүх зүйл Аллахын мөнхийн мэдлэгт оршдог. Хүн хувь заяагаа мэддэггүй болохоор элдэв гай зовлон, гай гамшгаас болгоомжлох ёстой. Учир нь тэр өөрийн хүсэл, сонголтод үлдсэн зан үйлийн төлөө хариуцлага хүлээх болно гэдгийг мэддэг. Түүнд ямар нэгэн муу юм тохиолдоход өөрийн хувь нэмрийг бодож, түүнийхээ дагуу ирээдүйн үйлдлээ тодорхойлдог. Тэр тэрслэхгүйгээр, албатынхаа үүргийг биелүүлэх ба Аллах Эзэндээ бүрэн захирагдаж байгаагаа харуулдаг.

Гай зовлон, уй гашууг гурван ерөнхий бүлэгт ангилж болно:

23 <https://kurul.diyaset.gov.tr/Cevap-Ara/28/-allah-boyle-yazmis--ben-ne-yapayim---demek-dogru-mudur->.

24 Хадид, 57/22.

Эхнийх нь байгалийн гамшиг, тахир дутуу төрөх гэх мэт хүний хүслээр үл хамаарах гай зовлон, гамшиг юм. Эдгээрт боол ямар ч хариуцлага хүлээхгүй. Тэр хувь заяанд итгэдэг, Аллах өөрийг нь сорьдог гэдгийг мэддэг, өөрт тохиолдсон зүйлд тэвчээртэй ханддаг учраас асар их шагнал хүртэх болно.

Хоёр дахь нь зам тээврийн осолд буруутай (хагас) гэх мэт хүний хүсэл зориг хэсэгчлэн орсон үйлдэл юм. Эдгээрийг тухайн хүн өөрийн буруутай хэмжээгээр хариуцна.

Гурав дахь нь хүний шууд хүсэл хамаардаг гай зовлон, гай гамшиг. Улаан гэрэл асах үед зам гарах, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаагүй ажилчин ажиллуулах, газар хөдлөлтөд тэсвэргүй барилга барих, эрүүл мэндэд нь аюул учруулах зэрэг амь нас, эд хөрөнгөд хохирол учруулсан хүмүүст хариуцлага тооцогддог.²⁵

Гэрлэлт хувь тавилан уу ?

Төгс Хүчит Аллах бүхнийг мэддэг шиг хүмүүсийн хэнтэй гэрлэхийг ч мэддэг. Энэ утгаараа гэрлэлт бол мэдээж хувь тавилан юм. Гэсэн хэдий ч Төгс Хүчит Аллахын тухай энэхүү мэдлэг нь хүнд хүчтэй нөлөө үзүүлдэггүй. Аллах хүмүүст хань ижлээ сонгох хязгаарлагдмал боломжийг олгодог. Энэ утгаараа гэрлэлт нь тухайн хүний хүсэл зоригтой холбоотой бөгөөд хүсэл зориг байгаа газар тухайн хүний үүрэг

25 <https://kurul.diyamet.gov.tr/Cevap-Ara/27/bela-ve-musibetler-ka-der-midir>

хариуцлага бас бий. Тиймээс хүн гэрлэлтийн талаар хийсэн буруу сонголтынхоо хариуцлагыг “Энэ бол миний хувь тавилан, би яах ёстой вэ” гэж Аллахыг буруутгах эрх байхгүй.

Бид генийн согогоос болж өвддөг нь хувь тавилан уу ?

Хувь тавилан гэдэг шашны хэллэгийн хувьд мөнхөөс үүрд мөнхөд болсон, болж байгаа, болох бүхий л зүйлийн цаг хугацаа, газар нутаг, шинж тэмдэг, шинж чанарыг бидний Аллах Эзэн мэдэж, тодорхойлж, өөрийн мэдлэгээр үнэлж дүгнэх явдал юм. Хэрэв бид энэ асуултыг Аллах эзэн энэ хэлбэрээр нь зохимжтой гэж, ийм байдлаар бүтээж байгаа талаас нь асууж байгаа бол тийм ээ, хүн төрөлхтөн гений эмгэгтэй төрөх нь хувь тавилан, өөрөөр хэлбэл Аллахын таалал юм.

Гэхдээ асуултад дурдсанчлан, удамшлын эмгэг/өвчин бол хувь тавилан гэдэг нь бидний хариуцлага, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээний эрэл хайгуулыг арилгадаггүй. Цөөн хэдэн жишээ дурдахад хамаатан садны гэрлэлт нь удамшлын олон өвчнийг үүсгэх чухал хүчин зүйл болдог. Нөгөөтээгүүр, удамшлын зарим өвчнийг эрт илрүүлэг, оношлох, хэсэгчлэн эмчлэхэд жирэмсэн үед хийсэн зарим шинжилгээ маш чухал байдаг. Түүнчлэн тамхи, архи зэрэг бодисыг хэрэглэх нь удамшлын өвчин үүсэхэд шууд нөлөөлдөг. Энэ бүхнийг тооцож үзэхэд бидний үүрэг бол чадах бүхнээ хийх явдал юм. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, шаардлагатай эмчилгээний процессыг

дагаж, эцэст нь бидний хувь заяанд, Аллахын хүсэлд бууж өгч, захирагдахыг хэлнэ. Тэгэхгүй бол бид хариуцлага үүрэх болно.

Хөгжлийн бэрхшээлтэй ? төрсөн нь шударга бус уу ?

Исламын шашны итгэл үнэмшлийн дагуу энэ амьдрал бол мөнх амьдралыг олж авах эсвэл алдах "богино, түр зуурын, хязгаарлагдмал" амьдрал юм. Бүх илчлэлдүүт нь бидний үнэн ба бодит амьдрал энэ ертөнц дэх бидний сорилтуудын үр дүнгийн дагуу хойд насандаа тодорхойлогдох болно гэдгийг сануулж, Гэгээн элч нар энэ үнэнийг хүмүүст хүргэдэг.

Энэ амьдралд илгээгдэх зорилго нь шалгалтад хамрагдах хүн өөрт нь тогтоосон шалгалтын арга замыг сонгох эрхгүй. Сурагч шалгалт өгөхөөсөө өмнө шалгалтын асуултаа өөрөө тодорхойлох эрхгүйтэй адил. *"Бид та нарыг бага зэрэг айлгаж, өлсгөж, мөн амь нас, мал хөрөнгө, ажил үйлсийг чинь доройтуулж шалгана. (Аяа, Мухаммед) тэвчээр хүлцэлтэй хүмүүсийг баярлуулаарай."* гэсэн айлдвараас²⁶ бид энэ ертөнцөд шалгагдаж байгаа сорилууд нь бие биеэсээ өөр гэдгийг мэдэж авдаг. Энэ төрлийн сорилтуудын нэг нь хөгжлийн бэрхшээл юм. Амьдралаа зөвхөн өөрийнхөө амьдрал гэж хардаггүй, ертөнцийг хойд насны талбар гэж хүлээн зөвшөөрдөг хүн үүнийг шударга бус явдал гэж боддоггүй, харин хэцүү санагдсан ч тэрээр хөгжлийн бэрхшээлийнхээ улмаас зовж шаналж, бэрхшээлтэй тулгарсан ч

.....
26 Бакара, 2/155.

жинхэнэ, мөнхийн амьдралдаа шагналаа авах болно гэдгийг мэддэг учраас бүгдийг хүлээн зөвшөөрдөг байна. Үүнээс гадна, шударга бус байдал нь "хариун өгөгдөөгүй эрх" байгаа бол энэ хариу нь жинхэнэ авч үзэх ёстой асуудал гэсэн үг юм. Хэрэв бид эрүүл саруул төрөхийн төлөө төлбөр төлдөг байсан бол хөгжлийн бэрхшээлтэй төрсөн нь шударга бус хэрэг болно.

Аллахад итгэдэг, найддаг хүний хувьд тахир дутуу төрөх нь хөгжлийн бэрхшээлтэй хүн болон түүний ойр дотнын хүмүүс аль алинд нь сорилт болдог. Аллахад болон Түүний хязгааргүй нигүүлсэлд итгэдэг хүн хөгжлийн бэрхшээлтэй гэдгээ мэддэг бөгөөд энэ хорвоод сорилттой гэдгээ ухаарч, тэрслэхгүй, зөв сэтгэл хөдлөл, зан авир гаргаж, хөгжлийн бэрхшээлдээ анхаарахгүй, өөрт байгаа бусад чадвараа ухаарч чадвал шударга бус, бузар муу гэж үзэж буй энэ байдлыг сайн ба боломж руу эргүүлж чадна. Нэмж дурдахад бидний амьдралд тохиолдож буй саад бэрхшээлүүд нь биднийг шагнал хүртэхэд хөтөлж, нүглүүдийг маань өршөөж, тэвчээртэй байвал оюун санааны тогтвортой байдлыг нэмэгдүүлэхэд хүргэдэг.

Анагаах ухаан үхэшгүй мөнх амьдралыг олж чадах уу ?

Куран сударт "Амьд бүхэн үхлийг амсах болно."²⁷ гэж Аллах Эзэн айлдсан байдаг. Анхны хүн ба шайтан хоёрын харилцан ярианд үхэшгүй мөнхийн тухай дурдагддаг бөгөөд энэ бол түүний Адамыг

.....
²⁷ Али Имран, 3/185.

төөрөгдөлд оруулах гэсэн санал юм.²⁸ Түүхийн эхэн үеэс хүн төрөлхтөн энэ дэлхийд удаан хугацаагаар оршин тогтнох/амьдрах эрэл хайгуулаа үргэлжлүүлсээр ирсэн. Египетийн соёл иргэншлээр дамжуулан бидний мэддэг мумижуулалт, өнөөгийн шинжлэх ухаан, технологийн хөгжил нь энэхүү эрэл хайгуулын тусгалын хамгийн түгээмэл жишээ юм. Гэсэн хэдий ч мэдэгдэж байгаагаар энэ зорилгоо өнөөг хүртэл биелүүлээгүй байна. Үүнээс хойш бас боломжгүй болно. Учир нь ертөнц өөрөө хязгаарлагдмал (түр зуурын) хэдий ч энэ хязгаарлагдмал дарааллаар хязгаарлагдмал хугацаанд оршдог хүн төрөлхтөн үхэшгүй мөнх байдлыг олж мэдрэх нь оюун санааны хувьд тогтворгүй бөгөөд боломжгүй юм. Гэсэн хэдий ч энэ ертөнцийн дараах амьдрал бол (ахирет) тэнд бид үхэшгүй мөнх амьдрах болно.

Сахиус, шившлэг гэх мэт зүйлс хувь заяанд нөлөөлдөг үү?

Хувь тавилан гэдэг нь "Бүхнийг чадагч Аллах Өөрийн мэдлэгээр бүх зүйл, үйл явдлыг мэддэг бөгөөд тогтоодог" гэсэн утгатай. Сахиус, шившлэг гэх мэт аливаа зүйл эсвэл өөр ямар нэгэн зүйл Аллахын мэдлэгийг өөрчлөх эсвэл нөлөөлөх боломжгүй юм. Манай шашинд ямар ч шалтгаанаар ийм зүйл хийхийг хатуу хориглодог.

Исламд аз, азгүйдэл, золгүй явдал гэж байдаг уу?

Исламын шашин гарч ирэх үед жахилие арабчуудын дунд азгүйдлийн итгэл үнэмшил чухал байр суурь эзэлдэг байв. Төрөл бүрийн амьтад, эд зүйл, амьтан, цаг хугацааг тухайн үеийн хүмүүс азгүйд тооцдог байсан бөгөөд эдгээр итгэл үнэмшлийг нийгмийн бараг бүх давхарга хүлээн зөвшөөрдөг байв. Тиймээс азгүйд тооцогдох зүйлд гүнээ санаа зовж, санаа зовсон нийгэм байсан. Исламын шашин гарч ирсэн нийгэмд тогтсон азгүйдлийн энэхүү итгэл үнэмшлийг хоосон төөрөгдөл, ор үндэсгүй мухар сүсэг гэж дүрсэлж, хүмүүсийг ийм бодлоос холдуулахыг оролдсон. Гэгээн элч (с.а.у.) аливаа зүйлд азгүйдэл гэж байдаггүй²⁹ бөгөөд азгүйдэлд итгэх нь олон бурхант үзэл мөн³⁰ гэж хэлсэн байдаг. Арабчуудын азгүйд тооцогдох эд зүйлсийн талаар “Аливаа зүйлд азгүйдэл гэж байдаггүй, Сафар сард азгүйдэл байдаггүй, Шар шувуу өтөхөд азгүйдэл байдаггүй.”³¹ гэх зэргээр ийм итгэл үнэмшил нь мухар сүсэг гэдгийг онцолж байв.

Аз ба золгүй явдлын тухай ойлголт нь Исламын хувь заяаны итгэл үнэмшилтэй нийцдэггүй. Хүний аз гэж нэрлэдэг зүйл нь түүний төлөөх Аллахын хүслээс өөр юу ч биш юм. “Бидэнд зөвхөн Аллахаас заяадаг хувь тавилан оногдоно. Аллах бидний Эзэн мөн. Сүсэгтнүүд Түүнд итгэцгээх болтугай.”³²

29 Бухари, Тыб, 19.

30 Ебу Давуд, Тыб, 24.

31 Мүслим, Салам, 102.

32 Тауба, 9/51.

Хүн аз, золгүй явдал гэж үзсэн зүйлдээ Аллахын хүч чадал, хүслийг олж харж чаддаггүй, тэгээд тэр зүйлийг аз гэж боддог. Элч Юсуфыг ах дүү нар нь худаг руу орхиж, худгаас гарсны дараа Египетэд боол болгон худалдсан нь золгүй явдал мөн үү? Египетийн нэр төртэй хүмүүсийн нэг нь түүнийг худалдаж аваад өсгөж, улмаар Египетэд чухал албан тушаалд очсон нь тохиолдол мөн үү?

"Аллах өөрийнхөө зорьсон үйл хэрэгт үнэнхүү хүчирхэг."³³ Түүний ах дүүс Хз. Юсуфд атаархаж байв. Гэсэн хэдий ч тэдний хийсэн зүйл Аллахын элч Юсуфын тухай зарлигийг хориглож чадаагүй юм. Элч Юсуф ах нарынхаа өмнө хүчирхэг их сайд болж гарч ирэхдээ *"Аллах бидэнд хайр энэрлээ үзүүлсэн."*³⁴ гэсэн үгээр Аллахад үнэнч байж, итгэж байгаагаа илэрхийлж, Тэрээр Аллахын шийдвэрт сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэв. "Юсуф" бүлгийг анхааралтай уншвал үйл явдлын ард аз, азгүйдэл гэж байдаггүй, харин Аллахын хүч, хүсэл зориг байдаг нь тодорхой харагдана.

Үхэл гэж юу вэ? Бидний хийж байгаа зүйлээс болж амьдрал уртсаж, богиносдог уу?

Үхэл гэдэг нь "Аллахын зүгээс амьд амьтан бүрийн урьдчилан тогтоосон амьдралын хугацаа ба үхлийн цаг буюу энэ хугацааны төгсгөл" гэсэн утгатай.³⁵ Аллах бол хүмүүсийг бүтээж, буян хишгээ өгдөг шиг

33 Юсуф, 12/21.

34 Юсуф, 12/90.

35 Жихат Тунч, "Ажал", ДИА, 10-р боть, 380-382-р хуу.

үхэх цагийг нь (ажал) тогтоон амийг нь авдаг юм. Хүн ба нийгэм болгонд ажал буюу үхэх цаг нь байдаг бөгөөд энэ нь цаг хугацаанаасаа өмнө ирдэггүй бас хоцрогддоггүй болно. Ариун Куран сударт Аллах Та энэ талаар дараах зүйлийг хэлсэн: *"Зон олон бүрд заяагдсан (үхлийн) цаг хугацаа бий. Тэрхүү цаг хугацаа нь ирэхүйд ганц хормоор ч хойшлуулж, урагшлуулж үл чадмуй. Аллах та нарын юу хийж байгааг бүрэн мэддэг."*³⁶ *"Үндэстэн бүр өөрийн гэсэн ажал (товлогдсон үхлийн мөч) байдаг. Тэр мөчид ганц ч хором хойшлуулах, ганц ч хором урагшлуулах боломжгүй юм."*³⁷


Бидний дээр дурдсан эшлэлүүд товлогдсон үхлийн мөч өөрчлөгдөхгүй гэдгийг тодорхой өгүүлдэг. Тэгвэл садака өглөг өгөх, хамаатан саднын харилцаагаа сайжруулах зэрэг зарим буян үйлдэх нь нас уртасгах талаар ямар утга учиртай байдаг вэ? Амьдралыг уртасгана гэдэг нь үр бүтээлтэй, чанартай амьдрах гэж ойлгож болно. Нөгөөтээгүүр, Аллах эдгээр албатуудынхаа зан авирыг урьдчилан мэддэг учраас тэдний насыг уртасгаж магадгүй юм. Эцсийн эцэст, Аллахын тогтоосон амьдралын үргэлжлэх хугацааг өөрчлөх боломжгүй юм.³⁸

.....
36 Мүнафикун, 63/11.

37 Аграф, 7/34. Мөн үзнэ үү. Юнус, 10/49.

38 Фатих Курт, "Ехл-и Сүннагийн хувьд ажал", *Гумушанэ их сургуулийн теологийн факультет сэтгүүл*, 2019, боть: VIII, тоо: 15, 116-131-р хуу.

**ШАШНААСГАРГАХАД
ХҮРГЭДЭГ
ҮГС**



Бидний хэлж буй үгс шашнаас гарахад хүргэдэг шалтгаан болох уу ?

Исламын шашны чухал хэсэг болох итгэл үнэмшлийн үндсэн зарчмуудын (Аллах, сахиусан тэнгэр, ном судар, гэгээн элч нар, хойд нас, хувь заяанд итгэх итгэл) нэгийг нь ч үгүйсгэж, Аллахыг бусад зүйлстэй жиших, Түүнийг Эцэг хэмээн түүнд үл тохирох шинж чанараар дүрслэх, Аллахын оршихуйг үгүйсгэх, харамч гэж хэлэх, Түүнээс өөр бурханд залбиран гуйх, Аллахын шинж чанар, түүний ариун нэрсээр тохуурхах, Гэгээн элч нарыг бурхдын зэрэгт өргөх зэрэг Түүний нэр төрд үл нийцэх эсрэгээр нь тэднийг шоолох, сахиусан тэнгэрүүдийг элэглэн тохуурхах - ялангуяа Азрайл (а.с.)-ын тухай ёжтой үг хэллэг манай нийгэмд байнга гардаг - эсвэл тэднийг доромжлох, Ариун Куран судрын ганцхан эшлэлийг ч үгүйсгэх, тэднийг шоолох, няцаах, эшлэлийг өөрчлөх, хойд төрөлд итгэх нь ахирет ертөнцөд итгэхийг үгүйсгэдэг учраас хүнийг ислам шашны хүрээнээс холдуулдаг.¹ Эдгээрээс гадна нэг, цөөхөн эсвэл бүгдийг нь үгүйсгэх, дутуу үнэлэх, үл тоомсорлох, дургүйцэх, тохуурхах нь тодорхой нотлох баримтаар фарз, харам гэж мэдэгдэж байгаа асуудлууд, эсвэл фарз/ харам зүйлсийг шоолох нь хүнийг шашнаасаа гарахад хүргэдэг. Эдгээр утгуудыг илэрхийлдэг үгсийг шашнаас гарах санаатай биш, харин **чин**

1 Ахмет Саим Кылавуз, *Итгэл үнэмшил ба доромжлолын хязгаар*, 106-130-р хуу.

сэтгэлээсээ итгэн тодорхой илэрхийлсэн хүн
Ислам шашнаас гардаг байна.

Хүнийг шашин шүтлэгээс гаргахад хүргэдэг үгсийг дараах байдлаар жишээг өгч болно: *"Би чамд Аллахаас илүү хайртай", "Аллах ирвэл тэр чамайг надаас холдуулж чадахгүй", "Энэ үед мөргөл залбирал хийх гэж үү, бид хэдэн онд амьдарч байгаа билээ", "намаз мөргөл бол дасгал, бидэнд залбирал хэрэггүй", "Аллах бидний хийдэг зүйлд хөндлөнгөөс оролцож болохгүй", "Миний шейх багш гэгээн элчээс илүү юм"* гэх мэт.

Хэдийгээр итгэл үнэмшил бол зүрх сэтгэлийн асуудал ч итгэлийг илэрхийлэх, хүнийг итгэгч гэж хүлээн зөвшөөрөхөд үгээр илэрхийлэх нь чухал үүрэгтэй. Нэгэнт зүрх сэтгэл итгэсэн бол хэл хүссэнээ хэлж чадахгүй. Бидний үгс бидний зүрх сэтгэл дэх итгэлтэй зөрчилдөж чадахгүй. Мусульманчууд, дээр дурдсан шиг итгэл үнэмшилд сөргөөр нөлөөлж болзошгүй үг хэллэг, зан үйлээс хол байх талаар мэддэг байх ёстой. Тэр тусмаа Ислам шашны ариун гэж үздэг элементүүдийг үг яриандаа ёжтойгоор оруулах нь тэвчиж болох асуудал биш юм. Хүн өөрийн итгэл үнэмшлийг алдагдуулах үг хэлсний дараа тэр даруй наманчилж, Калима Шахадатыг унших ёстой.

**Мусульман хүнд амны зуршлаар
"Аллахгүй, номгүй" гэж хэлдэг ?
хүний байдал нь юу болдог вэ ?**

Мусульманчуудын бие биеэ итгэл үнэмшилгүй хэмээн буруутгаж байгаа тухай манай Гэгээн элч (с.а.у.)-ын зарим үгс дараах байдалтай байна.

"Хэн нэг хүнийг үл итгэгч гэж дуудвал эсвэл тийм биш ч гэсэн "Аяа Аллахын дайсан" гэж хэлбэл түүний үгс өөрт нь эргэж ирнэ."²

"Мүмин хүнийг хараах нь түүнийг алахтай адил юм. "Хэн нэг Мүминийг үл итгэгч гэж буруутгавал түүнийг алсантай адил болно."³

"Нэг хүн мусульман ахан дүүстээ хандан "Аяа үл итгэгч" гэж хэлэх үед тэдний аль нэг нь энэ үгийг өөрийнх мэт хүлээн авах болно. Хэрэв энэ нь түүний хэлснээр бол үл итгэгч гэх нь түүнд үлддэг, үгүй бол хэлсэн хүнд нь буцдаг."⁴

Бидний Гэгээн элч (с.а.у.)- ийн эдгээр сэрэмжлүүлгийг авч үзвэл Мусульман гэдгээрээ танигддаг хэн нэгнийг мусульман биш гэж хэлэх нь буруу юм. Мусульман хүнийг "Аллахгүй", "Номгүй" гэх мэтээр хэлэх нь, дуудах нь түүнд хэлж болох хамгийн хатуу үгсийн нэг юм. Ийм учраас Мусульман хүн эдгээр болон түүнтэй төстэй үгсийг үг хэллэгээсээ бүр мөсөн өөрөөсөө холдуулах хэрэгтэй. Хэдийгээр энэ нь ерөнхий дүрэм боловч хэл ярианы дадал зуршил, хэл нь халтирах, үг нь хаашаа явж байгааг мэдэхгүй байх, ухаангүй байх гэх мэт "Аллахгүй" гэж ямар ч шалтгаангүйгээр, нөгөө хүн нь үл итгэгч гэсэн утгагүйгээр хэлэх нь хүнийг Исламын хүрээнээс гаргахгүй. Гэхдээ ийм үг хэрэглэхээс болгоомжилж, зуршил болгохгүй байхыг анхаарах хэрэгтэй.

2 Мүслим, Иман, 112.

3 Бухари, Ейман, 7; Тирмизи, Иман, 16.

4 Мүслим, Иман, 111.

Египетийн домог зүйд оршихуйг дүрслэхдээ "Египетийн бурхан" ? гэж хэлэх нь ширк мөн үү

Ширк гэдэг нь "Орчлон ертөнцийг бүтээж, захирдаг шүтээнээс өөр бурхдад өөр шүтээнд итгэдэг гэсэн утгатай.⁵ Исламын шашин нь Аллахыг мөн чанар, шинж чанар, үйлдлээрээ нэг, цор ганц гэсэн зарчимд тулгуурладаг тул Аллахад хамаарах ямар ч шинж чанар, үйлдэл байж болохгүй. Ийм учраас итгэгч хүн Египетийн бурхан, тэнгэрийн бурхан, газрын бурхан, гоо үзэсгэлэнгийн бурхан гэх мэт харь шашны итгэл үнэмшилтэй холбоотой хэллэг хэрэглэх нь зохисгүй юм. Хэдийгээр энэ нь үндсэн зарчим боловч олон бурхант шашинтнууд бурхад гэж тодорхойлсон оршихуйнуудыг ойлгуулахдаа, жишээлбэл, "Египетийн бурхан" гэсэн хэллэг нь "Эртний Египетэд бурхад гэж хүлээн зөвшөөрөгдсөн" гэсэн утгатай бол үүнийг ширк-ийн хүрээнд авч үзэх боломжгүй юм. Учир нь ширк бол хүний ухамсартайгаар, өөрийн гэсэн бодол санаагаар хийсэн сонголт юм. Уг мэдэгдэлд ширкийн үзэл бодол, санаа зорилго байхгүй билээ. Гэсэн хэдий ч дээр дурдсанчлан итгэгчид эдгээр болон үүнтэй төстэй хэллэгийг ямар ч эсэргүүцэлгүйгээр ашиглах нь таухидад итгэх итгэлийг бууруулж, цаг хугацааны явцад үл ойлголцол үүсгэж болзошгүй юм. Тиймээс эдгээр болон ижил төстэй хэллэгийг ашиглах нь зөв биш юм.

5 Мустафа Синаноглу, "Ширк", ДИА, 39-р боть, 193-198-р хуу.

Хэрэв бид Алладын шинж чанар болох бүтээгч сэтгэлгээг өөр хэн нэгэнд зориулж ашиглавал, тухайн хүний тухай "маш бүтээлч" гэвэл бидний итгэл эвдрэх үү ?

Бүгдийг бүтээж, бүх зүйлийг оргүй хоосноос бүтээгч нь Аллах юм. Үүнийг мэдсээр байж "бүтээгч" гэдэг үгийг хэлчхээд л юмны хэлбэрийг өөрчлөх, нээх гэдэг утгаар нь хэлэхэд хүнийг шашнаас холдуулахгүй. Куран сударт: *"...Агуу Аллах бол хамгийн агуу бүтээгч мөн."*⁶ хэмээн айлдсан байдаг. Араб хэлэнд "халк"/бүтээх гэдэг үг нь хүнийг аливаа зүйлийг хийх, үйлдвэрлэх гэсэн утгаар нь хэлдэг байсан. Гэвч цаг хугацаа өнгөрөхөд энэ нь Уг ойлголтыг зөвхөн Аллахад хэрэглэгддэг байсан бөгөөд Түүнээс өөр хэнийг ч "бүтээгч" гэж дуудах нь итгэл үнэмшлийн ёсонд харш гэж үздэг.⁷

Куран судрын зарим заалтыг өнгөрсөнд үлдсэн гэж дутуу үнэлдэг хүний итгэл эвдэрнэ гэж үү ?

Куран сударт иудейчүүд судар номоо сольж, заалтаа хэрэгжүүлдэггүй тухай байнга дурдсан байдаг. Еврейчүүд Тауратын зарим заалтыг хэрэгжүүлдэггүй ч зарим заалтыг хэрэглэдэг байсан. Энэ асуудлыг бидэнд хүргэж буй Куран сударт тэдний хандлагыг дараах байдлаар шүүмжилжээ: *"Та нар Таурат (Тора) номынхоо зарим хэсэгт нь итгэж, зарим хэсгийг нь үгүйсгэдэг юм уу? Ер нь та нарын ийнхүү үйлдлийн*

6 Мүминун, 23/14.

7 Куран судрын арга зам, 4-р боть, 13-15-р хуу.

гэсгээл нь энэ яваа насандаа зовж зүдрэн, хойд насандаа шившигтэйгээр гэсгээлд нэрвэгдэх явдал мөн. Учир нь Аллах та нарын хийсэн үйлийг мэдэж байгаа."⁸

Зөвхөн энэ эшлэл ч гэсэн бидний асуултад хангалттай хариулт болж магадгүй юм. Учир нь итгэл үнэмшил бол хуваагдашгүй нэгэн бүхэл юм. Өөрөөр хэлбэл, итгэх ёстой бүх зүйлд итгэх хэрэгтэй. Ганц асуудлыг үгүйсгэх нь хүнийг итгэлийн хүрээнээс гадагш гаргадаг. Тухайн хүн Куран судар дахь зарим заалтыг өнгөрсөнд үлдсэн гэж дутуу үнэлж, өнөөдөр хэрэглэх боломжгүй гэж хэлээд орхиж байгаа нь эшлэлд шүүмжлэгдсэн хандлагатай яг таарч байна. Иймд заавал итгэх ёстой асуудлын өчүүхэн хэсгийг ч үгүйсгэх нь тэр асуудалд итгэх итгэл биелээгүйг харуулж байна.⁹

Номонд итгэж, түүнийг амьдралдаа авч явах, түүний зааварчилгаа дор амьдралын замаа үргэлжлүүлэх нь түүний заалтуудыг бүрэн хэрэгжүүлж, биелүүлснээр боломжтой юм. Гэгээн Элч маань энэ асуудлыг "Куран судрын харамуудыг халал гэж үздэг хүн үүнд итгэн үнэмшээгүй"¹⁰ гэж хэлсэн байдаг.¹¹

8 Бакара, 2/85.

9 Ахмет Давутоглу, "Иман бол бүрэн бүтэн юм", *Исламын институт сэтгүүл*, Истанбул, 1964, тоо: 2, 6-р хуу.

10 Тирмизи, Фазаилул-Куран, 20.

11 *Хадисуудаар Ислам*, 1-р боть, 548-р хуу.

Агуулга нь Исламын шашинтай нийцэхгүй дуу сонсох нь бидний итгэлд сэргөөр нөлөөлж байна уу ?

Аллахын боол байх нэр төрийг хүртсэн итгэгч хүн Түүнд залбирахдаа мэдлэгтэй, болгоомжтой байх нь зохистой. Тиймээс хараалын үг, тэрслүү үг агуулсан дууг сонсохыг хориглосон аж.

Манай шашны эх сурвалж болох Куран судар, Суннад хөгжмийн талаар нарийвчилсан бөгөөд тусгай заалт байдаггүй. Хөгжим тоглох, сонсох нь гарцаагүй нүгэл гэдгийг нотлох баримт байхгүй билээ. Исламын шашин нь энэ талаар ерөнхий зарчим, зорилтуудыг тодорхой илэрхийлсэн байдаг. Иймээс Ислам шашны зарчмын эсрэг, хүмүүсийг Аллахыг эсэргүүцэхэд уриалсан, нүгэл үйлдэхэд чиглүүлсэн, бослого, эсэргүүцлийн соёлыг бий болгох зорилготой, илэрхийлэл, бэлгийн дур хүслийг өдөөж, хүмүүсийг харам үйлдэлд уриалсан дуу бичих, сонсох нь нүгэл юм. Аллахыг эсэргүүцсэн, хувь тавиланг доромжилж, нүгэл, харам үйлдлүүдийг хүлээн зөвшөөрөхгүйгээр зүгээр л дуу сонсдог хүн нүгэлтэн болдог ба наманчлах (тауба) ёстой.¹²

.....
12 <https://kurul.diyamet.gov.tr./Cevap ara/-muzigin dindeki yeri->

